

**“ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ТУХАЙ ХУУЛЬ”-ИЙН
ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ҮР ДАГАВРЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

УЛААНБААТАР

2025 он

Гарчиг

I. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ.....	3
A. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох.....	4
B. Үнэлгээ хийх хүрээг тогтоох.....	8
C. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох.....	23
D. Харьцуулах хэлбэрийг сонгох.....	24
E. Шалгуур үзүүлэлтийг томъёолох.....	25
F. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох.....	27
II. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ.....	28
III. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ.....	30
Нэгдүгээр бүлэг. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн зорилт, үйлчлэх хүрээ.....	30
Хоёрдугаар бүлэг. Төрийн болон орон нутгийн өмчийн ангилал.....	36
Гуравдугаар бүлэг. Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлага.....	50
Дөрөвдүгээр бүлэг. Төрийн болон орон нутгийн өмчийн эзэмшигчийн ангилал	61
Тавдугаар бүлэг. Төрийн болон орон нутгийн өмчид хөрөнгө олж авах, захиран зарцуулах.....	67
Зургаадугаар бүлэг. Төрийн болон орон нутгийн өмчийг захиран зарцуулах арга.....	70
Долоодугаар бүлэг. Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, тооллого.....	75
Наймдугаар бүлэг. Төрийн болон орон нутгийн өмчийн хяналт.....	78
Есдүгээр бүлэг. Төрийн болон орон нутгийн өмчийн тайлагнал ба мэдээллийн сан	81
ДҮГНЭЛТ.....	84
Хавсралт 1. Шүүхийн шийдвэрийн тоон судалгаа.....	86

Товчилсон үгс

ТБОНӨТХ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль

ЗЗНДНТУТХ Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдагын тухай хууль

МУИХХШТХ Монгол улсын их хурлын хяналтын шалгалтын тухай хууль

ЗГТХ Засгийн газрын тухай хууль

УИХ Улсын Их хурал

ИТХ Иргэдийн Төлөөлөгчдийн хурал

ТӨБЗГ Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

ТӨХ Төрийн өмчийн хороо

ЖДҮ Жижиг дунд үйлдвэрлэл

ТББ Төрийн бус байгууллага

ААН Аж ахуйн нэгж

ХК Хувьцаат компани

ХХК Хязгаарлагдмал хариуцлагатай компани

ТӨХЭ Төрийн өмчит хуулийн этгээд

ТӨК Төрийн өмчит компани

ТӨҮГ Төрийн өмчит үйлдвэрийн газар

ААТҮГ Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар

УТҮГ Улсын төсөвт үйлдвэрийн газар

ТУЗ Төлөөлөн удирдах зөвлөл

УЗ Удирдах зөвлөл

I. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

A. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын Зургаадугаар хавсралт Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалын 3.2-т “дараах нөхцөл байдал үүссэн тохиолдолд хууль тогтоомжийн хэрэгжилтэд үнэлгээ хийж болно” гэжээ. Өнөөгийн ТБОНӨТХ-ийн хэрэгжилтийн хүрээнд Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалын 3.2.1, 3.2.2, 3.3.3-т заасан нөхцөл байдал үүссэн хэмээн дүгнэж болохоор байна.

3.2.1.тухайн хууль тогтоомжийг шүүхийн практикт хэрэглэн хэрэг, маргааныг шийдвэрлэхэд хүндрэл, бэрхшээл гарах, ойлгомжгүй, зөрчилтэй зохицуулалттай байх, тэдгээр нь цаашид тухайн харилцаанд сөрөг үр дагавар үүсгэх шинжтэй байвал;

ТБОНӨТХ-ийн зохицуулалтын дутмаг, ойлгомжгүй, бусад хууль тогтоомжийн уялдааны асуудалтай холбоотойгоор шүүхийн практикт хэрэг маргааныг хянан шийдвэрлэхэд хүндрэл, бэрхшээл олноор гарах болжээ. Уг хуулийн хэрэглээтэй холбоотой хэрэг маргаан нь Иргэний болон Захиргааны хэргийн шүүхээр хянан шийдвэрлэгдэж байна. ТБОНӨТХ-ийн 2016-2025 (3 сарын 9-ний байдлаар) оны хооронд Иргэний хэргийн шүүхээр шийдвэрлэгдсэн маргааныг авч үзвэл нийт 270 орчин маргаан гарч байгаа бөгөөд жилд дундажаар 30-35 маргаан шүүхээр шийдвэрлэгдэж байна (хавсралт 1-ийг үзнэ үү).

Түүнчлэн ТБОНӨТХ-ийг хэрэгжилтийг хангах хүрээнд Засгий газар, ТӨБЗГ, ИТХ, Засаг дарга зэргээс гадагш чиглэсэн өмчийн харилцаа/түрээслүүлэх, дуудлаг худалдаа зэрэг/-д хамаарах журмыг батлах бодит шаардлага үүсэж буй хэдий ч, тухайн хуулиар эрх шилжүүлээгүй тул журмын хүчин төгөлдөр байдал, хэм хэмжээний актын нэгдсэн системд бүртгүүлэх боломжгүй байгаа зэрэг захиргааны хэм хэмжээний нийцлийн асуудлууд ч үүсэж байна.

3.2.2.хууль тогтоомжийг хэрэгжүүлэх явцад түүний зохицуулалт бодит байдалтай нийцээгүй, тухайн харилцааг зохицуулах боломжгүй, эсхүл нийгмийн харилцааны өөрчлөлт, хөгжлөөс хоцорсон, зайлшгүй зохицуулах ёстой харилцааг хамарч зохицуулаагүй, эсхүл тэдгээрээс улбаалсан сөрөг үр дагавар бий болсон бол;

Нэгдүгээрт, Монгол улс 1990 оноос зах зээлийн эдийн засагт шилжсэнтэй холбогдуулан 1996 онд “ТБОНӨТХ-ийг баталсан. Уг хууль нь зах зээлийн шилжилтийн үеийн төрийн өмчийг удирдах, төрийн өмчийг хувьчлах харилцааг зохицуулахад чиглэсэн байдаг.

Гэсэн хэдий ч, нийгэм, эдийн засгийн харилцаа хурдацтай өөрчлөхийн хэрээр ТБОНӨТХ-ийн зохицуулалт нь бодит байдалтай нийцэхгүй, нийгмийн харилцааны өөрчлөлт, хөгжлөөс хоцрох болсон. Өнөөдрийн байдлаар тус хуульд нийт 36 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан бөгөөд хуулийн бүтцийн үндсэн хэлбэр болох зүйлийн

зохицуулалтын ойролцоогоор 80%-д өөрчлөлт оржээ.¹ Хуулийн зохицуулалтын дийлэнх хэсэгт нэгдсэн бодлого, зарчмаар бус салангид байдлаар өөр, өөр зорилгын хүрээнд нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.²

Хоёрдугаарт, ТБОНӨТХ-ийн үйлчлэлийн хүрээнд ЖДҮ, Боловсролын зээлийн сан, Хөгжлийн банк зэрэг олон тооны төрийн өмчийн асуудал үүсэж, олон нийтийг анхаарлыг татах болсон. Улмаар 2019 онд Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр Үндсэн хуулийн 6.2 дахь “төрийн өмч” гэсэн өмнөх томъёоллыг “төрийн нийтийн өмч” гэж өөрчлөн хуульчилж, нийтийн эрх ашгийг тэргүүн ээлжид тавих үзэл санааг дэвшүүлсэн.

Уг “төрийн нийтийн өмч” гэсэн нэр томъёоны “цаад агуулга нь нэгдүгээрт, төрийн нийтийн өмчийг буюу иргэдэд өмчлүүлснээс бусад газар, байгалийн баялгийг эзэмших, захиран зарцуулах бүрэн эрхийг Монгол Улсын ард түмний төлөөлөл болсон УИХ бодлогын хувьд шийдвэрлэнэ. Шаардлагатай бол Үндсэн хуулийн 25 дугаар зүйлд заасны дагуу иргэдийн санаа бодлыг асууж шийдэж болно. ... Хоёрдугаарт, “нийтийн” гэдэгт ямар санаа байна гэхээр Монголын ард түмний нийтлэг ашиг сонирхол буюу нийтийн ашиг сонирхлын үүднээс тэр газар, байгалийн баялгийн хувь заяаг шийдвэрлэнэ”³ гэсэн утгатай.

Энэхүү Үндсэн хууль дахь “төрийн өмч” гэсэн нэр томъёог “төрийн нийтийн өмч” болгон өөрчлөх болсон үйл явцын ард нь өнөөг хүртэл төрийн нийтийн өмчийн удирдлага, эрх зүйн зохицуулалт хангалтгүй байснаас үүдэн төрийн нийтийн өмчийг хувийн ашиг сонирхлын үүднээс захиран зарцуулах, үр ашиггүй болгох асуудал үүссэнтэй холбоотой. ⁴

Мөн Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийг дагалдан ердийн хуулийн шинэчлэл хараахан хийгдээгүйн улмаас төрийн өмчийг харилцааг зохицуулж буй холбогдох хууль тогтоомж Үндсэн хуультай зөрчилдөх асуудал үүсч байна. Тухайлбал, 1996 оны 5 дугаар сард батлагдсан ТБОНӨТХ-ийн 4.4-т “Төрийн нийтийн зориулалттай өмчлөлийн зүйлсийг хуульд заасан нөхцөл, журмын дагуу иргэн /Монгол улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн/, бусад өмчийн хуулийн этгээдэд эзэмшүүлж, ашиглуулж болно” гэж заалтыг дурдаж болно.⁵ Улмаар, ТБОНӨТХ-ийг Үндсэн хуулийн үзэл санаанд нийцүүлэн шинэчлэхээс гадна төрийн өмчийг нийтийн эрх ашигт нийцүүлэн удирдах хүрээнд төрийн өмчийн удирдлага, түүний эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох хэрэгцээ шаардлага үүсэж байна.

Түүнчлэн ТБОНӨТХ 1996 онд батлагдан хэрэгжиж эхэлснээс хойших 28 жилийн хугацаанд нийгэм, эдийн засгийн өөрчлөлтийг дагаж өмчийн харилцаатай холбоотой эрх зүйн зохицуулалтын хүрээнд томоохон өөрчлөлтүүд гарсны дотор 2002 онд Иргэний хууль, Газрын тухай хууль батлагдаж, 2006 онд Төрийн болон орон

¹ УИХТГ, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн судалгаа. Хуулийн төслийн ажлын хэсэг. 2021 он.

² УИХТГ, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн судалгаа. Хуулийн төслийн ажлын хэсэг. 2021 он.

³ О.Мөнхсайхан, ikon.mn-д өгсөн ярилцлага 2020.06.19 [<https://ikon.mn/n/1x1c>]

⁴ Г.Давааням, Япон улсын төрийн өмчийн удирдлага, түүний эрх зүйн зохицуулалт, 1 (ННФ, 2022)

⁵ Г.Давааням, Япон улсын төрийн өмчийн удирдлага, түүний эрх зүйн зохицуулалт, 1 (ННФ, 2022)

нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, 2011 онд Төсвийн тухай, Компанийн тухай хууль /шинэчилсэн найруулга/, 2020 онд Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль /шинэчилсэн найруулга/ зэрэг төрийн үйл ажиллагаа, өмч болон бизнесийн харилцааг зохицуулсан хуулиудын шинэчлэл томоохон байр суурийг эзэлнэ.

3.2.3. Захиргааны байгууллага эрх хэмжээнийхээ хүрээнд хууль тогтоомжийг хэрэгжүүлэх явцад хүндрэл бэрхшээл үүссэн бол;

Төрийн өмчийг удирдах хүрээнд төрийн байгууллага хоорондын, төрийн байгууллага болон төрийн өмч эзэмшигч хоорондын эрх хэмжээ хуулиар тодорхой зааглагдаагүйн улмаас УИХ, Засгийн газар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар /цаашид “ТӨБГЗ” гэх/-аар шийдвэрлэх шаардлагагүй зүйлсийг эдгээр байгууллага шийдвэрлэх, эдгээр байгууллага шийдвэрлэх нь зохистой харилцааг доод шатны байгууллага нь шийдвэрлэсэн зэрэг олон асуудал гарах болсон (Хүснэгт 1). Тухайлал, 2015 онд Засгийн газар Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалтын нэмэлт төлөвлөгөө буюу олны нэрлэж дадсанаар "Дубайн гэрээ"-г УИХ-аар хэлэлцүүлэхгүйгээр шийдвэрлэсэн, 2016 онд Засгийн газар Эрдэнэт үйлдвэрийн 49%-ийн хувьцааг худалдан авах асуудлыг УИХ-аар хэлэлцүүлэхгүйгээр шийдвэр гаргасан зэрэг олон асуудлыг дурдаж болно.

Мөн төрийн өмчийг эзэмшиж байгаа төрийн байгууллага, албан газар, ТӨҮГ, ТӨК-ийн бүхий л эд хөрөнгийн эрхийг бусад төрийн байгууллагын оролцоо, зөвшөөрлийн үндсэн дээр хязгаарласан байна (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Төрийн болон өмчийн талаарх төрийн болон орон нутгийн байгууллагын эрх хэмжээний хуваарилалт⁶

Эрхийн төрөл	Төрийн өөрийн өмч				Орон нутгийн өмч	ААТТӨҮГ, Төрийн өмчийн оролцоотой компани
	УИХ	Засгийн газар	ТӨБЗГ	Яам, тусгай газар	ИТХ	
Өмчлөх	УИХ өмчлөх				Өмчлөх	
Хувьчлах	Үндсэн чиглэл батлах, хувьчилж үл болох эд хөрөнгийн жагсаалт батлах	Хувьчлах хуулийн этгээд, эд хөрөнгийн жагсаалт батлах (8.4)	Хувьчлах ажлыг зохион байгуулах. ТӨҮГ-ийг компани хэлбэрт оруулан хувьчлах шийдвэр (55.1) Төрд ногдох хувийг биржээр,	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар (ШӨХТГ) санал өгнө. Банк хувьчлах бол ШӨХТГ болон Монгол банк хамтарсан хөтөбөр гаргана. (33.1)	ИТХ үндсэн хөрөнгийг хувьчлах шийдвэр гаргах. ТӨБЗГ-тай зөвшилцөх (77.3)	-

⁶ УИХТГ, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн судалгааны тайлан, 18-20 (2021).

			биржийн гадуур худалдах шийдвэр (56.1)			
Өмчийг барьцаалах	Шийдвэр саргах	-	-	-	Шийдвэр гаргах (77.3)	-
Төрийн өмчийг орон нутгийн өмчид шилжүүлэх	Шийдвэр гаргах (30.1)	-	-	-		-
Хуулийн этгээд хамтран байгуулах, хөрөнгө оруулах, хөрөнгөө татан авах		Шийдвэр гаргах				Санал гаргах
Хөрөнгийг хувьчлалаас гадуур худалдах, шилжүүлэх	-	Үл хөдлөх хөрөнгийн шийдвэр гаргах (29.1)	Үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийг худалдах шийдвэр (29.1)	-	Үндсэн хөрөнгийг шилжүүлэх шийдвэр гаргах 77.3	Үл хөдлөх хөрөнгө, үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгөөс бусад эд хөрөнгийг дуудлага худалдааг аар худалдах. (29.1)
Үл хөдлөх, үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийг данснаас хасах, шинээр авах	-	-	Захиалгыг хянаж батлах, шинээр авах шийдвэр гаргах	-	Шийдвэр гаргах 77.3	Данснаас хасах санал гаргах
Шаардлагаг үй эд хөрөнгийг худалдах, шилжүүлэх, устгах	-	Зөвшөөрө л өгөх	Зөвшөөрөл өгөх	-	-	Шийдвэр гаргах 31.1)

Ийнхүү төрийн болон орон нутгийн өмчийг эзэмшигч өөрийн эзэмшлийн хөдлөх эд хөрөнгө, ширээ сандал зэрэг эд зүйлсийг ч бодит байдал дээр захиран зарцуулах боломжгүй байгаа нь өмчийг үр ашиггүй болгох, эдийн засгийн харилцаанд орох боломжийг хязгаарласныг илтгэж байна. Үүнээс гадна төрийн

болон орон нутгийн өмчийг эзэмшигчийн дотоод засаглал, хяналтын хүрээнд хэрэгжүүлэх боломж бүхий өмчийн удирдлагыг УИХ, ИТХ, Засгийн газар, Засаг дарга, ТӨБЗГ-ын түвшинд шийдвэрлэж байгаа нь өмчийн удирдлагын зардал болон үр ашгийн харьцаанд сөргөөр нөлөөлж байна (дэлгэрэнгүйг гуравдугаар бүлгээс үзнэ үү).

В. Үнэлгээ хийх хүрээг тогтоох

Үнэлгээний хүрээг тогтоох ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг судлах явцад агуулгын хувьд чухал ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх хамгийн гол зохицуулалтыг тодорхойлоход чиглэх учиртай. Улмаар 1995 оны төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний хүрээг дараах байдлаар өргөн цар хүрээнд тогтоов. Үүнд:

Нэгдүгээр бүлэг. ТБОНӨТХ-ийн зорилт, үйлчлэх хүрээ

Сонгож авсан зүйл, заалт
1 дүгээр зүйл. Хуулийн зорилт Энэ хуулийн зорилт нь төрийн болон орон нутгийн өмчийн эрх, төрийн өмчийн эд хөрөнгийн талаар хууль тогтоох, гүйцэтгэх байгууллагын бүрэн эрх, төрийн өмчтэй хуулийн этгээд, түүний албан тушаалтны эрх хэмжээ, төрийн өмчийн талаархи бодлогыг хэрэгжүүлэх байгууллагын үйл ажиллагааны зарчим, журмыг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино. 2 дугаар зүйл. Үйлчлэх хүрээ 1. Энэ хууль нь Үндсэн хууль, Иргэний хуульд тодорхойлсон төрийн болон орон нутгийн өмчийн өмчлөх эрхийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад үйлчилнэ. 2. Энэ хууль нь улсын болон орон нутгийн төсөв, Монгол Улсын эрдэнэсийн сан, Ирээдүйн өв сангийн бүрдүүлэлт, хуваарилалт, захиран зарцуулалттай болон Монгол Улсын Хөгжлийн банк, Хадгаламжийн даатгалын корпораци, Төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрлэл, технологийн паркийн удирдлага, Ирээдүйн өв сан корпорацийн болон Малын индексжүүлсэн даатгалын үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад үйлчлэхгүй. 3. Хот, тосгоны өмчийн харилцаанд энэ хуульд заасан орон нутгийн өмчийн зохицуулалт нэгэн адил үйлчилнэ.

Хоёрдугаар бүлэг. Төрийн болон орон нутгийн өмчийн ангилал

Төрийн өмчийн хүрээнд сонгож авсан зүйл, заалт
3 дугаар зүйл. Төрийн өмчийн зүйлсийн тухай ойлголт, ангилал

Төрийн өмч нь төрийн нийтийн зориулалттай өмч, төрийн өөрийн өмчөөс бүрдэнэ. Төрийн нийтийн зориулалттай өмч, төрийн өөрийн өмч нь Иргэний хуулийн 84 дүгээр зүйлд заасны дагуу үл хөдлөх болон хөдлөх хөрөнгөд хуваагдана.

4 дүгээр зүйл. Төрийн нийтийн зориулалттай өмч

1.Үндсэн хууль, бусад хуулиар нийтийн зориулалтаар ашиглахаар бүх ард түмний өмч болгон заасан зүйлсийг төрийн нийтийн зориулалттай өмч гэнэ.

2.Төрийн нийтийн зориулалттай өмчид дараахь үл хөдлөх болон хөдлөх хөрөнгө хамаарна:

- 1/ иргэдэд өмчлүүлснээс бусад газар;
- 2/ газрын хэвлий, түүний баялаг;
- 3/ ус, түүний доторх баялаг;
- 4/ ой, түүний дагалдах баялаг;
- 5/ ургамал, ан амьтны нөөц;
- 6/ түүх, соёлын үнэт цогцолбор, хөшөө дурсгал;
- 7/ археологийн болон палентологийн олдвор;
- 8/ хуулиар нийтийн зориулалтаар ашиглахаар тогтоосон бусад эд хөрөнгө.

3.Төрийн нийтийн зориулалттай өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхийг Улсын Их Хурал хэрэгжүүлэх ба үүнтэй холбогдон үүсэх харилцаанд энэ хууль үйлчлэхгүй.

4.Төрийн нийтийн зориулалттай өмчлөлийн зүйлсийг хуульд заасан нөхцөл, журмын дагуу иргэн / Монгол улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн/ , бусад өмчийн хуулийн этгээдэд эзэмшүүлж, ашиглуулж болно.

5 дугаар зүйл. Төрийн өөрийн өмч

1.Төрийн өөрийн өмчид энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаас бусад төр эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулж болох дараахь эд хөрөнгө хамаарна:

- 1/ төрийн байгууллага, албан газарт эзэмшүүлсэн эд хөрөнгө;
- 2/ төрийн өмчит үйлдвэрийн газарт эзэмшүүлсэн эд хөрөнгө;
- 3/ төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн төрд ногдох хувь хөрөнгө;
- 4/ улсын төсвийн хөрөнгө болон төрийн бусад тусгай сан;
- 5/ төрийн тусгай хэрэгцээний бэлтгэл нөөц;
- 6/ хуульд заасан бусад төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгийн үл хөдлөх болон хөдлөх хөрөнгө.

2.Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг аж ахуйн зориулалтаар нь Нөхөрлөл, компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу үндсэн ба эргэлтийн хөрөнгө гэж хуваана.

3.Төрийн өөрийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулахтай холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулна.

4.Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг нийтийн зориулалттай өмчид, эсхүл өөр өмчид шилжүүлэх журмыг хуулиар тогтооно.

5.Төрийн өөрийн өмчийг зориулалт бусаар захиран зарцуулах, нийгмийн шинжтэй төсөл, арга хэмжээнд зарцуулах, хандив, тусламж, түүнтэй адилтгах хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглох бөгөөд энэхүү хориглолтыг зөрчсөн эрх бүхий этгээдийг албан тушаалаас чөлөөлж, учруулсан хохирлыг нөхөн төлүүлнэ.

Орон нутгийн хүрээнд сонгож авсан зүйл, заалт

74 дүгээр зүйл. Орон нутгийн өмчийн зүйлсийн тухай ойлголт

1. Орон нутгийн өмчийн зүйлс нь энэ хуулийн 3 дугаар зүйлд заасны дагуу нийтийн зориулалттай өмч, орон нутгийн өөрийн өмчөөс бүрдэнэ.

2. Орон нутгийн нийтийн зориулалттай өмчид тухайн орон нутгийн хүн амын нийтийн хэрэглээнд зориулсан эд хөрөнгө хамаарна.

Гуравдугаар бүлэг. Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлага

Төрийн өмчийн хүрээнд сонгож авсан зүйл, заалт

8 дугаар зүйл. Төрийн өмчийн талаархи Улсын Их Хурлын бүрэн эрх

1. Улсын Их Хурал төрийн өмчийн талаар дараахь бүрэн эрхтэй:

- 1/ Улсын Их Хурал бүх ард түмнийг төлөөлөн төрийн өмчийн өмчлөгч байх;
- 2/ төрийн өмчийн улсын нэгдсэн тооллогын дүнгийн тухай Засгийн газрын тайланг хэлэлцэх, төрийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрх хэмжээг тогтоох;
- 4/ төрийн өмчийг барьцаалах, орон нутгийн өмчид шилжүүлэх тухай шийдвэр гаргах;
- 5/ төрийн өмчийг хувьчлах үндсэн чиглэл, төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл, хувьчилж үл болох эд хөрөнгийн жагсаалтыг батлах, түүнд өөрчлөлт оруулах;
- 6/ төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой банкны хувьчлалын үндсэн чиглэлийг баталж, хувьчлал хууль тогтоомжийн дагуу явагдаж байгаа эсэхэд Монголбанкаар дамжуулан хяналт тавина;
- 7/ хуульд заасан бусад бүрэн эрх.

2. Нийгэмчлэх шийдвэрийг гагцхүү Улсын Их Хурал гаргах эрхтэй.

9 дүгээр зүйл. Төрийн өмчийн талаархи Засгийн газрын бүрэн эрх

Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараахь бүрэн эрхтэй:

- 1/ төрийн өмчийн талаархи төрийн бодлого, хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах;
- 2/ төрийн өмчит хуулийн этгээдийн өөрт олгогдсон эд хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах хэмжээ, хязгаарыг энэ хуульд нийцүүлэн тогтоох;
- 3/ төрийн өөрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг хувьчлалаас гадуур худалдах, шилжүүлэх тухай шийдвэр гаргах;

- 4/ хувьчлах хуулийн этгээд, эд хөрөнгийн жагсаалтыг батлах;
- 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;
- 6/ төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эд хөрөнгөөс бусад өмчийн этгээдтэй хамтран хуулийн этгээд байгуулах, хөрөнгө оруулах, оруулсан хувь хөрөнгөө татан авах талаар тухайн хуулийн этгээдээс гаргасан саналыг хэлэлцэж шийдвэрлэх;
- 7/ хуульд заасан тохиолдолд бусдын өмчлөлийн зүйлийг төрийн өмчид дайчлан авах шийдвэр гаргах, нийгэмчлэх санал, төсөл боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;
- 8/ төрийн өмчийн эд хөрөнгийн нэгдсэн тооллогын дүн, төсвийн гүйцэтгэлийн тайланг Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх;
- 9/ төрийн өмчит хуулийн этгээдийн улсын ба орон нутгийн төсөвтэй харилцах хуваарийг тогтоох, өөрчлөх;
- 10/ төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой банкны төрийн өмчид ногдох хэсгийг хувьчлах хөтөлбөр, банкин дахь төрийн өмчийн эд хөрөнгийг үнэлэх журмыг Монголбанктай зөвшилцөн батална;
- 11/ хуульд заасан бусад бүрэн эрх.

9¹ дүгээр зүйл. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага

1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага төрийн өмчийн эд хөрөнгийг эзэмших, ашиглах, хамгаалах ажлыг эрхлэн гүйцэтгэх үүрэг бүхий Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг мөн.

2. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дарга, орон тооны бус найман гишүүнээс бүрдэнэ. Дарга, орон тооны бус гишүүнийг Засгийн газар томилж, чөлөөлнө.

3. Аймаг, нийслэлд төрийн өмчийн төлөөлөгч ажиллана.

4. Төрийн өмчийн төлөөлөгчийн эрх, үүрэг, ажиллах журмыг Засгийн газар батална.

11 дүгээр зүйл. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь дараах бүрэн эрхтэй:

- 1/ төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах ажлыг зохион байгуулж гүйцэтгэлийг хянах;
- 2/ төрийн өмчийн эд хөрөнгийн анхан шатны бүртгэл, тооллого, тайлан тэнцэл гаргах ажлыг зохион байгуулж удирдах, төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалтад хяналт тавьж, түүний үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ авах;
- 3/ төрийн өмчит хуулийн этгээдээс дагаж мөрдөх төлөвлөлт, ашиг орлогын хуваарилалтыг холбогдох байгууллагатай тохиролцон тогтоох;
- 4/ Засгийн газраас баталсан жагсаалтын дагуу эд хөрөнгийг хувьчлах ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг тайлагнах;
- 5/ орон нутгийн өмчийг удирдах ажилд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх;

6/ төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөгчийг томилж, түүний үйл ажиллагаанд хяналт тавих;

7/ */Энэ заалтыг 2003 оны 1 дүгээр сарын 2-ны өдрийн хуулиар хүчингүй болгосон/*

8/ төрийн өмчит хуулийн этгээдийн үл хөдлөх болон үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийг данснаас хасах санал, захиалгыг хянаж батлах, шинээр авах шийдвэр гаргах;

9/ хуульд заасан бусад бүрэн эрх.

12 дугаар зүйл. Төрийн өмчийн талаархи яам, тусгай газрын эрх хэмжээ

1. Эрхэлсэн салбар, хүрээний төрийн өмчит хуулийн этгээдийн аж ахуй, санхүүгийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангаж, захиалга, төлөвлөлт, хөрөнгө оруулалт, шаардлагатай бусад асуудлаар санал боловсруулж холбогдох газарт оруулна.

2."Үндэсний аюулгүй байдлыг хангах, батлан хамгаалах зориулалттай бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг төрийн өмчит хуулийн этгээдийн удирдлага, эд хөрөнгийн талаархи бүрэн эрхийг уг асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ.

13 дугаар зүйл. Төрийн өмчит хуулийн этгээдийн ойлголт, ангилал

Төр чиг үүргээ хэрэгжүүлэх болон нийгмийн хэрэгцээг хангах зорилгоор төр өөрийн өмчөөр дангаараа байгуулсан хуулийн этгээдийг төрийн өмчит хуулийн этгээд гэнэ. Төрийн өмчит хуулийн этгээдийг эд хөрөнгийн эрхийн байдлаар нь дор дурдсанаар ангилна:

1/ төрийн байгууллага, албан газар;

2/ төрийн өмчит үйлдвэрийн газар.

3/төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг.

4/төрийн болон орон нутгийн өмчийн боловсролын сургалтын байгууллага /сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн, дээд боловсрол/.

14 дүгээр зүйл. Төрийн байгууллага, албан газрын эд хөрөнгийн эрх

1.Төрийн өмчит үйлдвэрийн газраас бусад улсын төсвөөс санхүүждэг хуулийн этгээдийг төрийн байгууллага, албан газар гэнэ.

2.Төрийн байгууллага, албан газар төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг нь өөрт олгогдсон эд хөрөнгийн талаар дараахь эрх, үүрэгтэй:

1/ өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах;

2/ улсын төсвөөс олгосон хөрөнгийг Төсвийн тухай хуульд заасны дагуу зарцуулж, тайлагнах;

/Энэ заалтад 2003 оны 1 дүгээр сарын 2-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

/Энэ заалтад 2011 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

3/ */Энэ заалтыг 2003 оны 1 дүгээр сарын 2-ны өдрийн хуулиар хүчингүй болгосон/*

4/ төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургууль дэргэдээ бие даасан гарааны компани байгуулахаас бусад тохиолдолд үндсэн хөрөнгөд

хамаарах эд хөрөнгө олж авах, захиалах, данснаас хасаж шилжүүлэх, устгах саналаа төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тавьж, энэ хуулиар тогтоосон журмын дагуу зөвшөөрөл авах.

3.Төрийн болон орон нутгийн өмчийн төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгийн тусламж, үйлчилгээний удирдлага, зохион байгуулалт, санхүүжилт, хяналт, эмнэлгийн үйлчилгээнд тавих шаардлага, үйл ажиллагаатай холбогдсон харилцааг Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулиар зохицуулна.

15 дугаар зүйл. Төрийн өмчит үйлдвэрийн газрын ангилал

1.Төрийн өмчит үйлдвэрийн газар гэдэгт дан ганц төрийн өмчид үндэслэсэн болон улсын төсвөөс санхүүждэг үйлдвэрийн газар орох бөгөөд тэдгээрийг эд хөрөнгийн эрхийн байдлаар нь аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, улсын төсөвт үйлдвэрийн газар гэж ангилна:

2.Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар гэнэ.

3.Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр төсвийн хөрөнгөөр санхүүждэг, зөвхөн төрийн хэрэгцээнд зориулсан үйлдвэрлэл, ажил, үйлчилгээ эрхэлдэг хуулийн этгээдийг улсын төсөвт үйлдвэрийн газар гэнэ.

16 дугаар зүйл. Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын эд хөрөнгийн эрх

1. Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар нь эд хөрөнгийн талаар дараахь эрх, үүрэгтэй:

- 1/ өөрт олгогдсон хөрөнгийг дүрэмд заасан үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн эзэмших, ашиглах;
- 2/ үндсэн хөрөнгийг энэ хуульд заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулах;
- 3/ үйлдвэрийн үйл ажиллагааны үр дүнд олсон ашгаас эрх бүхий байгууллагаас баталсан нормативт хэмжээгээр өөртөө үлдээж захиран зарцуулах;
- 4/ үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ өөрөө бие даан борлуулах.

2. Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар үндсэн хөрөнгийг зөвхөн төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зөвшөөрөлтэйгээр данснаас хасах буюу борлуулах, устгах эрхтэй.

3.Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын хөрөнгөөр хандив, тусламж, түүнтэй адилтгах аливаа хөтөлбөр, арга хэмжээ, нийгмийн шинжтэй үйл ажиллагаа болон төсвийн алдагдлыг санхүүжүүлэхийг хориглоно.

17 дугаар зүйл. Улсын төсөвт үйлдвэрийн газрын эд хөрөнгийн эрх

1. Улсын төсөвт үйлдвэрийн газар нь эд хөрөнгийн талаар энэ хуулийн 14 дүгээр зүйлд заасан төрийн байгууллага, албан газартай нэгэн адил эрхтэй.

18 дугаар зүйл. Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захиргаа

1. Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг үйлдвэрийн газрын Захирал удирдана. Захирлыг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, зохих салбар, хүрээний яам, агентлагтай зөвшилцөн томилох буюу өөрчилнө.

2. Захирлаар томилогдох этгээд дор дурдсан шаардлага хангасан байвал зохино:

1/ дээд боловсролтой;

2/ аль нэг хуулийн этгээд буюу түүний салбар нэгжийн удирдах ажлыг 2-оос доошгүй жил хийсэн, удирдлагын зохих дадлагатай;

3/ удирдлагын ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлдэг.

3. Тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг нь шүүхийн шийдвэрээр хассан, эрүүгийн хуульд заасан санаатай гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял шийтгүүлсэн, удирдаж байсан хуулийн этгээдээ дампууруулсан, эсхүл удирдах үүргээ зохих ёсоор биелүүлээгүйгээс өөрчлөгдсөн этгээдийг 5 жилийн дотор захирлаар томилохыг хориглоно.

4. Захирал төрийн, хувийн өмчийн, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлд орох, тэдгээрийн захиргаанд буюу олон нийтийн болон шашны байгууллага, сангийн удирдах ажлыг хавсран гүйцэтгэхийг хориглоно.

5. Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захиргааны албан тушаалын жагсаалт, орон тооны нормативыг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тогтооно.

19 дүгээр зүйл. Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захиралтай байгуулах гэрээ

1. Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захирлыг / цаашид "захирал" гэх/ томилохдоо гэрээ байгуулна. Гэрээнд дараахь нөхцөлийг тусгана:

1/ энэ хуульд заасан эрх, үүрэг;

2/ эдийн засгийн үр ашгийг дээшлүүлж, хүргэх түвшин;

3/ техник, технологийг шинэчлэх даалгавар;

4/ хамт олны хөдөлмөр хамгаалал, нийгмийн талаар авах арга хэмжээ;

5/ менежментийн бодлого;

6/ захирлаас болон үүргээ биелүүлэх талаар төрөөс хүлээх үүрэг;

7/ удирдаж байгаа үйлдвэрийн газарт нь өмчлөгчөөс олгосон эд хөрөнгө, түүний хэмжээ;

8/ цалин, нэмэгдэл хөлс, энэ хуульд заасан урамшуулал;

9/ ажлын нөхцөл /унаа, холбоо зэрэг/;

10/ энэ хуульд заасан эд хөрөнгийн хариуцлага;

11/ гэрээний үүргийн биелэлтийг дүгнэх журам, хугацаа;

12/ хуульд харшлаагүй бусад нөхцөл.

2. Захирал гэрээгээр тохиролцсон үүргээ биелүүлээгүй нь хүндэтгэн үзэх бодит шалтгаангүй бол түүнийг ажлаас халах үндэслэл болно.

20 дугаар зүйл. Захирлын эд хөрөнгийн эрх, үүрэг

1.Захирал дараахь эрх, үүрэгтэй:

- 1/ тухайн үйлдвэрийн газрыг итгэмжлэлгүйгээр төлөөлөх, итгэмжлэл олгох;
- 2/ үйлдвэрийн газрын нэрийн өмнөөс эд хөрөнгийг энэ хууль, гэрээнд заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулах;
- 3/үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах;
- 4/ үйлдвэрийн газрын захиргааны бүтцийг тогтоож, албан тушаалтныг томилох, чөлөөлөх, эрх бүхий байгууллагаас тогтоосон цалингийн бүдүүвч сангийн хэмжээнд багтаан цалинг тогтоох;
- 5/ үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, технологийн нууцад хамаарах мэдээллийг тогтоох;
- 6/ хөдөлмөрийн хууль тогтоомжид нийцсэн хөдөлмөрийн дотоод журам баталж мөрдүүлэх;
- 7/ тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах;
- 8/ маргаантай асуудлаар үйлдвэрийн газраа төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргах;
- 9/ улсаас хатуу тогтоосноос бусад бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний үнэ, тарифыг тогтоох;
- 10/ эрх хэмжээнийхээ асуудлаар хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг биелүүлэхийн тулд тэдгээрт нийцүүлэн тухайн үйлдвэрийн газрын хэмжээнд дагаж мөрдөх, тушаал, заавар гаргах;
- 11/ хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.

2. Захиралд энэ зүйлд заасан нийтлэг эрх, үүргээс гадна тухайн үйлдвэрийн газрын үйл ажиллагааны онцлогтой холбоотой бусад эрх, үүрэг эдлүүлэх талаар энэ хуулийн 19 дүгээр зүйлд заасан гэрээнд тусгаж болно.

3. Захирал шаардлагатай мэргэжилтэн, албан тушаалтныг оролцуулан захирлын зөвлөл байгуулан ажиллуулж болох ба зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг захирлын тушаалаар батална.

Зөвлөлийн гишүүд захиралд гагцхүү зөвлөх эрхтэй ажиллана.

4. Захиралд дараахь урамшуулал үзүүлэхээр гэрээнд тусгаж болно:

- 1/ үйлдвэрийн газрын ашгаас тодорхой хугацаанд тодорхой хувиар олгох;
- 2/ гэрээний үүргийн биелэлтийг харгалзан тодорхой хэмжээний мөнгөн шагнал олгох.

5. Захирлын гэм буруутай үйл ажиллагаа болон энэ хууль, гэрээнд заасан эд хөрөнгө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхээ хэтрүүлэн буюу урвуулан ашиглах зэргээр тухайн үйлдвэрийн газарт хохирол учруулсан бол уг хохирлыг захирал өөрийн хувийн өмчийн эд хөрөнгөөр бүрэн хариуцна.

21 дүгээр зүйл. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, түүний эд хөрөнгийн эрх, онцлог

1. Төрийн өмчийн хувьцаатай буюу төр хувь хөрөнгөө оруулсан хуулийн этгээдийг төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд гэнэ.

2. Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөгчийг дараах байдлаар томилно.

1/төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эрх барих дээд байгууллагын хуралд төрийг төлөөлөх этгээдийг уг хурлаар хэлэлцэх асуудал бүрээр өгөх саналын удирдамжийн хамт төрийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлж байгаа этгээд томилох;

2/төрийн өмчийн оролцооны хувь хэмжээтэй хувь тэнцүүлэн тухайн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд төрийг төлөөлөх гишүүний нэрийг төрийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлж байгаа этгээд тухайн компанийн нэр дэвшүүлэх хороонд санал болгох бөгөөд нэр дэвшүүлэх хороо тэрхүү нэр дэвшигдэж байгаа этгээд нь хуульд заасны дагуу төрийг төлөөлөх этгээд мөн бол төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилуулахаар хувьцаа эзэмшигчдийн хуралд шууд оруулах үүрэгтэй;

3/энэ зүйлийн 2 дахь хэсгийн 1, 2-т заасан төрийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх этгээдийг Засгийн газар тогтоох.

3. Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Гишүүдийн хуралд төрийг төлөөлж оролцохоор томилогдсон төрийн өмчийн төлөөлөгч нь тухайн хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд орсон байна.

4. Төрийн өмчийн төлөөлөгч дараахь эрх үүрэгтэй:

1/ гишүүдийн болон төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд таслах эрхтэй оролцох;

2/ төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлж байгаа хуулийн этгээдийн эд хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах талаар санал боловсруулж төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад оруулах;

3/ олгогдсон эрх хэмжээнийхээ дотор төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх.

5.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон энэ зүйлийн 2 дахь хэсгийн 3-т заасны дагуу тогтоосон этгээд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд төрийг төлөөлж оролцох гишүүдийг томилохдоо дараах болзлыг хангасан нэр дэвшигчдээс томилно:

1/тухайн хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний үүргийг гүйцэтгэхэд шаардагдах мэдлэг, чадвартай;

2/тухайн хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн байхад ашиг сонирхлын зөрчил үүсэхгүй байх;

3/төрийн захиргааны албан хаагч болон энэ зүйлийн 2 дахь хэсгийн 3-т заасны дагуу тогтоосон этгээдийн ажилтан байх.

6.Төрийн өмчийн төлөөлөгч болон төлөөлөн удирдах зөвлөлийн төрийг төлөөлөх гишүүнээр томилогдсон этгээд нь төрийн мэдлийн хувьцаа эзэмшигчээс баталсан удирдамж, зааврыг баримтлан ажиллана. Удирдамж, зааврыг зөрчсөн буюу зохих ёсоор биелүүлээгүй нь түүнийг томилсон шийдвэрийг хүчингүй болгох үндэслэл болно.

8. Төр төлөөлж Гишүүдийн хуралд оролцож байгаа төрийн өмчийн төлөөлөгч нь тухайн хуулийн этгээдийн бусад хувийн өмчлөгчөөс төлөөлөн удирдах зөвлөлд сонгогдож байгаа гишүүний талаар санал өгөхгүй.

9. Энэ хууль болон бусад хуульд нийцүүлж Засгийн газар төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд дэх төрийн өмчийн төлөөллийн талаар тусгай журам тогтоож болно.

11.Төрийн өмчийн төлөөлөгч нь төлөөлөн удирдах зөвлөлтэй тухайн хуулийн этгээдийн хэтийн төлөвлөгөөг тохиролцож, түүний хэрэгжилтийг хянаж, дүгнэхээс бусад хэлбэрээр өдөр тутмын удирдлагын үйл ажиллагаанд оролцохгүй.

12.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилогдсон төрийн албан хаагч эрх бүхий байгууллагаас тогтоосон цалин хөлснөөс бусад төрлийн шан харамж, урамшуулал авахыг хориглоно.

13.Төрийн мэдлийн хувьцаа эзэмшигч нь төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдээс олгох ногдол ашгийн хувь хэмжээг тогтоох саналыг төлөөлөн удирдах зөвлөлд бичгээр, эсхүл цахим хэлбэрээр гаргана.

14.Төлөөлөн удирдах зөвлөл энэ хуульд заасан тайлан, бусад мэдээллийг холбогдох байгууллагад хугацаанд нь гаргаж өгөх үүрэгтэй.

15.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нийт төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны санхүүгийн үр дүн, тэдгээрээс төсвийн байгууллагын санхүү болон мөнгөн хөрөнгийн гүйлгээнд нөлөөлөх байдал, ажлын үр дүнд хяналт тавина.

16.Төрийн өмчит, төрийн өмч давамгайлсан хуулийн этгээд нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авсны үндсэн дээр зээл авч, үнэт цаас гаргана.

18.Энэ зүйлийн 16-д заасан зөвшөөрөлд төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн тухайн санхүүгийн жилд эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр богино хугацаанд авах зээл, үнэт цаас хамаарахгүй.

19.Энэ зүйлийн 16-д заасан зөвшөөрөлд төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн улирлын чанартай орлогын дутагдлыг санхүүжүүлэх зээл хамаарахгүй.

20.Энэ зүйлийн 16-д заасан зөвшөөрөлгүйгээр төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээд нь зээл авах, үнэт цаас гаргахыг хориглоно.

21.Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хөрөнгөөр хандив, тусламж, түүнтэй адилтгах аливаа хөтөлбөр, арга хэмжээ, нийгмийн шинжтэй үйл ажиллагаа, төсвийн алдагдлыг санхүүжүүлэхийг хориглоно.

Орон нутгийн хүрээнд сонгож авсан зүйл, заалт

77 дугаар зүйл. Орон нутгийн өмчийн талаархи иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх

1. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь тухайн аймаг, сум, нийслэл, дүүргийн өмчийн зүйлсийг хүн амаа төлөөлөн өмчлөгч нь байна.

2. Орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараахь бүрэн эрхтэй:

1/ орон нутгийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдлыг хянан шалгах буюу түүнд тавих хяналт шалгалтыг зохион байгуулах;

2/ иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргаас орон нутгийн өмчийн хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхээ хэрэгжүүлэх талаар зохиосон ажил, үр ашгийн тайлан, нэгдсэн тооллогын дүнг жил бүр хэлэлцэж, дүгнэлт, чиглэл өгөх;

3/ орон нутгийн өмчийн үндсэн хөрөнгийг хувьчлах ба бусдад шилжүүлэх, шинээр олж авах жагсаалт, төлөвлөгөө, эх үүсвэрийг хэлэлцэж батлах. Хувьчлах орон нутгийн эд хөрөнгийн жагсаалтыг батлахдаа Төрийн өмчийн хороотой зөвшилцөнө;

4/ орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих.

3. Орон нутгийн өмчид хамаарах үндсэн хөрөнгийг бусдын өмчлөлд шилжүүлэх, барьцаалах, шинээр олж авах асуудлыг гагцхүү иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний хуралдааны чөлөөт цагт Хурлын дарга шийдвэрлэнэ.

4. Хурлын дарга нь тухайн хурлын хуралдааны чөлөөт цагт энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан бүрэн эрхийг хэрэгжүүлж иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хариуцан тайлагнахаас гадна орон нутгийн өмчийн оролцоотой хувь нийлүүлсэн хуулийн этгээдэд өмчийн төлөөлөгчийг томилж түүний үйл ажиллагааг чиглүүлнэ.

6. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хуулийн 68.4-т заасны дагуу засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн өөрийн удирдлагын чиг үүргийг шилжүүлсэн бол энэ хуульд заасан иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрхийг тухайн хот, тосгоны Зөвлөл хэрэгжүүлнэ.

78 дугаар зүйл. Орон нутгийн өмчийн талаархи Засаг даргын бүрэн эрх

1. Засаг дарга нь иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас орон нутгийн өмчийн эд хөрөнгийн талаар гарсан шийдвэрийг Засгийн газрын бодлогод нийцүүлэн хэрэгжүүлэх үүрэгтэй.

2. Хуульд өөрөөр заагаагүй бол Засаг дарга дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас олгосон эрх хэмжээний дотор орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах;

2/ орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эрх баригчийг томилох;

3/ орон нутгийн өмчийн төлөөлөгчийг томилох, өөрчлөх саналаа Хурлын даргад оруулах;

4/ орон нутгийн өмчийн эд хөрөнгийн нэгдсэн бүртгэл хөтлөх, эд хөрөнгийн тооллого явуулах ажлыг зохион байгуулах;

5/ орон нутгийн өмчит албан байгууллагыг шаардлагатай эд хөрөнгөөр хангах;

- 6/ орон нутгийн өмчийн эд хөрөнгийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын мэргэжил, арга зүйн удирдлагын дор хувьчлах ажлыг зохион байгуулах;
- 7/ нутгийн өмч эрхэлсэн ажилтан буюу албыг шуурхай удирдах.

3.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хуулийн 68.4-т заасны дагуу засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн төрийн удирдлагын чиг үүргийг шилжүүлсэн бол энэ хуульд заасан Засаг даргын бүрэн эрхийг тухайн хот, тосгоны Захирагч хэрэгжүүлнэ.

79 дүгээр зүйл.Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн эрх

Орон нутгийн өмчит хуулийн этгээд энэ хуулийн 14, 16, 17, 21 дүгээр зүйл, 211 дүгээр зүйлийн 12 дахь хэсэгт заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

80 дугаар зүйл. Орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах журам

Орон нутгийн өмчийг эзэмших, захиран зарцуулахтай холбогдсон харилцааг энэ хуулийн тавдугаар бүлэгт заасны дагуу зохицуулна.

Дөрөвдүгээр бүлэг. Төрийн болон орон нутгийн өмчийн эзэмшигчийн ангилал

Сонгож авсан зүйл заалт

13 дугаар зүйл. Төрийн өмчит хуулийн этгээдийн ойлголт, ангилал

Төр чиг үүргээ хэрэгжүүлэх болон нийгмийн хэрэгцээг хангах зорилгоор төр өөрийн өмчөөр дангаараа байгуулсан хуулийн этгээдийг төрийн өмчит хуулийн этгээд гэнэ. Төрийн өмчит хуулийн этгээдийг эд хөрөнгийн эрхийн байдлаар нь дор дурдсанаар ангилна:

- 1/ төрийн байгууллага, албан газар;
- 2/ төрийн өмчит үйлдвэрийн газар.
- 3/төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг.
- 4/төрийн болон орон нутгийн өмчийн боловсролын сургалтын байгууллага /сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн, дээд боловсрол/.

14 дүгээр зүйл. Төрийн байгууллага, албан газрын эд хөрөнгийн эрх

1.Төрийн өмчит үйлдвэрийн газраас бусад улсын төсвөөс санхүүждэг хуулийн этгээдийг төрийн байгууллага, албан газар гэнэ.

2.Төрийн байгууллага, албан газар төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг нь өөрт олгогдсон эд хөрөнгийн талаар дараахь эрх, үүрэгтэй:

- 1/ өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах;

2/ улсын төсвөөс олгосон хөрөнгийг Төсвийн тухай хуульд заасны дагуу зарцуулж, тайлагнах;

4/ төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургууль дэргэдээ бие даасан гарааны компани байгуулахаас бусад тохиолдолд үндсэн хөрөнгөд хамаарах эд хөрөнгө олж авах, захиалах, данснаас хасаж шилжүүлэх, устгах саналаа төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тавьж, энэ хуулиар тогтоосон журмын дагуу зөвшөөрөл авах.

3.Төрийн болон орон нутгийн өмчийн төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгийн тусламж, үйлчилгээний удирдлага, зохион байгуулалт, санхүүжилт, хяналт, эмнэлгийн үйлчилгээнд тавих шаардлага, үйл ажиллагаатай холбогдсон харилцааг Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулиар зохицуулна.

15 дугаар зүйл. Төрийн өмчит үйлдвэрийн газрын ангилал

1.Төрийн өмчит үйлдвэрийн газар гэдэгт дан ганц төрийн өмчид үндэслэсэн болон улсын төсвөөс санхүүждэг үйлдвэрийн газар орох бөгөөд тэдгээрийг эд хөрөнгийн эрхийн байдлаар нь аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, улсын төсөвт үйлдвэрийн газар гэж ангилна:

2.Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар гэнэ.

3.Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр төсвийн хөрөнгөөр санхүүждэг, зөвхөн төрийн хэрэгцээнд зориулсан үйлдвэрлэл, ажил, үйлчилгээ эрхэлдэг хуулийн этгээдийг улсын төсөвт үйлдвэрийн газар гэнэ.

Тавдугаар бүлэг. Төрийн болон орон нутгийн өмчид хөрөнгө олж авах, захиран зарцуулах

Сонгож авсан зүйл заалт

24 дүгээр зүйл. Төрийн өмчийн эд хөрөнгийг олж авах

1. Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар өөрийн чиг, үүрэг зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай эд хөрөнгийн жагсаалтыг санхүүгийн жил эхлэхээс 3 сарын өмнө гаргаж, төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Сангийн яамаар зардлын дээд хязгаарыг батлуулна.

2.Төрийн байгууллагаас бусад төрийн өмчит хуулийн этгээд батлагдсан зардлын хэмжээнд багтаан шаардлагатай хөрөнгийг өөрөө худалдаж авах ба төрөөс түүнд хариу төлбөргүйгээр олгож болно.

3. Төрийн өмчит хуулийн этгээд үл хөдлөх хөрөнгийг захиалгын үндсэн дээр зөвхөн төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын шийдвэрээр олж авна.

Зургаадугаар бүлэг. Төрийн болон орон нутгийн өмчийг захиран зарцуулах арга

Сонгож авсан зүйл, заалт

28 дугаар зүйл. Төрийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх

1. Төрийн нийтийн зориулалттай өмчийг түрээслүүлэх журмыг Улсын Их Хурал, төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журмыг Иргэний хуульд нийцүүлэн Засгийн газар тогтооно

2. Засгийн газраас тусгайлан журамласнаас бусад үл хөдлөх хөрөнгийг түрээсээр эзэмшүүлэх, ашиглуулах эрхийг төрийн өмчит хуулийн этгээд эдэлнэ.

3. Түрээсийн гэрээнд Иргэний хуулийн 105 дугаар зүйлд заасан нөхцөлөөс гадна эд хөрөнгө түрээслүүлэх хугацаа, төлбөр, нөхцөл, хугацаанаас өмнө цуцлах үндэслэл, үүсэх үр дагавар, түүнийг арилгах журмыг заавал тусгана.

4. Түрээсэлсэн эд хөрөнгийг худалдах тохиолдолд түрээслэгчид Иргэний хуулийн 105 дугаар зүйлд заасан эрх /тэргүүн ээлжинд худалдан авах/ эдлүүлэх эсэхийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага шийдвэрлэнэ.

5. Төрийн өмчийн түрээсийн төлбөрийг улсын төсөвт оруулна. Уг төлбөр тухайн эд хөрөнгийг худалдан авах үнийн төлбөрт үл хамаарна.

29 дүгээр зүйл. Төрийн өмчийн эд хөрөнгийг худалдах

1. Төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг хувьчлалаас гадуур худалдахад Засгийн газрын, төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын, бусад эд хөрөнгийг тухайн хуулийн этгээдийн шийдвэрээр гагцхүү дуудлага худалдаагаар худалдаж болно.

30 дугаар зүйл. Төрийн өмчийн эд хөрөнгийг үнэ төлбөргүй шилжүүлэх

1. Төрийн өмчийн эд хөрөнгийг орон нутгийн өмч бүрдүүлэх зорилгоор үнэ төлбөргүй шилжүүлэх асуудлыг гагцхүү Улсын Их Хурал шийдвэрлэнэ.

2. Төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгө, хуулийн этгээдийн эрх хэмжээнд хамааруулснаас бусад хөдлөх хөрөнгийг Засгийн газрын шийдвэрээр, Засгийн газраас зөвшөөрөл олгосон тохиолдолд төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын шийдвэрээр шилжүүлж болно.

3. Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хандивлах, бэлэглэх, барьцаалах, зээлдүүлэх, бусад өмчийн хуулийн этгээдэд хувь хөрөнгө болгон оруулахыг хориглоно.

4. Төрийн өмчийн эд хөрөнгөнөөс нэг удаагийн тэтгэмж, тусламж олгох журмыг Засгийн газраас тогтооно.

Долоодугаар бүлэг. Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, тооллого, актлах

Сонгон авсан зүйл заалт

69 дүгээр зүйл. Төрийн өмчит хуулийн этгээдийн нягтлан бодох бүртгэл, бүртгэл тооцоо

1.Төрийн өмчит хуулийн этгээд нь анхан шатны бүртгэлийн баталгаажсан баримтыг үндэслэн дэлгэрэнгүй ба хураангуй бүртгэл хөтлөн, тайлан тэнцлийг улирлаар зохиож Сангийн яаманд тушаана.

2. Заавал хөтлөх нягтлан бодох бүртгэлийн нийтлэг маягтаас гадна төрийн өмчийн хуулийн этгээдэд хөтлөгдвөл зохих мэдээ, тайлангийн маягт, аргачлалыг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батлан мөрдүүлж болно.

3.Төрийн өмчит хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч нь мэргэшсэн байх бөгөөд түүнийг Сангийн яамны зөвшөөрөлтэйгээр захирал томилно.

70 дугаар зүйл. Төрийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн тооллого, түүний хугацаа

1. Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгө, үнэт цаас, мөнгөн хөрөнгийн тооллогыг дотоодын тооллого, улсын тооллого гэж хоёр хуваана.

2. Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана:

3. Дотоодын тооллогын тайлан тэнцлийн дүнг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага санхүү, статистикийн байгууллагатай хамтран улсын хэмжээгээр нэгтгэн гаргаж, дутагдсан эд хөрөнгийг нөхөн төлүүлэх, илүүдэл болон цаашид ашиглах боломжгүй болсон үндсэн эд хөрөнгийг шилжүүлэх, борлуулах, устгах зэрэг шаардлагатай арга хэмжээ авч Засгийн газарт тайлагнана.

4. Үндсэн хөрөнгийн, шаардлагатай гэж үзвэл эргэлтийн хөрөнгийн улсын үзлэг тооллогыг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага эрхлэн 4 жилд 1 удаа Засгийн газрын бүрэн эрхийн хугацаа эхэлсэн анхны жилийн IV улиралд багтаан явуулна.

Наймдугаар бүлэг. Төрийн болон орон нутгийн өмчийн хяналт

Сонгон авсан зүйл заалт

66 дугаар зүйл. Хяналт шалгалтын тогтолцоо

1. Төрийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, эзэмшилт, ашиглалт, захиран зарцуулалтад тавих төрийн хяналт шалгалт нь Улсын Их Хурал, Засгийн газраас тавих ерөнхий хяналт, Төрийн хянан шалгах хороо, Сангийн яам болон төрийн өмчийн бодлого,

зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас хэрэгжүүлэх мэргэжлийн хяналт шалгалт, хуулийн этгээдийн дотоодын хяналт шалгалтаас бүрдэнэ.

2. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон эрх бүхий бусад байгууллагын захиалгаар төрийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, захиран зарцуулалтад хөндлөнгийн магадлан шалгалт хийлгэж болно.

3. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ талаархи хууль болон Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах үндсэн дээр өмчийн ашиглалт, захиран зарцуулалтад гүйцэтгэлийн болон баримтын байцаан шалгалт хийх, бүртгэлээр хяналт тавих зэргээр өмчийн хадгалалт, хамгаалалтад тавих системийн хяналт шалгалтыг хэрэгжүүлнэ.

4. Сангийн яам нь төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай хамтран төрийн өмчит хуулийн этгээдийн аж ахуй, санхүүгийн үйл ажиллагаанд баримтын иж бүрэн шалгалтыг 2 жил тутам нэгээс доошгүй удаа заавал хийх ба шалгалтын дүнг хамтран хэлэлцэж шаардлагатай арга хэмжээ авна.

5. Эрх бүхий байгууллагууд тус тусын эрхлэх ажлын хүрээнд өмч хамгаалах асуудлаар төрийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалалтад санхүүгийн гэнэтийн сонгон шалгалт хийж болно.

67 дугаар зүйл. Дотоодын хяналт шалгалт

1. Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна.

2. Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна.

Есдүгээр бүлэг. Төрийн болон орон нутгийн өмчийн тайлагнал, мэдээллийн сан

Сонгон авсан зүйл заалт

70 дугаар зүйл. Төрийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн тооллого, түүний хугацаа

1. Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгө, үнэт цаас, мөнгөн хөрөнгийн тооллогыг дотоодын тооллого, улсын тооллого гэж хоёр хуваана.

2. Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана.

С. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох

ТБОНӨТХ-ийн хэрэгжилтийн үр дагаврыг тодорхойлоход аргачлалын 3.4-т заасан дараах шалгуур үзүүлэлтийг сонгов. Үүнд:

3.4.1.зорилгод хүрсэн түвшин-тухайн хууль тогтоомж хэрэгжиж эхэлснээс хойшх хугацаанд хуулийн зорилго, зорилтдоо хүрсэн эсэхийг тогтооно.

3.4.3.зардал-үр өгөөжийн харьцаа-тухайн хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд зарцуулсан хөрөнгө, гарсан үр өгөөжийн харьцааг тооцон гаргана. Тодруулбал, хууль тогтоомж нийгэмд үр нөлөөтэй үйлчилж, тодорхойлсон зорилтдоо бүрэн, эсхүл зарим хэсэгт нь хүрсэн эсэхийг тухайн хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд гарсан зардлын хэмжээг харьцуулан гаргаж ирнэ.

3.4.4.хүлээн зөвшөөрөгдсөн байдал-иргэд, хуулийн этгээдээс хууль тогтоомжийг хэрэгжүүлснээр гарсан үр дагаврыг хэрхэн хүлээн авч байгааг тодорхойлно. Өөрөөр хэлбэл, хууль тогтоомжийг нийгэм хүлээн зөвшөөрч, сайн дураар сахин биелүүлж байгаа эсэхийг энэ шалгуур үзүүлэлтээр шалгана.

3.4.5.практикт нийцэж байгаа байдал-тухайн хууль тогтоомжийн зохицуулалт хэрхэн хэрэгжиж байгаа, түүний эерэг болон сөрөг үр дагавар хэрэгжүүлэхэд хүндрэл гарч байгаа эсэхийг тодорхойлно.

D. Харьцуулах хэлбэрийг сонгох

ТБОНӨТХ-ийн хэрэгжилтийн үр дагаврыг тодорхойлоход аргачлалын 3.5.3-т заасан дараах харьцуулах хэлбэрийг сонгов. Ингэхдээ 3.5.1-т заасан “хууль хэрэгжсэнээр нийгмийн харилцаанд гарсан эерэг, сөрөг өөрчлөлтүүдийг олж тодорхойлох”, 3.5.2-т заасан “хуулийн хэрэгжилттэй холбоотой үүссэн асуудал буюу үнэлэх болсон шалтгаан, тогтоосон хүрээ, шалгуур үзүүлэлтээс хамааран аль болох тохиромжтой харьцуулах хэлбэрийг сонгох”-ыг эрмэлзсэн болно. Үүнд:

3.5.3.2.хууль тогтоомж батлагдахаас өмнөх болон хууль тогтоомж батлагдсанаас хойш-хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчлэхээс өмнөх нөхцөл байдлыг хууль тогтоомж хүчин төгөлдөр хэрэгжсэний дараах нөхцөл байдал буюу хууль тогтоомжийн хэрэгжилтийн явцад гарч байгаа үр дагавартай харьцуулан дүн шинжилгээ хийхийг хэлнэ.

Байвал зохих үзүүлэлтийг хууль тогтоомжид тодорхой заагаагүй бол хууль тогтоомж батлагдахаас өмнөх үеийн нөхцөл байдал, тоо баримтыг хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш бий болсон үеийн нөхцөл байдал, тоо баримттай харьцуулж болно.

3.5.3.3.хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш-хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдсөнийг он дарааллаар судалж тогтооход чиглэгдэнэ. Тодорхой цаг хугацааны дарааллаар нөхцөл байдлын өрнөлийг жагсааж гаргасан судалгааг үнэлгээнд хэрэглэнэ.

3.5.3.4.тохиолдол судлах-хууль тогтоомж (түүний зүйл, хэсэг, заалт), эсхүл үнэлгээний хүрээгээр тогтоосон ижил төстэй эрх зүйн хэм хэмжээ өөр, өөр

орчин нөхцөлд (бусад улсад, өөр орон нутагт гэх мэт) хэрэгжиж байгаа байдлыг харьцуулан дүн шинжилгээ хийхийг хэлнэ.

Е. Шалгуур үзүүлэлтийг томьёолох

ТБОНӨТХ-ийн хэрэгжилтийн үр дагаврыг тодорхойлоход аргачлалын 3.6-т заасны дагуу шалгуур үзүүлэлтийг дараах байдлаар томьёолов. Үүнд:

- 3.6.1.шалгуур үзүүлэлтийг томьёолох гэдэг нь тогтоосон шалгуур үзүүлэлт бүрээр тодорхой таамаглалыг дэвшүүлэх, эсхүл асуулт тавихыг хэлнэ.

ТБОНӨТХ-д үнэлгээний хийх хүрээ	Таамаглал дэвшүүлсэн асуулт
Нэгдүгээр бүлэг. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн зорилт, үйлчлэх хүрээ	Q1: 1996 оны ТБОНӨТХ-ийн зохицуулалт нь хуулийн зорилтыг хэрэгжүүлэхэд хангалттай байна уу? Q2: 1996 оны ТБОНӨТХ-ийн хүрээ нь төрийн болон орон нутгийн өмчийн бүхий л харилцааг бүрэн зохицуулсан уу?
Хоёрдугаар бүлэг. Төрийн болон орон нутгийн өмчийн ангилал	Q1: 1996 оны ТБОНӨТХ нь 2019 оны нэмэлт өөрчлөлтийн хүрээнд Үндсэн хуулийн 6.2-т туссан “төрийн нийтийн өмч”-ийн үзэл санааг хэрэгжүүлж чадаж байна уу? Q2: 1996 оны ТБОНӨТХ нь өмчийн төрөлтэй уялдсан өмчийн удирдлагын тогтолцоог бүрдүүлсэн үү?
Гуравдугаар бүлэг. Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлага	Q1: 1996 оны ТБОНӨТХ дахь өмчийн удирдлагын үр ашиг болон зардлын харьцаа зохистой байна уу? Q2: 1996 оны ТБОНӨТХ нь өмч хариуцсан байгууллагын эрх зүйн баталгааг бүрдүүлсэн үү?
Дөрөвдүгээр бүлэг. Төрийн болон орон нутгийн өмчийн эзэмшигчийн ангилал	Q1: Төрийн өмчит хуулийн этгээдийн ангилал Иргэний хууль, бусад хуультай нийцтэй юу?
Тавдугаар бүлэг. Төрийн болон орон нутгийн өмчид хөрөнгө олж авах, захиран зарцуулах	Q1: Төрийн болон орон нутгийн өмчид хөрөнгө олж авах харилцааг бүрэн зохицуулж чадсан уу?
Зургаадугаар бүлэг. Төрийн болон орон нутгийн өмчийг захиран зарцуулах арга	Q1: Төрийн болон орон нутгийн өмчийг захиран зарцуулах аргыг нарийвчлан зохицуулах шаардлагатай юу?
Долдугаар бүлэг. Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, тооллого	Q1: Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, тооллого бүрэн хийгдэж чадаж байгаа юу?

Наймдугаар бүлэг. Төрийн болон орон нутгийн өмчийн хяналт	Q1: Төрийн болон орон нутгийн өмчид тавих төрийн хяналтын тогтолцоо бүрдсэн үү?
Есдүгээр бүлэг. Төрийн болон орон нутгийн өмчийн тайлагнал, мэдээллийн сан	Q1: Төрийн болон орон нутгийн өмчийн тайлагнал ба мэдээллийн сангийн тогтолцоо бүрдсэн үү?

- 3.6.2.хэрэгжилтийг нь шалгаж үнэлгээ хийх гэж байгаа хууль тогтоомжийн бүтэц, агуулга, зохицуулалтын шинж чанар, онцлогоос хамааран аль тохиромжтой буюу түүгээр хэрэгжилтийн үр нөлөө, үр дагавар нь гарч ирэх шалгуур үзүүлэлтийг сонгоно.

ТБОНӨТХ-д үнэлгээний хийх хүрээ	Сонгосон шалгуур үзүүлэлт
Нэгдүгээр бүлэг. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн зорилт, үйлчлэх хүрээ	3.4.1.зорилгод хүрсэн түвшин 3.4.5.практикт нийцэж байгаа байдал 3.5.3.2.хууль тогтоомж батлагдахаас өмнөх болон хууль тогтоомж батлагдсанаас хойш
Хоёрдугаар бүлэг. Төрийн болон орон нутгийн өмчийн ангилал	3.4.4.хүлээн зөвшөөрөгдсөн байдал 3.4.5.практикт нийцэж байгаа байдал 3.5.3.3.хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш
Гуравдугаар бүлэг. Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлага	3.4.3.зардал-үр өгөөжийн харьцаа 3.4.4.хүлээн зөвшөөрөгдсөн байдал 3.4.5.практикт нийцэж байгаа байдал 3.5.3.4.тохиолдол судлах
Дөрөвдүгээр бүлэг. Төрийн болон орон нутгийн өмчийн эзэмшигчийн ангилал	3.4.1.зорилгод хүрсэн түвшин 3.4.5.практикт нийцэж байгаа байдал
Тавдугаар бүлэг. Төрийн болон орон нутгийн өмчид хөрөнгө олж авах, захиран зарцуулах	3.4.5.практикт нийцэж байгаа байдал 3.5.3.4.тохиолдол судлах

Зургаадугаар бүлэг. Төрийн болон орон нутгийн өмчийг захиран зарцуулах арга	3.4.5.практикт нийцэж байгаа байдал 3.5.3.4.тохиолдол судлах
Долдугаар бүлэг. Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, тооллого	3.4.1.зорилгод хүрсэн түвшин 3.4.5.практикт нийцэж байгаа байдал
Наймдугаар бүлэг. Төрийн болон орон нутгийн өмчийн хяналт	3.4.1.зорилгод хүрсэн түвшин 3.4.5.практикт нийцэж байгаа байдал
Есдүгээр бүлэг. Төрийн болон орон нутгийн өмчийн тайлагнал, мэдээллийн сан	3.4.5.практикт нийцэж байгаа байдал

Ү. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

ТБОНӨТХ-ийн хэрэгжилтийн үр дагаврыг тодорхойлоход аргачлалын 3.7-т заасны дагуу мэдээлэл цуглуулах аргыг сонгов. Үүнд:

3.7.1.хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхэд тоон болон чанарын мэдээлэл;

3.7.3.1.тухайн хууль тогтоомжийг хэрэглэж гаргасан шүүхийн шийдвэр буюу шүүхийн практик, тухайн сэдвээр гарсан мэргэжлийн ном, товхимол, гарын авлага, эмхэтгэл, өгүүлэл, илтгэл, эрдэм шинжилгээ, судалгааны тайлан, статистикийн тоо баримт, хэвлэл мэдээллийн хэрэгслийн эх сурвалж;

II. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

ТБОНӨТХ-ийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ дараах тоон мэдээллийг ашиглав.

1. ТӨБЗГ, Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүү, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд, 2023
2. ТӨБЗГ, Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүү, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд, 2022
3. ТӨБЗГ, Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүү, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд, 2021
4. ТӨБЗГ, Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүү, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд, 2020
5. ТӨБЗГ, Төрийн болон орон нутгийн өмчийн тооллогын нэгдсэн дүн, 1996
6. ТӨБЗГ, Төрийн болон орон нутгийн өмчийн тооллогын нэгдсэн дүн, 2000
7. ТӨБЗГ, Төрийн болон орон нутгийн өмчийн тооллогын нэгдсэн дүн, 2003
8. ТӨБЗГ, Төрийн болон орон нутгийн өмчийн тооллогын нэгдсэн дүн, 2007
9. ТӨБЗГ, Төрийн болон орон нутгийн өмчийн тооллогын нэгдсэн дүн, 2015
10. ТӨБЗГ, Төрийн болон орон нутгийн өмчийн тооллогын нэгдсэн дүн, 2021
11. Нийслэлийн өмчийн газар, Нийслэлийн өмчийн тооллогын нэгдсэн дүн, 2022
12. Нийслэлийн өмчийн газар, Нийслэлийн санхүүгийн тайлангийн нэгтгэл, 2022

ТБОНӨТХ-ийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ дараах чанарын мэдээллийг ашиглав.

Хууль тогтоомж:

1. Монгол Улсын Үндсэн хууль – 1992
2. Иргэний хууль – 2002
3. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль – 1996
4. Төрийн аудитын тухай хууль – 2020
5. Төрийн хяналт шалгалтын тухай хууль – 2003
6. Хууль тогтоомжийн тухай хууль – 2015
7. Монгол Улсын Их Хурлын тухай хууль – 1992
8. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль – 2022
9. Захиргааны ерөнхий хууль – 2015
10. Монгол Улсын Засгийн газрын тухай хууль – 1993
11. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль – 1992
12. Банкны тухай хууль – 2010
13. Боловсролын тухай хууль – 2002
14. Эрүүл мэндийн тухай хууль – 2011
15. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль – 2022
16. Соёлын тухай хууль – 1996
17. Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоол – 2016
18. Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралт, Аж ахуй нэгжийн санхүүгийн тайлан тодруулгыг бэлтгэх заавар

19. Япон улсын Төрийн өмчийн тухай хууль – 1948
20. Бүгд Найрамдах Эстони Улсын Төрийн хөрөнгийн тухай хууль – 2018
21. Бүгд Найрамдах Солонгос Улсын Төрийн өмчийн тухай хууль – 2009

Судалгаа, бусад баримт, мэдээлэл:

1. УИХТГ, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн судалгаа. Хуулийн төслийн ажлын хэсэг. 2021 он;
2. О.Мөнхсайхан, ikon.mn-д өгсөн ярилцлага 2020.06.19 [<https://ikon.mn/n/1x1c>]
3. Б.Цэнгэл, Өмчийн хэмжээ бус үр өгөөж илүү чухал, 2025.03.06 (<https://vip76.mn/content/79203>).
4. Н.Баярмаа, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн төсөлд өгөх санал шүүмж, цуврал №40, 5, (ННФ., 2022).
5. Н.Баярмаа, Газар ба үл хөдлөх хөрөнгө, газрын хэвлийн баялаг ба хувьцаа (ННФ, 2022).
6. Г.Давааням, Япон улсын төрийн өмчийн удирдлага, түүний эрх зүйн зохицуулалт, (ННФ., 2022).
7. Hart, O., Shleifer, A., & Vishny, R. W. The proper scope of government: Theory and an application to prisons. *The Quarterly Journal of Economics*, 112(4), 1127–1161(1997) ; Besley, T., & Ghatak, M. Government versus private ownership of public goods. *The Quarterly Journal of Economics*, 116(4), 1343–1372 (2001).
8. Williamson, Oliver E. Transaction cost economics. In R. Schmalensee & R. D. Willig (Eds.), *Handbook of industrial organization* Vol. 1, pp. 135–182, (1989); Transaction costs, institutions, and economic performance. *International Center for Economic Growth, Occasional Papers* No. 30. ICS Press., 1992).
9. OECD (2024), *OECD Guidelines on Corporate Governance of State-Owned Enterprises 2024*, OECD Publishing, Paris, <https://doi.org/10.1787/18a24f43-en>.
10. OECD (2024), *Ownership and Governance of State-Owned Enterprises 2024*, OECD Publishing, Paris, <https://doi.org/10.1787/395c9956-en>.
11. ЗГХЭГ, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврт хийсэн үнэлгээ, 2022.11.20 (<https://lawforum.parliament.mn/project/344/>).

III. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

Нэгдүгээр бүлэг. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн зорилт, үйлчлэх хүрээ

Q1. 1996 оны ТБОНӨТХ-ийн зохицуулалт нь хуулийн зорилтыг хэрэгжүүлэхэд хангалттай байна уу?

ТБОНӨТХ-ийн 1 дүгээр зүйлд “Энэ хуулийн зорилт нь төрийн болон орон нутгийн өмчийн эрх, төрийн өмчийн эд хөрөнгийн талаар хууль тогтоох, гүйцэтгэх байгууллагын бүрэн эрх, төрийн өмчтэй хуулийн этгээд, түүний албан тушаалтны эрх хэмжээ, төрийн өмчийн талаарх бодлогыг хэрэгжүүлэх байгууллагын үйл ажиллагааны зарчим, журмыг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино” гэжээ. Өөрөөр хэлбэл, уг хууль нь төрийн болон орон нутгийн өмчийн талаарх төрийн байгууллагын эрх хэмжээг тогтооход чиглэсэн хэмээн ойлгож болно.

Мөн ТБОНӨТХ-ийн 10 бүлгийн дотор дараах бүлэг, хуулийн зүйлээр илэрхийлбэл нийт 83 зүйлийн 33 зүйл/32-65 дугаар зүйл/ буюу нийт зохицуулалтын 1/3 нь төрийн өмчийг хувьчлах харилцааг зохицуулсан байна.

- Зургаадугаар бүлэг. Төрийн өмчийн эд хөрөнгийг хувьчлах
- Долдугаар бүлэг. Нийгмийн салбарын өөрчлөлт, шинэчлэл, хувьчлал

Улмаар 1996 оны Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль нь шилжилтийн үеийн төрийн болон орон нутгийн өмчийн талаарх төрийн байгууллагын эрх хэмжээг тогтоох, өмч хувьчлалыг зохицуулахад чиглэсэн хэмээн дүгнэж болохоор байна.

Уг хуулийн хүрээнд төрийн болон орон нутгийн өмчийн хувьчлал өргөн цар хүрээтэй явагдаж ирсэн. Энэ талаар ТӨБЗГ-ын дарга Б.Цэнгэл “Өнгөрсөн 30 жилийн хугацаанд хувьчилж болох бүхнийг хувьчилсан. Магадгүй тухайн үед төрийн болон нийтийн өмчийг хувьчлах, худалдах, зарж борлуулах хандлага илүүтэй баримталж ирсэн байх. Харин одоо төрийн болон нийтийн хэрэгцээнд юуг авч үлдэх вэ гэдгийг анхаарах цаг болжээ.”⁷ гэсэн байдаг.

Харин бусад улсын төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль нь төрийн болон орон нутгийн өмчийн удирдлага, ашиглалт, хамгаалалт, үр ашигтай байдлыг сайжруулахад чиглэсэн өргөн цар хүрээний харилцааг зохицуулж байна. Өөрөөр хэлбэр, төрийн болон орон нутгийн өмчийн үр ашигтай байдал, ашиглалтыг нэмэгдүүлэхэд чиглэдэг хэмээн хэлж болно.

Хүснэгт 2. Зарим улсын төрийн өмчийн хуулийн зорилт

Улс	Хуулийн нэр	Хуулийн зорилго, зорилт	Он
-----	-------------	-------------------------	----

⁷ Б.Цэнгэл, Өмчийн хэмжээ бус үр өгөөж илүү чухал, 2025.03.06 (<https://vip76.mn/content/79203>).

Солонгос Улс	Төрийн өмчийн тухай хууль	Төрийн өмчийн удирдлага, ашиглалт, хамгаалалтыг зохицуулах, <u>төрийн өмчийн үр ашигтай ашиглалтыг хангах.</u>	2009 он
Эстони Улс	Төрийн өмчийн тухай хууль	Төрийн өмчийн удирдлага, ашиглалт, захиран зарцуулалтыг зохицуулах, <u>төрийн өмчийн үр ашигтай ашиглалтыг дэмжих.</u>	1995 он
Япон улс	Төрийн өмчийн тухай хууль	Төрийн өмчийн зохистой удирдлага, ашиглалт, хамгаалалтыг хангах, <u>төрийн өмчийн нэгдмэл, одоогийн хэмжээ болон нөхцөл байдлыг тодорхой болгох,</u> мөн тэдгээрийн удирдлага, ашиглалт, хамгаалалтын талаар шаардлагатай зохицуулалтыг хийх.	1948 он
Герман улс	Холбооны өмчийн тухай хууль	Холбооны өмчийн удирдлага, ашиглалт, хамгаалалтыг зохицуулах, улмаар төрийн өмчийг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах, нийтийн ашиг сонирхолд нийцүүлэн удирдах эрх зүйн үндсийг бүрдүүлэх.	1961 он

Ийнхүү Монгол улсын хувьд төрийн болон орон нутгийн өмчийн зохицуулалтын хүрээнд шилжилтийн үеийн зохицуулалтаас төрийн болон орон нутгийн өмчийг зохистой удирдах, үр ашгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн эрх зүйн шинэчлэлийг хийх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Q2. 1996 оны ТБОНӨТХ-ийн хүрээ нь төрийн болон орон нутгийн өмчийн бүхий л харилцааг бүрэн зохицуулсан уу?

Монгол улс зах зээлийн харилцаанд шилжсэнээс хойш төр өөрийн өмчийг удирдах, эсхүл шинээр хөрөнгө олж авах замаар эдийн засгийн харилцаад нөлөө бүхий өмчлөгч хэвээр байна. 1996 онд ТБОНӨТХ батлагдах үед 1,531.9 тэрбум төгрөгийн өмчтэй байсан бол 2021 оны байдлаар 79,896.6 тэрбум төгрөг хүрсэн буюу шууд нэрлэсэн дүнгээр бодвол төрийн өмч ойролцоогоор 52 дахин нэмэгдсэн байна.⁸

График 1. Төрийн болон орон нутгийн өмчийн өсөлт

⁸ ТӨБЗГ, Төрийн болон орон нутгийн өмчийн тооллогын нэгдсэн дүн, 2, (2021).



Ялангуяа, 2024 онд Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг баталсан нь цаашид зах зээлийн харилцаан дахь төрийн өмчит хуулийн этгээдийн байр суурь, үүрэг ролийг баталгаажуулсан хэмээн хэлж болно.

2023 оны жилийн эцсийн байдлаар төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь 64,200.5 тэрбум төгрөгийн хөрөнгө эзэмшиж, 23,617.9 тэрбум төгрөгийн орлого олж, 4,983.2 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилсан байна.⁹ Өөрөөр хэлбэл, эндээс төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн орлого нь 2023 оны улсын төсвийн орлого /19.4 их наяд/-аас ойролцоогоор 4 их наяд төгрөгөөр илүү байгааг харж болно.

Ийнхүү төр улсын төсвөөс гадуур их хэмжээний мөнгөн бус хөрөнгийг өмчилж байгаа тул төрийн өмчийг зохистой удирдах, үр өгөөжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн эрх зүйн орчныг бүрдүүлэх хэрэгцээ шаардлага өндөр байна. 1996 оны ТБОНӨТХ нь өмнө дурдсанчилан шилжилтийн үеийн харилцааг зохицуулахад чиглэсэн бөгөөд төрийн өмчийн харилцааг бүрэн зохицуулж чадаагүй байна. Тухайлбал, Өмчийн удирдлагын хүрээнд УИХ, Засгийн газар, ТӨБЗГ-ын өмчийг удирдах бүрэн эрх ойлгомжгүй, уялдаа холбоо тааруу, төрийн өмчийг эзэмшиж буй төрийн байгууллага, албан газар, компанийн эд хөрөнгийн эрх тодорхойгүй, төрийн өмчит хөрөнгө олж авах хязгаарлалт байхгүй, төрийн өмчийг захиран зарцуулах харилцааг шинж чанараар нь бус гэрээний төрлөөр шууд тулган зааж, өмчийн захиран зарцуулах уяан хатан байдлыг хязгаарласан, төрийн өмчийг бусдад шилжүүлэх, ашиглуулах арга нь ойлгомжгүй, уялдаа холбоо тааруу, төрийн өмчийн бүртгэл, тооллого, тайлагнал, хяналт, мэдээллийн тогтолцоо нь зөвхөн өөрийн өмчөөр хязгаарлагдсан зэрэг асуудлыг дурдаж болохоор байна.

⁹ ТӨБЗГ, Төрийн өмчит блон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүү, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд, 4, (2023) /https://pcsp.gov.mn/files/statistic/FR_BOOK_2023_Final.pdf/

Хүснэгт 3. ТБОНӨТХ-ийн хүрээ

№	Төрийн өмчийн харилцаа	Хуулийн зохицуулалтын хүрээ	(+/-)
1	Төрийн өмчийн ангилал	Хоёрдугаар бүлэг. Өмчийн зүйлс	+
2	Төрийн өмчийн удирдлага	Гуравдугаар бүлэг. Өмчийн удирдлага	+/-
3	Төрийн өмчийг эзэмших этгээд	Дөрөвдүгээр бүлэг. Төрийн өмчийн хуулийн этгээд, түүний эд хөрөнгийн эрх	+/-
4	Төрийн өмчид хөрөнгө олж авах	Тавдугаар бүлэг. Төрийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах	+/-
5	Төрийн өмчийг захиран зарцуулах хэлбэр	Зургаадугаар бүлэг. Төрийн өмчийн эд хөрөнгийг хувьчлах	+/-
6	Төрийн өмчийг захиран зарцуулах арга	Зургаадугаар бүлэг. Төрийн өмчийн эд хөрөнгийг хувьчлах	+/-
7	Төрийн өмчийг хадгалах, хамгаалах	Долоодугаар бүлэг. Нийгмийн салбарын өөрчлөлт, шинэчлэл, хувьчлал	+/-
8	Төрийн өмчийн бүртгэл	Наймдугаар бүлэг. Төрийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад тавих хяналт шалгалт, бүртгэл, тооцоо	+/-
9	Төрийн өмчийн тооллого	70, 71, 72, 73 дугаар зүйл	+/-
10	Төрийн өмчийн тайлагнал	8.1.2, 9.1.8 /улсын нэгдсэн тооллогын тайлан/	+/-
11	Төрийн өмчийг данснаас хасах	31 дүгээр зүйл	+/-
12	Төрийн өмчийн хяналт	66, 67 дугаар зүйл	+/-
13	Төрийн өмчийн мэдээллийн сан	-	-

Мөн орон нутгийн хувьд Үндсэн хуулийн 58.1-д “1.Аймаг, нийслэл, сум, дүүрэг бол хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор мөн” хэмээн заасан. Энэ ч утгаараа, Үндсэн хуулийн 59 дүгээр зүйлийн 2-т “Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд өмчийн удирдлагыг хэрэгжүүлэх эрхтэй” гэж хэмээн зааж, өмчлөгчийн эрхийг нь баталгаажуулсан байдаг.

Энэ хүрээнд 1996 онд ТБОНӨТХ батлагдах үед өөртөө өмчлөлийн хөрөнгүй байсан орон нутаг нь эдийн засгийн цогцолбор болохын хувьд 2021 оны байдлаар 11.901 тэрбум төгрөгийн хөрөнгийг өмчлөх болжээ (график 1-ийг үзнэ үү). Нийслэлийн хувьд дангаараа 4.84 тэрбум буюу нийт орон нутгийн өмчийн 1/3-ээс илүү хувийг өмчилж байна. Харин бодит байдал дээр сум, дүүрэг өөрийн өмчлөлийн хөрөнгөгүй байгаа нь Үндсэн хуулийн үзэл санааг амьдар дээл буулгах ТБОНӨТХ-ийн зохицуулалт дутмаг байгаа илтгэж байна.

Хүснэгт 4. Нийслэлийн өмчийн хөрөнгийн нэгдсэн дүн / мян.төг/¹⁰

Д/д	Дүүргийн нэрс	Хуулийн этгээдийн тоо	Балансын дүн
1	Багануур	41	228,635,661.54
2	Багахангай	24	34,912,628.76
3	Баянгол	106	434,889,144.53
4	Баянзүрх	154	1,348,842,624.5
5	Налайх	45	176,365,956.65
6	Сонгинохайрхан	149	628,115,688.11
7	Сүхбаатар	115	617,037,666.33
8	Хан-Уул	103	513,818,900.96
9	Чингэлтэй	132	856,641,673.4
Нийт		869	4,839,259,944.79

Орон нутгийн өмчийн эрх зүйн үндэсийг 2020 онд батлагдсан Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль (ЗЗНДНТУТХ)-аар бэхжүүлсэн. Энэ нь цаашид аймаг, нийслэл төдийгүй сум, дүүрэг нь өөрийн чиг үүргийн хүрээнд өөртөө хөрөнгийг олж авч, бие даасан эдийн засгийн цогцолбор болон хөгжих боломжийг бүрдүүлсэн хэмээн ойлгож болно.

ЗЗНДНТУТХ-ийн 18.1-д “Аймаг, сум, нийслэл, дүүрэг нь өмчтэй байна.”, 18.2-д “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн өмчийн хувьд өмчлөгчийн эрхийг хуульд заасан хязгаарын хүрээнд тухайн нэгжийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, өмчийн удирдлагыг тухайн нэгжийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас олгосон эрх хэмжээний хүрээнд Засаг дарга хэрэгжүүлнэ.” хэмээн зохицуулсан.

¹⁰ Нийслэлийн өмчийн газар, 2021 оны 12 сарын 31-ны өдрийн санхүүгийн тайлангын дүнгээр тасалбар болгосон Нийслэлийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогын дүнгийн танилцуулга, 2023.

Улмаар уг хуулийн 18.4-д “Орон нутгийн өмчийн харилцааг хуулиар зохицуулна.” гэжээ.

Гэсэн хэдий ч, 1996 оны ТБОНӨТХ нь орон нутгийн өмчийн харилцааг зөвхөн есдүгээр бүлгээр зохицуулжээ. Өөрөөр хэлбэл, орон нутгийн өмчийг удирдах, үр ашгийг нэмэгдүүлэхтэй холбогдох харилцаа нь зохицуулалтын хувьд тодорхойгүй байдалд хүрсэн. Энэ хүрээнд **нэгдүгээрт** өнөөгийн байдлаар сум, дүүрэг нь хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх өөрийн өмчлөлийн хөрөнгөгүй хэвээр байна, **хоёрдугаарт**, аймаг, нийслэлийн өмчийн харилцааны зохицуулалт нь тухайн шатны нэгжээс гаргасан хэм хэмжээний актын хүрээнд өөр хоорондоо ялгаатай байдлаар хийгдэж, нийтийн өмч алдагдах, үр ашиггүй болох нөхцөл бүрдсэн байна.

Мөн орон нутгийн өмчийн нийтлэг харилцаа буюу өмчийн захиран зарцуулах хэлбэр, арга, өмчийн хадгалах, хамгаалах, бүртгэл, тооллого, тайлагнал, данснаас хасах, хяналт, мэдээллийн санд хамаарах нарийвчсан хуулийн зохицуулалт тусаагүй байна.

Хүснэгт 5. 1996 оны ТБОНӨТХ-ийн хүрээ

№	Орон нутгийн өмчийн харилцаа	Хуулийн зохицуулалт хүрээ	(+/-)
1	Өмчийн ангилал	74 дүгээр зүйл	+
2	Өмчийн удирдлага	77 дүгээр зүйл 78 дугаар зүйл	+/-
3	Өмчийг эзэмших этгээд	79 дүгээр зүйл	+/-
4	Орон нутгийн өмчид хөрөнгө олж авах	75 дугаар зүйл	+/-
5	Өмчийг захиран зарцуулах хэлбэр	79 дүгээр зүйл /төрийн өмчийн зохицуулалтаас эш татсан хэдий ч, хэрэглэх боломжгүй/	+/-
6	Өмчийг захиран зарцуулах арга	-	-
7	Өмчийг хадгалах, хамгаалах	-	-
8	Өмчийн бүртгэл		-
9	Өмчийн тооллого	-	-
10	Өмчийн тайлагнал	-	-

11	Өмчийг данснаас хасах	-	-
12	Өмчийн хяналт	77.1	+-
13	Өмчийн мэдээллийн сан	-	-

Ийнхүү Үндсэн хууль дахь орон нутаг эдийн засгийн цогцолбор байх үзэл санааг хэрэгжүүлэх хүрээнд батлагдсан ЗЗНДНТУТХ-ийн 18.4-т Орон нутгийн өмчийн харилцааг хуулиар зохицуулахаар тусгасан хэдий ч, орон нутгийн өмчийн харилцаанд хамаарах хуулийн зохицуулалт хангалтгүй байна.

Түүнчлэн ТБОНӨТХ нь төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг тодорхойлохдоо хуулийн бүхий зүйл заалт дээр “эд хөрөнгө” гэсэн хууль зүйн нэр томъёог хэрэглэсэн байна. Харин төрийн болон орон нутгийн өмчийг багтаасан өмчийн суурь хууль болох 2002 оны Иргэний хуулийн 84.4-т “Эд хөрөнгө нь үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө байна” хэмээн тусгасан байдаг.

Хүснэгт 6. Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тоо (2021)

Хувьцааны эзэмшил / хэлбэр	ХК	ХХК
Төрийн өмчит	56	34
Орон нутгийн өмчит	13	76
	69	101
	170	

Өөрөөр хэлбэл, ТБОНӨТХ-ийн зохицуулалт нь төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгөөр хязгаарласан буюу Иргэний хууль дахь хөрөнгийн агуулгыг явцуу утгаар хуулчилсан хэмээн дүгнэж болохоор байна. Тухайлбал, эдийн бус хөрөнгийн ангилалт хамаарах төр болон орон нутгийн эзэмшлийн хувьцааг авч үзвэл нь нийт 170 компанид хувьцаа эзэмшиж байна.¹¹

Хоёрдугаар бүлэг. Төрийн болон орон нутгийн өмчийн ангилал

Q1. 1996 оны ТБОНӨТХ нь 2019 оны нэмэлт өөрчлөлтийн хүрээнд Үндсэн хуулийн 6.2-т туссан “төрийн нийтийн өмч”-ийн үзэл санааг хэрэгжүүлж чадаж байна уу?

ТБОНӨТХ-ийн 4.1-д “Үндсэн хууль, бусад хуулиар нийтийн зориулалтаар ашиглахаар бүх ард түмний өмч болгон заасан зүйлсийг

¹¹ ТӨБЗГ, Улсын нэгдсэн тооллогын тайлан, 5, (2021).

төрийн нийтийн зориулалттай өмч гэнэ.” гэжээ. Үүнд дараах үл хөдлөх, хөдлөх хөрөнгө хамаарахаар байна.

- 1/ иргэдэд өмчлүүлснээс бусад газар;
- 2/ газрын хэвлий, түүний баялаг;
- 3/ ус, түүний доторх баялаг;
- 4/ ой, түүний дагалдах баялаг;
- 5/ ургамал, ан амьтны нөөц;
- 6/ түүх, соёлын үнэт цогцолбор, хөшөө дурсгал;
- 7/ археологийн болон палентологийн олдвор;
- 8/ хуулиар нийтийн зориулалтаар ашиглахаар тогтоосон бусад эд хөрөнгө.

Улмаар тус хуулийн 4.3-т “Төрийн нийтийн зориулалттай өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхийг Улсын Их Хурал хэрэгжүүлэх ба үүнтэй холбогдон үүсэх харилцаанд энэ хууль үйлчлэхгүй”,

4.4-т “Төрийн нийтийн зориулалттай өмчлөлийн зүйлсийг хуульд заасан нөхцөл, журмын дагуу иргэн /Монгол улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн/, бусад өмчийн хуулийн этгээдэд эзэмшүүлж, ашиглуулж болно” хэмээн зохицуулжээ.

Гэсэн хэдий ч, ТБОНӨТХ-ийн 4.1 дэх хэсгийн “төрийн нийтийн зориулалттай өмч”-ийн хүрээ нь зөвхөн хөдлөх эд хөрөнгө, үл хөдлөх эд хөрөнгөд хамаарахаар байгаа нь оновчгүй байна. Өөрөөр хэлбэл, зах зээлийн харилцаа хөгжихийн хэрээр аливаа баялгийг эдийн бус хөрөнгө хэлбэрээр удирдах нь зайлшгүй зүйл болсон. Энэ ч утгаараа, Үндсэн хуулийн 6.2-т “...газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ.”, “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндэсийг хуулиар тогтооно” хэмээн заажээ.

Улмаар 2024 онд батлагдсан Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 12.5-т “Орлого төвлөрүүлэгч хуулийн этгээд нь 100 хувь төрийн өмчит компани байх бөгөөд хувьцааг Засгийн газар эзэмшинэ.”, 12.7-т “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн хувьцааг орлого төвлөрүүлэгч хуулийн этгээд эзэмшинэ” заасан нь компанийн хувьцааг Засгийн газар эзэмших буюу төрийн нийтийн өмчид хамаарах эдийн бус хөрөнгийг хүлээн зөвшөөрсөн байна.

Мөн ТБОНӨТХ-ийн 4.1 дэх хэсгийн “төрийн нийтийн зориулалттай өмч”-ийн жагсаалтад Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 4.1.1-т заасан “Үндэсний баялгийн сан”, Эрдэнэсийн сангийн тухай хуулийн 3.1.4-д заасан “Эрдэнэсийн сан”, Агаарын зайг нисэхэд ашиглах тухай хуулийн 4.1.1-д заасан “Монгол улсын агаарын зай”, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 4.1.10-т заасан “үндэсний архивын сан хөмрөг” зэрэг нь тусаагүй байгаа нь анхаарал татаж байна. Эдгээр хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхийг гагцхүү Улсын Их Хурал хуулиар тогтоох бөгөөд үүнтэй холбогдон үүсэх харилцаанд ТБОНӨТХ үйлчлэхгүй

байх шинжээрээ Үндсэн хуульд заасан “төрийн нийтийн өмч”-ийн ангилалд хамаарахаар байна.

Харин төрийн өөрийн өмч буюу ТБОНӨТХ-ийн 5.1.4-т “улсын төсвийн хөрөнгө”-ийг хамааруулан зохицуулсан нь анхаарал татаж байна. Өөрөөр хэлбэл, “улсын төсөв” нь Улсын Их хурлаас баталсан Төсвийн тухай хууль”-иар зохицуулагдах бөгөөд “улсын төсөвт хамаарах мөнгөн хөрөнгийг удирдах, хуваарилах харилцааг ТБОНӨТХ-иар зохицуулах боломжгүй юм.

Мөн 1996 оны ТБОНӨТХ дахь “төрийн нийтийн зориулалттай өмч” гэсэн хууль нэр томъёог Үндсэн хуулийн 6.2 дахь хэсгийн “төрийн нийтийн өмч” гэсэн хууль зүйн нэр томъёонд нийцүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Үүнээс гадна “төрийн нийтийн өмч”-ийн жагсаалтыг өргөжүүлэх нь зохистой байна.

Q2. 1996 оны ТБОНӨТХ нь өмчийн төрөлтэй уялдсан өмчийн удирдлагын тогтолцоог бүрдүүлсэн үү?

Төрийн өмчийн удирдлага

ТБОНӨТХ нь төрийн өмчийг “төрийн нийтийн зориулалттай өмч” болон “төрийн өөрийн өмч” хэмээн хоёр ангилж, “төрийн нийтийн зориулалттай өмч”-ийн харилцааг гагцхүү УИХ-аас хуулиар тусгайлан зохицуулахад ач холбогдол өгсөн байна. Энэ ч утгаараа ТБОНӨТХ нь “төрийн өөрийн өмч”-ийн харилцааг зохицуулахад түлхүү анхаарсан хэмээн дүгнэж болохоор байна.

ТБОНӨТХ-ийн 5.1-д “Төрийн өөрийн өмчид энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаас бусад төр эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулж болох дараахь эд хөрөнгө хамаарна” гэжээ. Үүнд

- 1/ төрийн байгууллага, албан газарт эзэмшүүлсэн эд хөрөнгө;
- 2/ төрийн өмчит үйлдвэрийн газарт эзэмшүүлсэн эд хөрөнгө;
- 3/ төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн төрд ногдох хувь хөрөнгө;
- 4/ улсын төсвийн хөрөнгө болон төрийн бусад тусгай сан;
- 5/ төрийн тусгай хэрэгцээний бэлтгэл нөөц;
- 6/ хуульд заасан бусад төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгийн үл хөдлөх болон хөдлөх хөрөнгө.

Мөн 5.2. “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг аж ахуйн зориулалтаар нь Нөхөрлөл, компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу үндсэн ба эргэлтийн хөрөнгө гэж хуваана.” 5.3. “Төрийн өөрийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулахтай холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулна” гэжээ.

Өөрөөр хэлбэл, төрийн өөрийн өмч гэдэг нь төрийн байгууллага, албан газар, төрийн өмчит компани хууль болон дүрэмд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор өөрөө өмчилж, удирдах хөрөнгийг илэрхийлж байна. Төрийн нийтийн өмчөөс ялгаатай энэ ангилалд хамаарах төрийн өмчийг удирдах харилцааг гагцхүү УИХ-аас хуулиар тогтоох шаардлагагүй бөгөөд ТБОНӨТХ-д заасан үндэслэл, журмын дагуу холбогдох этгээд шийдвэрлэхээр зохицуулахыг зорьжээ.

Гэсэн хэдий ч, ТБОНӨТХ-ийн суурь бүтэц, үзэл санаа нь 34 удаагийн нэмэлт өөрчлөлтийн явцад төрийн өмчийн төрлөөс хамаарч ялгамжтай байдлаар, уян хатан үйлчлэх шинж чанараа алдсан байхаас гадна бусад төрийн байгууллагад олон тооны журам батлах эрхийг шилжүүлэх байдлаар хуулийн суурь бүтэц, бүрэн эрхийн хуваарилалт алдагдсан байна. Тухайлбал, **нэгдүгээрт**, ТБОНӨТХ-ийн 8.1.4-т төрийн өмчийг бусдад барьцаалуулах шийдвэрийг УИХ-аас, бусдад шилжүүлэх шийдвэрийг 9.1.3-т заасны дагуу Засгийн газраас гаргах байдлаар өөрчлөн найруулж, бүрэн эрхийн хуваарилалтыг ойлгомжгүй болгосон. **Хоёрдугаарт**, төрийн байгууллага, албан газар, төрийн өмчит компани өөрийн өмчлөлийн эд хөрөнгө (эд хогшилд зэрэг хөдлөх эд хөрөнгө)-ийн захиран зарцуулах эрхийг хязгаарлаж, гүйлгээнд орох боломжийг хаасан, **Гуравдугаарт**, Төрийн өмчийг удирдах хүрээнд Засгийн газраас баталсан журам, ТӨБЗГ-аас баталсан журам үйлчилж, өмчийн эзэнгүй, үр ашиггүй байдал үүсэж байна.

Хүснэгт 7. 1996 оны ТБОНӨТХ-ийн хүрээнд гарсан журмууд

Засгийн газрын журам	
1	Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журам, 2001
2	Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам, 2023
3	Төрийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулах нийтлэг журам, 2023
ТӨБЗГ-ын журам	
Эд хөрөнгөд хамаарах нийтлэг	
1	“Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам батлах тухай” 2019 оны 271 дүгээр тогтоол
2	“Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 2019 оны 268 дугаар тогтоол
Бусдад ашиглуулах	
1	Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн доод хязгаар, түрээсийн зарим төлбөрийн хэмжээг тогтоох заавар, улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хувь хэмжээг шинэчлэн батлах тухай, 2020

2	Түрээслэгчийг сонгон шалгаруулалтын жишиг баримт бичиг батлах тухай, 2020
3	Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн талаар авах зарим арга хэмжээний тухай, 2020
4	Төрийн өмчит хуулийн этгээдийн бусдаас түрээслэх байр талбайн талаар авах арга хэмжээний тухай, 2023
5	Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний маягт, дүгнэх аргачлал батлах тухай, 2020

Иймээс төрийн өмчийг бусдад шилжүүлэх, ашиглуулахад холбогдох суурь зохицуулалтыг журмаар бус ТБОНӨТХ-д тусгаж хууль тогтоомжийн тодорхой байдал, нэгдмэл байдлыг хангах шаардлага үүсч байна.

УИХ өмчийг удирдах бүрэн эрх

УИХ бүх ард түмнийг төлөөлөн төрийн өмчийн өмчлөгч байх этгээд байдаг. Энэ ч утгаараа, төрийн нийтийн өмчийг удирдах бүрэн эрхийг гагцхүү УИХ-д хадгалсан байна.

Хүснэгт 8. ТБОНӨТХ дахь өмчийг удирдах шийдвэр

ТБОНӨТХ-ийн дагуу УИХ-аас шийдвэр гаргах
8 дугаар зүйл. Төрийн өмчийн талаархи Улсын Их Хурлын бүрэн эрх 8.1.4/ төрийн өмчийг барьцаалах, орон нутгийн өмчид шилжүүлэх тухай шийдвэр гаргах; 30 дугаар зүйл. Төрийн өмчийн эд хөрөнгийг үнэ төлбөргүй шилжүүлэх 1. Төрийн өмчийн эд хөрөнгийг орон нутгийн өмч бүрдүүлэх зорилгоор үнэ төлбөргүй шилжүүлэх асуудлыг гагцхүү Улсын Их Хурал шийдвэрлэнэ.
ТБОНӨТХ-ийн дагуу өөртөө буюу УИХ-д эрх хадгалсан
28 дугаар зүйл. Төрийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх 28.1.Төрийн нийтийн зориулалттай өмчийг түрээслүүлэх журмыг Улсын Их Хурал

УИХ-аас өмчийг удирдах хүрээнд дараах асуудал үүсэж байна. **Нэгдүгээрт**, УИХ төрийн өмчийг барьцаалуулах шийдвэрийг гаргах нь бодит байдалд нийцэхгүй байна. Ялангуяа, ТӨК-иудын хувьд өөрийн эзэмшлийн зүйлийг бусдад барьцаалуулах замаар санхүүжилт татах хэрэгцээ шаардлага байгаа хэдий ч, УИХ-аас шийдвэр гаргах нь хугацаа шаардах тул энэхүү заалт нь хэрэглэгдэхэд хүндрэлтэй байдаг. Улмаар ирээдүйд бий болох үр ашгийг барьцаалуулах арга замыг сонгох тохиолдол байна. Үүнд

- 1) 2015 онд “**Эрдэнэт үйлдвэр**” баяжмал борлуулах гэрээний орлогыг барьцаалуулах замаар зээл авсан;
- 2) 2017 онд “**Газрын тос үйлдвэрлэх газар**” ирээдүйд ирээдүйд олох ашгийг барьцаалуулах замаар Хөгжлийн банкаас зээл авсан;
- 3) 2018 онд “**ТЭЦ-4**” өргөтгөлийг улсын төсвөөс санхүүжүүлэх боломжгүй байсан тул ирээдүйд олох ашгийг барьцаалуулах замаар зээл авсан.

Харин төрийн нийтийн өмчийг удирдах харилцаа нь Үндсэн хууль болон ТБОНӨТХ-д заасны дагуу УИХ-ын бүрэн эрхэд хамаарах тул төрийн нийтийн өмчийг бусдад барьцаалуулах шийдвэрийг УИХ-д гаргах нь зохистой байж болно.

Хоёрдугаарт, стратегийн ач холбогдол бүхий салбар дахь төрийн өмчит компанийн төрийн эзэмшлийн хувьцааг бусдын өмчлөлд шилжүүлэх, барьцаалуулах шийдвэрийг УИХ-д хадгалах асуудал чухлаар тавигдана. Өнөөгийн эрх зүйн орчны хувьд Засгийн газар болон түүний харьяа хуулийн этгээд нь стратегийн ач холбогдол бүхий салбар дахь төрийн өмчит компанийн төрийн эзэмшлийн хувьцааг эзэмшиж байгаа тул хувьцаа эзэмшигчийн хувиар КТХ-д заасны дагуу дангаар шийдвэр гаргах эрх зүйн боломжтой бий.

Иймээс Үндсэн хуульд заасан “төрийн нийтийн өмч”-ийн үзэл санааны хүрээнд **нэгдүгээрт** төрийн бүхий л өмчийг бусдад барьцаалуулах шийдвэрийг УИХ-д хадгалсан зохицуулалтыг төрийн нийтийн өмчийг удирдах харилцаатай уялдуулан эргэж харах, **хоёрдугаарт** стратегийн ач холбогдол бүхий салбар дахь төрийн өмчит компанийн төрийн эзэмшлийн хувьцааг бусдын өмчлөлд шилжүүлэх, барьцаалуулах шийдвэрийг УИХ-ийн бүрэн эрхэд хамааруулах асуудлыг анхаарах шаардлагатай байна.

Засгийн газар өмчийг удирдах бүрэн эрх

ТБОНӨТХ-ийн хүрээнд Засгийн газар нь 1) УИХ-аас эрх олгосон төрийн нийтийн өмчийг хууль тогтоомжид заасны дагуу удирдах, 2) төрийн өөрийн өмчийн ангилалд хамаарах үл хөдлөх эд хөрөнгийг бусдад шилжүүлэх шийдвэрийг гаргах 3) төрийн өмчийг бусдад ашиглуулахад баримтлах журмыг батлах бүрэн эрхтэй байна.

ТБОНӨТХ-д заасны дагуу Засгийн газраас шийдвэр гаргах
9 дүгээр зүйл. Төрийн өмчийн талаархи Засгийн газрын бүрэн эрх 9.1.3/ төрийн өөрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг <u>хувьчлалаас гадуур худалдах, шилжүүлэх тухай шийдвэр гаргах;</u> 30 дугаар зүйл. Төрийн өмчийн эд хөрөнгийг үнэ төлбөргүй шилжүүлэх 2. Төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгө, хуулийн этгээдийн эрх хэмжээнд хамааруулснаас бусад хөдлөх хөрөнгийг Засгийн газрын шийдвэрээр, Засгийн газраас зөвшөөрөл олгосон тохиолдолд төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын шийдвэрээр шилжүүлж болно.

ТБОНӨТХ-ийн дагуу Засгийн газарт эрх шилжүүлсэн
9 дүгээр зүйл. Төрийн өмчийн талаархи Засгийн газрын бүрэн эрх 9.1.2/ төрийн өмчит хуулийн этгээдийн өөрт олгогдсон эд хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах хэмжээ, хязгаарыг энэ хуульд нийцүүлэн тогтоох; 28 дугаар зүйл Төрийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журмыг Иргэний хуульд нийцүүлэн Засгийн газар тогтооно.
ТБОНӨТХ-ийн 28.1-д Засгийн газарт эрх олгосоны дагуу баталсан журам
Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журам, №134 2001 Зөвшөөрөл олгох тухай, №68 тогтоол, 2019

Гэсэн хэдий ч, 1) үл хөдлөх эд хөрөнгөтэй дүйцэхүйц үнэ цэн, ач холбогдол бүхий хөдлөх эд хөрөнгө, эдийн бус хөрөнгийг бусдад шилжүүлэх, 2) үйлдвэр, барилга байгууламжийг цогцолбор байдлаар дагалдах хөдлөх эд хөрөнгө, эдийн бус хөрөнгийн хамт бусдад шилжүүлэх, 3) үл хөдлөх эд хөрөнгийг бусдад шилжүүлэхтэй дүйцэхүйц шинж чанар бүхий эд юмсын хязгаарлагдмал эрхийн үндсэн дээр бусдад ашиглуулах зэрэг тохиолдолд Засгийн газрын бүрэн эрхэд хамаарах эсэх нь тодорхойгүй байна.

Өнөөг хүртэл Засгийн газар нь баланс хооронд шилжүүлэх шийдвэрийг 2020 онд 12, 2021 онд 10, 2022 онд 12, 2023 онд 9, 2024 онд 8 удаа гаргаж байжээ. Энэ нь Засгийн газарт үүсэх ачаалал, зардлын үүднээс авч үзвэл зохистой түвшинд байна. Тухайлбал, 2024 онд дараах үл хөдлөх эд хөрөнгийг шилжүүлэх шийдвэр гаргажээ.

№	Сар, өдөр	Тогтоол	Үл хөдлөх эд хөрөнгө	ТӨБЗГ
1	1/03	1	Хууль үүйн үндэсний хүрээлэнгээс УИХ-ын Тамгын газарт	
2	1/25	32	Хөвсгөл ХХААГ-аас Хөвсгөл Мал эмнэлгийн газарт	
3	1/25	33	Баянхонгор Шүүх шинжилгээний газраас Стандарчилал хэмжил зүйн газарт	
4	1/25	36	Аялал жуулчлалын хөгжлийн төвөөс Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд	эрх шилжүүлсэн
5	5/15	207	Цэргийн хөгжмийн коллежийг Үндэсний батлан хамгаалахын их сургууль	

6	9/25	94	ИНЕГ-аас МИАТ ХК-нд	
7	10/23	141	Монголын далд уурхайн музей- Монголросцветмет ТӨҮГ-т	эрх шилжүүлсэн
8	11/27	193	ИНЕГ-аас ИНҮТ-д	эрх шилжүүлсэн

Мөн ТБОНӨТХ-ийн 30.2-д “хуулийн этгээдийн эрх хэмжээнд хамааруулснаас бусад хөдлөх эд хөрөнгийг Засгийн газрын шийдвэрээр” бусдад шилжүүлэхээр тогтоосон нь зохисгүй байна. Өөрөөр хэлбэл, Засгийн газрын эрх хэмжээнд хамааруулснаас бусад хөдлөх эд хөрөнгийг өмчийн эзэмшигч буюу төрийн байгууллага, албан газар, компани бие даан шийдвэрлэх нь өмчийн удирдлагын үүднээс авч үзвэл оновчтой.

Энэ ч утгаараа, Засгийн газрын 2019 оны №168-р тогтоолын хүрээнд хуулийн этгээдийн эрх хэмжээнд хамааруулснаас бусад төрийн өмчийн хөдлөх хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх эсэх асуудлыг ТӨБЗГ тухай бүр хэлэлцэн шийдвэрлэж байхыг зөвшөөрсөн байна. Энэхүү хуулийн этгээд эрх хэмжээ гэдэг нь өмчийн удирдлагын практикт төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдээр хязгаарлагдаж байгаа буюу төрийн өмчийн компани, төрийн байгууллага, албан газар хамаарахгүй хэмээн ойлгож болно.

ТӨБЗГ өмчийг удирдах бүрэн эрх

ТБОНӨТХ-ийн хүрээнд ТӨБЗГ нь төрийн өмчийн хөдлөх эд хөрөнгийг дуудлага худалдааны үндсэн дээр бусдад шилжүүлэх шийвэр гаргах бүрэн эрхтэй байна. Мөн ТБОНӨТХ-иар эрх шилжүүлж аваагүй хэдий ч, ТӨБЗГ нь төрийн өмчид хөрөнгө олж авах, данснаас хасах, бусдад ашиглуулахад холбогдох журмыг баталж мөрдүүлдэг байна.

ТБОНӨТХ-д заасны дагуу ТӨБЗГ-аас шийдвэр гаргах
28 дугаар зүйл. Төрийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх 28.4. Түрээсэлсэн эд хөрөнгийг худалдах тохиолдолд түрээслэгчид Иргэний хуулийн 105 дугаар зүйлд заасан эрх /тэргүүн ээлжинд худалдан авах/ эдлүүлэх эсэхийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага шийдвэрлэнэ. 29 дүгээр зүйл. Төрийн өмчийн эд хөрөнгийг худалдах 1. төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын... шийдвэрээр гагцхүү дуудлага худалдаагаар худалдаж болно.
ТБОНӨТХ-д заасны дагуу ТӨБЗГ-т эрх шилжүүлээгүй боловч, үйлчилж буй журам

“Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам батлах тухай” 2019 оны 271 дүгээр тогтоол
“Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 2019 оны 268 дугаар тогтоол
Бусдад ашиглуулах
Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн доод хязгаар, түрээсийн зарим төлбөрийн хэмжээг тогтоох заавар, улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хувь хэмжээг шинэчлэн батлах тухай, 2020
Түрээслэгчийг сонгон шалгаруулалтын жишиг баримт бичиг батлах тухай, 2020
Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн талаар авах зарим арга хэмжээний тухай, 2020
Төрийн өмчит хуулийн этгээдийн бусдаас түрээслэх байр талбайн талаар авах арга хэмжээний тухай, 2023
Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний маягт, дүгнэх аргачлал батлах тухай, 2020
Засгийн газрын Зөвшөөрөл олгох тухай, №68 тогтоол, 2019-д заасны дагуу шийдвэр гаргах
Хуулийн этгээдийн эрх хэмжээнд хамааруулснаас бусад төрийн өмчийн хөдлөх хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх

Гэсэн хэдий ч, ТӨБЗГ-ын баталсан журмууд нь ТБОНӨТХ болон бусад хуулиар эрх олгогдоогүй буюу тэдгээрийн хуулийн үндэслэл нь тодорхойгүй байна. Мөн журам гэсэн “хууль зүйн нэр томъёо”-г хэрэглээгүй боловч, төрийн болон орон нутгийн өмчийн харилцааг зохицуулсан “зарим арга хэмжээ авах тогтоол”, гэрээний маягт, аргачлал зэрэг хэм хэмжээний актыг баталж мөрдүүлж байна.

Иймээс журмын хүрээнд тогтсон нийтлэг зохицуулалтыг ТБОНӨТХ-д тусгах, нийгмийн харилцааны өөрчлөлт зэргээс шалтгаалан богино хугацаанд өөрчлөгдөх харилцаа зэргийн хувьд ТБОНӨТХ-иар ТӨБЗГ-т журам батлах эрхийг шилжүүлэх нь зохистой. Өнөөгийн нөхцөл байдал нь тодорхой хэрэг маргааны хүрээнд эрх зүйн тогтворгүй байдлыг дагуулж болохоор байна.

Өмч эзэмшигчийн өмчийг удирдах бүрэн эрх

Төрийн өмч эзэмшигч гэдэг нь төрийн байгууллага, албан газар, төрийн өмчит компани зэрэг төрийн өмч дээр суурилж үйл ажиллагаа явуулж буй этгээдийг илэрхийлнэ. Эдгээр нь төрийн өмчийг өөрийн баланс дээрээ бүртгэж, иргэний эрх зүйн харилцаанд оролцох бөгөөд УИХ, Засгийн газар, ТӨБЗГ-ын эрх хэмжээнд хамааруулаагүй үндсэн хөрөнгөөс бусад хөрөнгөө удирдах бүрэн эрхийг хэрэгжүүлдэг.

Өмчийн эзэмшигч
ТБОНӨТХ-д заасны дагуу ААТҮГ үндсэн хөрөнгөө захиран зарцуулах
16 дугаар зүйл. Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын эд хөрөнгийн эрх 16 дугаар зүйл. Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын эд хөрөнгийн эрх 16.1.2/ үндсэн хөрөнгийг энэ хуульд заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулах;
ТБОНӨТХ-д заасны дагуу хуулийн этгээд үндсэн хөрөнгөөс бусад хөрөнгөө бусдад худалдах
29 дүгээр зүйл. Төрийн өмчийн эд хөрөнгийг худалдах 1. Төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгө..., төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгө...-өөс... бусад эд хөрөнгийг тухайн хуулийн этгээдийн шийдвэрээр гагцхүү дуудлага худалдаагаар худалдаж болно.

Гэсэн хэдий ч, бодит байдал дээр төрийн байгууллага, албан газар, компанийн хөрөнгийн эрхийн хуваарилалт нь ойлгомжгүй байна. Өөрөөр хэлбэл, ТБОНӨТХ-ийн 29.1-д “Төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгө..., төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгө...-өөс... бусад эд хөрөнгийг тухайн хуулийн этгээдийн шийдвэрээр” бусдад худалдаж болохоор зохицуулсан.

Энэхүү үндсэн хөрөнгө гэдэг нь “нэгээс дээш тайлант үед ашиглагдахаар хүлээгдэж хөрөнгө бөгөөд бүтээгдэхүүн, үйлчилгээний үйлдвэрлэл болон нийлүүлэтэд ашиглах, бусдад түрээслүүлэх эсвэл удирдлагын зориулалтаар ашиглагдах хөрөнгийг хэлнэ.”¹² Үндсэн хөрөнгөд дараах хөрөнгө хамаарна.¹³ Үүнд:

(а) Газрын сайжруулалт: Нийтийн эзэмшлийн газар дээр хийгдсэн явган хүний зам, ногоон байгууламж болон бусад газрын сайжруулалтууд;

(б) Барилга байгууламж: Бүх төрлийн барилга, түүний бүрэлдэхүүнд хамаарах халаалт, ус, агааржуулалт, цахилгааны систем, зам, гүүр, янз бүрийн талбай зэрэг дэд бүтцийн шинжтэй зүйлс;

(в) Машин, тоног төхөөрөмж: Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай бүх төрлийн машин механизмаас гадна дамжуулах төхөөрөмж, нэмэгдэл төхөөрөмжүүд;

(г) Тээврийн хэрэгсэл: Бүх төрлийн тээврийн хэрэгслүүд;

(д) Тавилга, эд хогшил: Нэг жилээс дээш хугацаанд ашиглагдах тавилга, аж ахуйн эд хогшил, багаж хэрэгслүүд;

¹² НББОУС 16

¹³ Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралт, Аж ахуй нэгжийн санхүүгийн тайлан тодруулгыг бэлтгэх заавар.

(е) Компьютер, бусад хэрэгсэл: Компьютер, хэвлэх, хувилах төхөөрөмж болон бусад хэрэгслүүд;

(ё) Бусад үндсэн хөрөнгө: Дээрх ангилалд ороогүй бусад үндсэн хөрөнгө хамаарна.

Харин хуулийн этгээд өөрийн шийдвэрийн үндсэн дээр захиран зарцуулж болох хөрөнгөд эргэлтийн хөрөнгө болон биет бус хөрөнгө зэрэг хамаарна.¹⁴ Эргэлтийн бус хөрөнгөд дараах хөрөнгө хамаарна. Үүнд:

1.Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө;

2.Дансны авлага;

3.Татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн авлага;

4.Бусад авлага;

5.Бусад санхүүгийн хөрөнгө;

6.Бараа материал;

7.Урьдчилж төлсөн зардал/тооцоо;

8.Бусад эргэлтийн хөрөнгө;

9.Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө);

Биет бус хөрөнгө гэж биет шинж чанаргүй, тодорхойлж болохуйц, мөнгөн бус хөрөнгийг хэлнэ. Санхүүгийн байдлын тайланд биет бус хөрөнгийг хуримтлагдсан хорогдол, хуримтлагдсан үнэ цэнийн бууралтыг хассан дансны цэвэр дүнгээр нь толилуулна.¹⁵ Биет бус хөрөнгийг дараах байдлаар ангилна. Үүнд:

(а) Зохиогчийн эрх;

(б) Компьютерийн програм хангамж: Програм хангамж, мэдээллийн сан;

(в) Патент;

(г) Барааны тэмдэг;

(д) Тусгай зөвшөөрөл: Тодорхой үйлдвэрлэл, үйлчилгээ, ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл;

¹⁴ Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралт, Аж ахуй нэгжийн санхүүгийн тайлан тодруулгыг бэлтгэх заавар.

¹⁵ Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралт, Аж ахуй нэгжийн санхүүгийн тайлан тодруулгыг бэлтгэх заавар.

(е) Газар эзэмших эрх;

(ё) Бусад биет бус хөрөнгө: Барилгын зураг, төсвийн ажил, техник эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын зардал, хөгжүүлэлтийн зардал.

Хэдийгээр, төрийн байгууллага, албан газар, компанид эдийн бус хөрөнгийн эрхийг олгосон боловч, үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх эд хөрөнгийн эрхийг хязгаарласан байна. Эсрэгээрээ, үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх эд хөрөнгийн эрхийг хязгаарласан боловч, өндөр үнэ цэн бүхий зохиогчийн эрх, мэдээллийн сан, патент, барааны тэмдэг, тусгай зөвшөөрөл, газар эзэмших эрх зэрэгт хамаарах эрхийг олгосон байгаа нь анхаарал татаж байна.

Тухайлбал, ХЗДХЯ-ны харьяа “Хууль зүйн үндэсний хүрээлэн” ТӨҮГ-ийн эзэмшлийн хууль тогтоомжийг олон нийтэд хүргэхэд чиглэсэн “legalinfo.mn” нээлттэй мэдээллийн сан, “хууль дээдлэх ёс” сэтгүүлийн барааны тэмдэг зэргийг удирдах буюу захиран зарцуулах эрхийг ТӨБОНӨТХ-иар өмчийн эзэмшигчид олгосон хэмээн ойлгож болохоор байна.

Орон нутгийн өмчийн удирдлага

ТБОНӨТХ-ийн 74.1-д “Орон нутгийн өмчийн зүйлс нь энэ хуулийн 3 дугаар зүйлд заасны дагуу нийтийн зориулалттай өмч, орон нутгийн өөрийн өмчөөс бүрдэнэ.”, 74.2-т “Орон нутгийн нийтийн зориулалттай өмчид тухайн орон нутгийн хүн амын нийтийн хэрэглээнд зориулсан эд хөрөнгө хамаарна” гэжээ.

Хэдийгээр, орон нутгийн өмчийг “нийтийн зориулалттай өмч” болон “орон нутгийн өөрийн өмч” хэмээн хоёр ангилсан байх боловч, өмчийн төрлөөс хамаарсан ялгамжтай удирдлын зохицуулалтыг бүрдүүлж чадаагүй байна. Өөрөөр хэлбэл, орон нутгийн өмчийн ангилал нь бодит байдал дээр хууль хэрэглээний хувьд ямар нэгэн ач холбогдолгүй байна.

Онолын хувьд ЗЗНДНТУТХ-д заасны дагуу орон нутгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж чиг үүргийн хүрээнд өөрийн өмчийн хөрөнгөөр бий болгосон дараах өмчийг тухайн шатны ИТХ-ын бүрэн эрхэд хамааруулж болно. Үүнд: аймаг, нийслэлийн хувьд нийтийн эзэмшлийн гудамж, талбай, хөшөө дурсгал, олон нийтийн соёл, амралтын хүрээлэн, ногоон байгууламж, авто зам, авто зогсоол болон цэвэр, бохир усны шугам, дулааны шугам, хог хаягдал болон хаягдал ус цэвэрлэх байгууламж, үерийн далан, ундны болон ахуйн хэрэгцээний уст цэгийн байгууламж зэрэг нийтийн хэрэгцээнд зориулсан хөрөнгө, сум, дүүргийн хувьд нийтийн эзэмшлийн гудамж, талбай, хөшөө дурсгал, олон нийтийн соёл, амралтын хүрээлэн, ногоон байгууламж, авто зам, авто зогсоол болон төвлөрсөн бус ундны болон ахуйн хэрэгцээний уст цэгийн байгууламж зэрэг нийтийн хэрэгцээнд зориулсан хөрөнгө хамаарна. Өөрөөр хэлбэл, зарим төрлийн орон нутгийн өмчийг нийтийн зориулалттай өмчийн ангилалд хамааруулахын ач холбогдол нь тухайн ангиллын өмчийг удирдах харилцааг тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид байнга оршин суугаа сонгуулийн эрх бүхий иргэдээс сонгогддог, бүрэн эрхийг хамтын

удирдлагын зарчмын үндсэн дээр хэрэгжүүлдэг тухайн шатны ИТХ-аас шийдвэрлэхэд оршино.

Гэсэн хэдий ч, ТБОГӨТХ-ийн зохицуулалтын хүрээнд дараах гурван асуудал чухлаар тавигдаж байна. **Нэгдүгээрт** өмчийн ангиллын үр дагавар тодорхойгүй тул орон нутгийн нийтийн зориулалттай өмчийг удирдах эрхийг тухайн шатны Засаг дарга, түүний харьяа байгууллага хэрэгжүүлэх боломж нь эрх зүйн хувьд нээлттэй байна. **Хоёрдугаарт** ТБОНӨТХ-ийн 77.3-т заасны дагуу орон нутгийн өмчийг бусдад шилжүүлэх, барьцаалуулах шийдвэрийг тухайн шатны ИТХ-ын даргад дангаар гаргах боломжтой байна. ИТХ-ын дарга нь ЗЗНДНТУДТХ-ийн 52-т заасны заасны дагуу ИТХ-ын хурлыг зохион байгуулахад холбогдох бүрэн эрхийг хэрэгжүүлэх этгээд байх бөгөөд ИТХ-ын төлөөлөн орон нутгийн өмчийн удирдлагыг хэрэгжүүлэх боломжгүй юм. Энэ талаар Үндсэн хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2-т “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд өмчийн удирдлагыг хэрэгжүүлэх”-ээр заасан байдаг.

Гуравдугаарт ТБОНӨТХ-ийн 78.2.1-д заасны дагуу аймаг, нийслэлийн ИТХ-аас Засаг даргад өмчийн удирдах эрх хэмжээг харилцан адилгүй байдлаар олгож байна. Энэ нь Үндсэн хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2-т заасан орон нутгийн өмчийн удирдлагыг хэрэгжүүлэх аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын эрх хэмжээ, хязгаарыг өнөөгийн ТБОНӨТХ-иар тодорхой байдлаар тогтоож, өгөөгүй байгаатай холбоотой.

ИТХ өмчийг удирдах бүрэн эрх
ТБОНӨТХ-д заасны дагуу ИТХ-аас шийдвэр гаргах
77 дугаар зүйл. Орон нутгийн өмчийн талаархи иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх 77.3. Орон нутгийн өмчид хамаарах үндсэн хөрөнгийг бусдын өмчлөлд шилжүүлэх, барьцаалах, шинээр олж авах асуудлыг гагцхүү иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний хуралдааны чөлөөт цагт Хурлын дарга шийдвэрлэнэ.
Засаг дарга өмчийг удирдах бүрэн эрх
ТБОНӨТХ-д заасны дагуу Засаг даргаас шийдвэр гаргах
78 дугаар зүйл. Орон нутгийн өмчийн талаархи Засаг даргын бүрэн эрх 78.2.1/ иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас олгосон эрх хэмжээний дотор орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах;

Мөн ЗЗНДНТУТХ-ийн 18.4-т Орон нутгийн өмчийн харилцааг хуулиар зохицуулахаар тусгасан. Гэсэн хэдий ч, ТБОНӨТХ-д орон нутгийн өмчийн удирдлагын талаар тодорхой зохицуулалт байхгүй улмаас орон нутгийн ИТХ эсхүл Засаг даргаас өмчийн харилцааг зохицуулсан журам батлах зайлшгүй шаардлага үүсэх болсон.

Тухайлбал, Нийслэлийн хувьд нийслэлийн өмчийн харилцаанд хамаарах дараах эрх зүйн актыг бие даан баталсан байна. Эдгээр дотор захиргааны хэм хэмжээний актын шинжтэй буюу гадагш чиглэсэн харилцаанд хамаарах эрх зүйн акт цөөнгүй бий.

- Нийслэлийн өмчийн талаар баримтлах бодлогын баримт бичиг НИТХ-ын 2014-01-23 өдрийн 14/01 тогтоол
- Нийслэлийн өмчийн оролцоотой хувь нийлүүлсэн этгээдэд төлөөлөл хэрэгжүүлэх журам НИТХТ-ийн 2014-04-21 өдрийн 54 тогтоол, /1 хавсралт/
- Нийслэлийн өмчийн хуулийн этгээдийн удирдах зөвлөлийн ажиллах журам НИТХТ-ийн 2014-04-21 өдрийн 54 тогтоол, /2 хавсралт/
- Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын захиралтай контракт байгуулах дүгнэх журам НИТХТ-ийн 2014-04-21 өдрийн 54 тогтоол, /3 хавсралт/
- **Нийслэлийн өмчийн эзэмшүүлэх гэрээ байгуулах, гэрээний биелэлтийг дүгнэх журам НИТХТ-ийн 2014-04-21 өдрийн 55 тогтоол /1 хавсралт/**
- **Нийслэлийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журам НИТХТ-ийн 2014-05-05 өдрийн 65 тогтоол /1 хавсралт/**
- **Нийслэлийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх түрээслэгчийн сонгон шалгаруулах журам НИТХТ-ийн 2014-05-05 өдрийн 65 тогтоол /2 хавсралт/**
- **Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам НИТХТ-ийн 2014-05-05 өдрийн 66 тогтоол /1 хавсралт/**
- **Нийслэлийн өмчийн хувьчлах журам НИТХТ-ийн 2014-05-05 өдрийн 67 тогтоол /1 хавсралт/**
- Нийслэлийн өмчийн хувьчлах комиссын ажиллах журам НИТХТ-ийн 2014-05-05 өдрийн 67 тогтоол /2 хавсралт/
- Нийслэлийн өмчид үнэ төлбөргүй шилжин ирж байгаа нийтийн эзэмшлийн эд хөрөнгийг бүртгэн авах журам НИТХТ-ийн 2014-05-05 өдрийн 68 тогтоол /1 хавсралт/

Гэтэл хуульд хэм хэмжээ тогтоосон акт батлахаар эрх олгогдоогүй бол дүрэм, журам батлах эрхгүй. Улмаар ИТХ-аас өөрийн өмчийн харилцааг зохицуулхаар баталсан дүрэм журмын хүчин төгөлдөр байдлын асуудал ч үүсэж байна.

Мөн орон нутгийн өмчийн удирдлагын талаарх ИТХ болон Засаг даргын эрх хэмжээ нь орон нутгийн ИТХ-аас баталсан журмуудын хүрээнд харилцан адилгүй зохицуулагдаж байна. Тухайлбал, ТӨБЗГ-ын Дорнод аймгийн орон нутгийн өмчийн газрын үйл ажиллагаанд илэрсэн зөрчил, дутагдлыг Арилгах арга хэмжээ, зөвлөмжид Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 50 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг худалдан

борлуулах, ашиглуулах, түрээслүүлэх үлгэрчилсэн журам”-ыг хуульд нийцүүлэн шинэчлэн батлуулах шаардлагатай байгаа талаар дурджээ.¹⁶

Гуравдугаар бүлэг. Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлага

Q1. 1996 оны ТБОНӨТХ дахь өмчийн удирдлагын үр ашиг болон зардлын харьцаа зохистой байна уу?

Төрийн болон орон нутгийн өмчийн харилцаанд “төрийн болон орон нутгийн өмчийг удирдах” тухай ойлголт ач холбогдолтой байдгаараа төрийн болон орон нутгийн өмчийн эрх зүй нь хувийн өмчийн эрх зүйгээс ялгаатай.¹⁷ Төрийн болон орон нутгийн өмчийг ард нийтийн эрх ашгийн үүднээс зүй зохистой удирдахын тулд төрийн болон орон нутгийн чиг үүргийг хэрэгжүүлэгч олон төрлийн этгээд оролцдог нь хувийн өмчийн эрх зүйгээс ялгагдах онцлог юм.¹⁸ “Хувийн өмчийн эрх зүйд өмчлөгчийн туйлын эрхийг тодорхой нэг этгээд хэрэгжүүлэн уг эрхээ хэрэгжүүлэхэд олон төрлийн шат дамжлага, хяналтын механизм шаарддаггүй”.¹⁹ Төрийн болон өмчийн эрх зүйд төрийн болон орон нутгийн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг эзэмшиж ашиглаж, захиран зарцуулж байгаа этгээдийг ерөнхийд нь төрийн болон орон нутгийн өмчийг эзэмшигч гэж нэрлэж болно.²⁰

Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлага нь онолын хувьд эзэн-төлөөллийн асуудал (agency problem)²¹ болон хэлцлийн зардал (transaction cost)²²-ын тэнцвэрийн хангахад чиглэх учиртай. Энэхүү хоёр ойлголтын тэнцвэрийн сайн хангаж чадсан тохиолдолд төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагын үр ашиг болон зардлын харьцаа сайжирна.

Эзэн-төлөөллийн асуудал гэдэг нь өмчийн эзний сонирхол болон өмчийг удирдаж байгаа этгээд хооронд сонирхлын зөрчил үүсэхийг хэлнэ. Төрийн өмчийн хувьд өмчийн эзэн болох ард түмэн, түүнийг төлөөлсөн УИХ-ийн өмчийг нийтийн эрх ашгийн төлөө удирдах сонирхол болон өмчийг бодитоор удирдаж буй төрийн байгууллага, түүний эрх бүхий албан тушаалтны хувийн сонирхол хоорондын зөрчлийг илэрхийлнэ. Энэхүү төрийн өмчийн харилцаан дахь эзэн-төлөөллийн асуудлыг зохицуулах олон хууль зүйн арга байдаг ч, хамгийн нийтлэг нь өмчийн

¹⁶ ТӨБЗГ, Шалган зааварчлах, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх ажлын хэсгийн тайлан дүгнэлт (2024).

¹⁷ Н.Баярмаа, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн төсөлд өгөх санал шүүмж, цуврал №40, 5, (ННФ., 2022).

¹⁸ Мөн тэнд.

¹⁹ Мөн тэнд.

²⁰ Мөн тэнд.

²¹ Hart, O., Shleifer, A., & Vishny, R. W. The proper scope of government: Theory and an application to prisons. The Quarterly Journal of Economics, 112(4), 1127–1161(1997) ; Besley, T., & Ghatak, M. Government versus private ownership of public goods. The Quarterly Journal of Economics, 116(4), 1343–1372 (2001).

²² Williamson, Oliver E. Transaction cost economics. In R. Schmalensee & R. D. Willig (Eds.), Handbook of industrial organization Vol. 1, pp. 135–182, (1989); Transaction costs, institutions, and economic performance. International Center for Economic Growth, Occasional Papers No. 30. ICS Press., 1992).

хөдөлгөөний шийдвэр гаргалтын процесс дахь төлөөлөл буюу төрийн байгууллага, албан тушаалтны тоог багасгаж, шийдвэр гаргалтын дээд шатны байгууллагын хяналтад оруулах байдаг.

Гэсэн хэдий ч, бүхий л төрлийн өмчийн хөдөлгөөнийг шийдвэрлэх бүрэн эрхийг УИХ эсхүл Засгийн газар, орон нутагт ИТХ эсхүл Засаг даргад төвлөрүүлэх нь хэлцлийн зардлыг нэмэгдүүлж, төрийн өмчийн хөдөлгөөнийг зогсонго байдалд оруулах эрсдэлийг дагуулж байдаг. 1996 оны ТБОНӨТХ-ийн зохицуулалтын хүрээнд дараах зохицуулалт нь хэлцлийн зардлыг үлэмж нэмэгдүүлж байгаагаас гадна зарим тохиолдолд өндөр зардлаас шалтгаан тухайн зохицуулалт хэрэглэгдэхгүй байх нөхцөл үүсжээ. Үүнд:

ТБОНӨТХ-ийн холбогдох заалт	Тайлбар
8 дугаар зүйл. Төрийн өмчийн талаархи Улсын Их Хурлын бүрэн эрх 8.1.4/ төрийн өмчийг барьцаалах... тухай шийдвэр гаргах;	Төрийн өмчийг барьцаалах шийдвэрийг УИХ-д төвлөрүүлсэн.
30 дугаар зүйл. Төрийн өмчийн эд хөрөнгийг үнэ төлбөргүй шилжүүлэх 2. Төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгө, <u>хуулийн этгээдийн эрх хэмжээнд хамааруулснаас бусад хөдлөх хөрөнгийг Засгийн газрын шийдвэрээр, Засгийн газраас зөвшөөрөл олгосон тохиолдолд</u> төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын шийдвэрээр шилжүүлж болно.	Хариу төлбөргүй шилжүүлэх шийдвэрийг Засгийн газарт төвлөрүүлсэн.
29 дүгээр зүйл. Төрийн өмчийн эд хөрөнгийг худалдах 1. төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын... шийдвэрээр гагцхүү дуудлага худалдаагаар худалдаж болно.	Хөдлөх эд хөрөнгийг бусад хариу төлбөргүй шилжүүлэх шийдвэрийг ТӨБЗГ-д төвлөрүүлсэн.

Дээрх дурдсан хэлцийн зардал гэдэг нь тухайн өмчийн хөдөлгөөнийг хийхэд шууд болон шууд бусаар зарцуулах бүхий мөнгө, хүч хөдөлмөр, цаг хугацааг илэрхийлэх бөгөөд хэлцлийн зардал өндөр байх тусам өмчийн удирдлагын зардал болон үр ашгийн харьцаа буурдаг. Өөрөөр хэлбэл, өмчийн хөдөлгөөнийг хийхэд шат дамжлагтай, удаан байх тусам төрийн байгууллагад үүсэх зардал нэмэгдэнэ хэмээн хэлж болно. Улмаар эзэн-төлөөллийн асуудлыг зохицуулахын хажуугаар хэлцлийн зардлыг бага түвшинд барих хувилбар нь өмчийн удирдлагын хүрээнд УИХ, Засгийн газар, ТӨБЗГ, өмчийн эзэмшигчийн бүрэн эрхийн хуваарилалтыг оновчтойгоор хийх асуудал байдаг. Тухайлбал, Япон улсад нийтийн зориулалт бүхий гол горхи,

цэцэрлэгт хүрээлэн, нийтийн талбай зэргийг бусдын өмчлөлд шилжүүлэх тохиолдолд зөвхөн парламент шийдвэрлэхээр зохицуулсан байдаг.²³ Мөн Франц, Солонгос, Финланд зэрэг улсад төрийн өмчийн хөдлөх эд хөрөнгийн удирдлагыг өмч эзэмшигч байгууллага нь бие даасан хэрэгжүүлж, тайлан мэдээг нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу хөтөлж, хүргүүлдэг бол үл хөдлөх эд хөрөнгийн удирдлагад төрийн өмч хариуцсан газар нь оролцох байдлаар бүрэн эрхийн хуваарилалтыг хийжээ.²⁴

1996 оны ТБОНӨТХ-ийн дараах үндсэн бүтэц, үзэл санаа нь эзэн-төлөөллийн асуудлын зохицуулах болон хэлцлийг зардлын үүднээс авч үзвэл оновчтой байна.

Нэгдүгээрт, төрийн өмчийг “нийтийн зориулалттай өмч” болон “өөрийн өмч” хэмээн ангилах замаар “нийтийн зориулалттай өмч”-ийг удирдах бүрэн эрхийг гагцхүү УИХ-д хадгалсан.

Хоёрдугаарт, төрийн өмчийг орон нутгийн өмчид шилжүүлэх шийдвэр гаргах бүрэн эрхийг гагцхүү УИХ-д хадгалсан.

Гуравдугаарт, төрийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийг бусдад шилжүүлэх бүрэн эрхийг Засгийн газарт олгосон.

Гэсэн хэдий ч, 1) үл хөдлөх эд хөрөнгөтэй дүйцэхүйц хөдлөх эд хөрөнгө, эдийн бус хөрөнгийн удирдлага, 2) бусдын өмчлөлд хөрөнгө шилжүүлэхтэй дүйцэхүйц үр дагавар бүхий барьцаалуулах, эд юмсын хязгаарлагдмал эрхийн үндсэн дээр ашиглуулах харилцаа, 3) орон нутгийн өмчийг төрийн өмчид шилжүүлэх үндэслэл, журам, 4) төрийн болон орон нутгийн өмч эзэмшигчийн хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийг бие даан удирдах бүрэн эрхийг хүрээ, хязгаар, 5) өөрийн бие даасан засаглал бүхий төрийн өмчит компанийн өмчийн удирдлагын харилцаа зэрэгт холбогдох тусгайлсан зохицуулалт дутмаг байна.

Өөрөөр хэлбэл, дээрх төрлийн төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагын харилцаанд ТӨБЗГ болон орон нутгийн өмчийн газар, эсхүл тодорхой тохиолдолд Засгийн газар болон ИТХ, Засаг даргын оролцоог хангах замаар төрийн болон орон нутгийн өмчийг удирдах бүрэн эрхийн хуваарилалтыг хийж болно.

Q2. 1996 оны ТБОНӨТХ нь өмч хариуцсан байгууллагын эрх зүйн баталгааг бүрдүүлсэн үү?

ТБОНӨТХ-ийн хүрээнд төрийн өмчийг хариуцсан байгууллага болох ТӨБЗГ (Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар)-ын эрх зүйн байдлыг 1996-2016 болон 2016 оноос хойш хэмээн хоёр салган авч үзэж болно.

²³ Г.Давааням, Төрийн өмчийн удирдлага, түүний эрх зүйн зохицуулалт: япон улсын жишээ, 55-56 (2021).

²⁴ ЗГХЭГ, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврт хийсэн үнэлгээ, 2022.11.20 (<https://lawforum.parliament.mn/project/344/>).

1996-2016 оны хооронд ТӨХ (Төрийн өмчийн хороо) буюу хамтын удирдлагын зарчим бүхий бие даасан “хороо”-ны хэлбэртэйгээр үйл ажиллагаа явуулж ирсэн. Харин 2016 оноос хойш “ТӨБЗГ” буюу хамтын удирдлагын зарчим бүхий “агентлаг”-ын хэлбэртэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

ТӨХ (1996-2016)

1996 оноос ТБОНӨТХ хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэнтэй холбогдуулан Засгийн газрын 1996 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн 177 дугаар тогтоолоор төрийн өмчийг хариуцсан байгууллага болох Төрийн өмчийн хороог байгуулж, Засгийн газрын 1996 оны 184 дүгээр тогтоолоор Засгийн газрын үндсэн бүтцийн байгууллагын түвшинд Төрийн өмчийн хорооны зохион байгуулалтын бүтэц, дүрмийг баталжээ.²⁵

Уг хуульд Төрийн өмчийн хорооны эрх барих дээд байгууллага нь дарга, орон тооны бус 8 гишүүнээс бүрдэнэ. Хорооны гишүүнийг Төрийн өмчийн хорооны даргын санал болгосноор Засгийн газар томилдог²⁶ байхаар зохицуулсан байна. Эндээс хууль тогтоогч төрийн өмч хариуцсан байгууллагын бие даасан байдалд ач холбогдол өгч, эрх зүйн байдлыг нь хамтын удирдлагын зарчим бүхий “хороо”-ны хэлбэртэй байхаар тогтоосон хэмээн ойлгож болно.

Үүнээс гадна ТӨХ-ны бүтцээс гадна төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх үүрэг бүхий аж ахуйн тооцоон дээр ажилладаг агентлаг байхаар тогтоосон байдаг.²⁷ Өөрөөр хэлбэл, тухайн үед төрийн өмчит аж ахуй нэгжийн удирдах загварыг нэг агентлаг дээр төвлөрсөн байхаар төлөвлөж байсан хэмээн ойлгож болно.

Улмаар ТӨХ-ны үндсэн чиг үүрэг нь (i) төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт, бүртгэл тайлан, тооцоонд хяналт тавьж, үр ашгийг дээшлүүлэх, (ii) Засгийн газрын шийдвэрээр төрийн өмчийг хувьчлах ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэх, (iii) төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн төлөөллийг хэрэгжүүлэх, (iv) төрийн захиргааны байгууллагыг шаардлагатай эд хөрөнгөөр хангах байв.

ТӨХ нь бүрэн эрхийн хүрээнд дор дурдсан чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар дүрэмд заасан.

- Төрийн өмчийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих, үр дүнг судалж боловсронгуй болгох талаар санал боловсруулж, зохих журмын дагуу шийдвэрлүүлэх;
- Төрийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах, үнэлэх, хувьчлах талаар эрх хэмжээнийхээ хүрээнд аргачлал, заавар, журмыг боловсруулж, батлан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

²⁵ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль 10.1.

²⁶ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль 10.2.

²⁷ ТӨХ-ны түүхэн замнал 2025.03.09 (https://pcsp.gov.mn/?page_id=4544).

- Төрийн өмчийг хувьчлах талаар тухайн жилд явуулах бодлого, хөтөлбөрийг боловсруулан Засгийн газар, Улсын Их Хуралд оруулан шийдвэрлүүлэх;
- Батлагдсан хөтөлбөрийн дагуу төрийн өмчийг хувьчлах ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлд нь хяналт тавьж, үр дүнг тайлагнах;
- Төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, түүний ашиглалтад хяналт тавьж, үр ашгийг дээш лүүлэх арга хэмжээ авах, төрийн өмчийн бүртгэл, тооллого, тайлан тэнцэл хянах ажлыг зохион байгуулж удирдах;
- Төрийн өмчийн төлөөлөл, өмч хувьчлалын ажлын эрх зүйн үндсийг бүрдүүлэх, боловсронгуй болгох санал боловсруулах, энэ талаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах;
- Төрийн өмчийн эзэмшилт, ашиглалт, төлөөлөл, хувьчлалтай холбогдуулан байгууллага, иргэдээс ирүүлсэн санал, хүсэлт, мэдээллийг хянан үзэж шийдвэрлэх;
- Төрийн өмчит үйлдвэрийн газрын удирдлагыг хууль тогтоомжид заасны дагуу томилох, чөлөөлөх, түүнтэй гэрээ байгуулах, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөгчийг томилж, түүний үйл ажиллагаанд хяналт тавих;
- Батлагдсан норм, нормативын үндсэн дээр төрийн байгууллагуудыг шаардлагатай эд хөрөнгөөр хангах;
- Орон нутгийн өмчийг удирдах ажилд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх;
- Засгийн газраас тогтоосон журмын хүрээнд төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түрээслэх.

Харин Засгийн газрын 2016 оны 1 дүгээр сарын 04-ний өдрийн 5 дугаар тогтоолоор Төрийн өмчийн хороо татан буугдаж, эрхэлж байсан чиг үүрэг нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад шилжүүлсэн байна.

ТӨБЗГ (2016-өнөөг хүртэл)

Засгийн газрын 2016 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Худалдан авах ажиллагааны газрыг татан буулгаж ТӨБЗГ-ын нэг хэлтэс болгосон. Энэ хүрээнд ТӨБЗГ-ийг төрийн өмчийн эд хөрөнгийг эзэмших, ашиглах, хамгаалах ажлыг эрхлэн гүйцэтгэх үүрэг бүхий Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг болгон өөрчлөн зохион байгуулсан.²⁸

Гэсэн хэдий ч, ТӨБЗГ-ын үндсэн чиг үүрэгт томоохон өөрчлөлт ороогүй. Үүнд (i) төрийн өмчийг эзэмших, ашиглах, бүртгэх, тоолох, тайлагнах, хамгаалах, хяналт

²⁸ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль 9^{1.1}

тавих ажлыг эрхлэн гүйцэтгэх, үр ашгийг дээшлүүлэх,²⁹ (ii) Засгийн газрын шийдвэрээр төрийн өмчийг хувьчлах ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэх,³⁰ (iii) төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн төлөөллийг хэрэгжүүлэх хамаарна.³¹

Улмаар ТӨБЗГ-ын эрх барих дээд байгууллага нь дарга, орон тооны бус найман гишүүнээс бүрдэх бөгөөд тэдгээрийг Засгийн газар томилж, чөлөөлөх³²-өөр зохицуулсан байна. Хэдийгээр, ТӨБЗГ нь Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байгаа боловч, хамтын удирдлагын зарчимд тулгуурлан шийдвэр гаргахаар зохицуулсан нь онцлог байна.

Хамтын удирдлага бүхий байгууллагын онцлог нь “...байгууллагын шийдвэрийг нэг гишүүн дангаар, эсхүл цөөнхөөр, эсхүл эрх олгогдоогүй этгээд гаргахгүй” байхад оршино³³. Тиймээс ТӨБЗГ-ын “хурал” нь хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ “хамтын удирдлагын зарчим” (англи хэл., council-system)-ын дагуу шийдвэр гаргах шаардлагатай байдаг. Хамтын удирдлагын зарчмын хүрээнд байгууллагын шийдвэр гаргах бүрэн эрхийг зөвхөн хуульд заасан үндэслэлээр тухайн байгууллагаас тусгайлан эрх олгосноос бусад тохиолдолд түүний дарга эсхүл гишүүн аль ч этгээд дангаар хэрэгжүүлэхийг хориглодог.

Гэсэн хэдий ч, ТБОНӨТХ-иар ТӨБЗГ-ын хурлын бүрэн эрх болон даргын бүрэн эрх нь тодорхой тусгагдаагүй улмаас ТӨБЗГ-ын дарга хурлын бүрэн эрхийг дангаар хэрэгжүүлэх практикт байна.³⁴ Мөн ТБОНӨТХ-ийн хүрээнд ТӨБЗГ-ын хурлын ирц, олонх эсхүл дийлэнх олонхын үндсэн дээр шийдвэр гаргах эсэх зэрэгт хамаарах зохицуулалт тодорхой бус байна.

Өнөөгийн байдлаар Засгийн газрын 2016 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн 49 дүгээр тогтоолоор ТӨБЗГ-ын орон тооны бус гишүүнээр:

- Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга;
- Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Захиргаа, хүний нөөцийн газрын дарга;
- Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
- Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
- Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга;
- Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;

²⁹ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11.2.

³⁰ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11.4.

³¹ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11.6.

³² Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль 9¹.2

³³ Захиргааны ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 (2015 он).

³⁴ Төрийн өмчийг эзэмүүлэх гэрээний загвар зэрэг ТБОНӨТХ-ийг хэрэгжүүлэхтэй холбоотой олон тооны асуудлыг ТӨБЗГ-ын дарга дангаар шийдвэрлэж байна.

- Барилга, хот байгуулалтын яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга;
- Зам, тээврийн хөгжлийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга нар тус тус томилогдон ажилллаж байна.

Ийнхүү ТӨБЗГ-ын эрх барих дээд байгууллага нь төрийн өмч эзэмшигч яамдын төлөөллийн хамтын удирдлагын зарчимд тулгуурлан шийдвэр гаргаж байгаа хэдий ч, орон тооны бус гишүүд нь зөвхөн Засгийн харьяа яамдын төлөөллөөс бүрдэж байгаа нь ойлгомжгүй байна. Өөрөөр хэлбэл, төрийн өмчийн удирдахад зохих мэдлэг, ур чадвар бүхий хөндлөнгийн этгээдийг оролцуулах замаар мэргэшсэн байдал, хяналтыг бэхжүүлж болно.

ТӨХЭ-ийн удирдлага

ТӨХЭ (Төрийн өмчит хуулийн этгээдийн удирдлага) нь төр буюу өмчийн эзэн өөрт байх хувьцаа эзэмшигчийн эрхээ ямар хэлбэрээр хэрэгжүүлэх вэ? гэдгийг илэрхийлнэ. Өөрөөр хэлбэл, төрийн зүгээс хувьцаа эзэмшигч болохын хувьд ТӨХЭ-д удирдлагын ямар хэлбэрийг сонгон хэрэгжүүлэх, ТӨХЭ-ийн ТУЗ-ийг томилох, хариуцлага хүлээлгэх, чиглүүлэх, үйл ажиллагааны төлөвлөгөөг тодорхойлох, хяналт тавих, төрийн төлөөлөн саналын эрх эдлэх зэрэг бүрэн эрхийг илэрхийлнэ.

Төр хувьцаа эзэмшигчийн эрхээ хэрэгжүүлэх удирдлагын хэлбэр

№	Загварын төрөл
1	Төвлөрсөн удирдлагын загвар (centralised model)
2	Хоёр яамны удирдлагын загвар (Dual model)
3	Хосолмол удирдлагын загвар (Twin track model)
4	Зохицуулах байгууллагын загвар (Coordinating agency)
5	Төвлөрсөн бус загвар (Decentralised model)

Төвлөрсөн удирдлагын загвар гэдэг нь төвлөрсөн нэг байгууллага төрийг төлөөлөн ТӨХЭ-ийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэн удирдах загвар юм. Тухайн төв байгууллага нь: төрийн тусгай чиг үүрэг бүхий хороо, нэгж, салбарын яам, толгой компани (холдинг), үндэсний баялагийн сан байдаг. Тухайлбал Австри, Чили, Колумб, Франц, Грек, Исланд, Нидерланд, Израиль, Итали, Солонгос, Шинэ Зеланд зэрэг улсуудад төвлөрсөн удирдлагыг нэг яам хэрэгжүүлдэг³⁵ бол Унгар, Малайз, Сингапур, Вьетнам, Перу, Бутан зэрэг улсуудад хувьцаа эзэмшигчийн эрхийг

³⁵ OECD, Organising The State Ownership Function-implementing the OECD Guidelines on Corporate Governance of State Owned Enterprises, OECD Publishing (Paris., 2020).

хэрэгжүүлэх чиг үүргийг нэгдсэн төвлөрсөн удирдлага бүхий толгой компани (холдинг) хэрэгжүүлдэг³⁶.

Хоёр яамны удирдлагын загвар гэдэг нь Сангийн яам болон салбарын нэг яам гэсэн хоёр төрийн байгууллага эсвэл төрийн хоёр өөр байгууллага төрийг төлөөлөн ТӨХЭ-ийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлдэг загвар юм. Энэ загварын хувьд ихэвчлэн ТӨХЭ-ийн санхүүгийн зорилго, төлөвлөгөөг сангийн яам тодорхойлож харин гүйцэтгэх ажил, стратеги бодлогыг нөгөө салбарын яам (ихэвчлэн 4-6) тодорхойлох чиг үүрэгтэйгээр оролцдог байна.

Хосолмол удирдлагын загвар гэдэг нь чиг үүргийн хувьд тус загвар нь төвлөрсөн удирдлагын загвартай төстэй боловч ТӨХЭ-ийг хоёр хэсэгт ангилж хоёр өөр төрийн байгууллага эсвэл компани төрийг төлөөлөн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлдэг. Тухайлбал, Бельги улсын хувьд ТӨХЭ-ийг хоёр хэсэгт ангиласан байдаг. Үүнд: 1) ашгийн төлөө үйл ажиллагаа явуулдаг арилжааны ТӨХЭ болон 2) “бие даасан төрийн өмчит компани” ангилалд багтах тусгай таван ТӨХЭ-үүд (SNCB, Infrabel, Belgocontrol, bPost, Proximus) юм. Эхний ангилал болох ашгийн төлөө, арилжааны ангилалд багтдаг ТӨХЭ-ийн удирдлагыг Federal Holding and Investment Company (FPIM) гэсэн компани хэрэгжүүлдэг байна. Хоёр дахь ангиллын ТӨХЭ-ийг ЗГ-ийн зүгээс бие даан удирдлагыг хэрэгжүүлдэг байна. FPIM нь холдинг компани бөгөөд 100 хувь ТӨХЭ бөгөөд стратегийн ач холбогдол бүхий ТӨХЭ-д санхүүжилт өгөх мөн толгой компанийн чиг үүргийг давхар гүйцэтгэдэг байна³⁷.

Зохицуулах байгууллагын загвар гэдэг нь хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий яам болон төрийн байгууллагад ТӨХЭ-ийн ажлын гүйцэтгэлийг хянах, техник болон үйл ажиллагаатай холбоотойгоор зөвлөх, хоорондын уялдаа холбоог зохицуулах чиг үүрэг бүхий тусгай нэгж, агентлаг байгуулан хэрэгжүүлдэг загвар юм. Бусад улсын практикаас үзэхэд зохицуулах байгууллагын бүрэн эрх нь яам төрийн байгууллагын бүрэн эрхтэй харьцуулхад харьцангуй хязгаарлагдмал байдаг.

Тухайлбал, Коста Рика, Латви, Литва, Филиппин, Энэтхэг зэрэг улс орнууд зохицуулах нэгж байгуулах загварыг хэрэгжүүлж байна. Тухайлбал, Коста Рика улсын тусгай зөвлөх чиг үүрэг бүхий нэгж (ТӨК-ийн удирдлага зохицуулах ерөнхий газар) нь Ерөнхийлөгчийн шууд харъяа зөвлөх чиг үүрэг бүхий байгууллагын статустай байдаг. Харин Филиппин улсын хувьд засгийн газрын харъяа “Government-owned and controlled corporation (GOCC)” нь зохицуулах чиг үүрэг бүхий нэгж бөгөөд ТӨХЭ-ийн ТУЗ-ийг томилох, сонгон шалгаруулах чиг үүргийг гүйцэтгэдэг байна. GOCC-ийн удирдлагын бүрэн эрхийг төрийг төлөөлөн Ерөнхийлөгч хэрэгжүүлдэг ба түүнийг төлөөлөн Засаглалын хороо (Governance Commission) бүрэн эрхийг хэрэгжүүлдэг байна³⁸. Энэтхэг улсад “Department of Public Enterprises (DEP)” нь

³⁶ A Toolkit, Corporate Governance of State-Owned Enterprises, The World Bank (2014) 171.

³⁷Бельги улсын холбооны толгой компани болох Federal Holding and Investment Company (FPIM)-ийн албан ёсны цахим хуудас [https://www.sfpi-fpim.be/en].

³⁸Филиппин улсын “Төрийн өмчит хуулийн этгээдийн удирдлагын корпораци” (Government-owned and controlled corporation-GOCC)-ийн танилцуулга, мэдээлэл [https://ogcc.gov.ph/gocc/].

ТӨХЭ-ний удирдлагын үйл ажиллагаанд зөвлөх болон зохицуулах чиг үүрэг бүхий байгууллага юм. DEP нь ТӨХЭ-ний засаглалын зөвлөмж боловсруулах, ТӨХЭ-ийн зорилго, үйл ажиллагааг хөгжүүлэхд дэмжлэг үзүүлэх, олон нийт болон парламентад холбогдох мэдээлэлийг өгөх чиг үүргийг гүйцэтгэдэг байна³⁹.

Төвлөрсөн бус загвар гэдэг нь нэг байгууллага эсвэл салбарын яам төрийг төлөөлөн хувьцаа эзэмшигчийн чиг үүргийг хэрэгжүүлэхийг зөвшөөрдөггүй ба тухайн ТӨХЭ-ийн хамаарах салбарын яам эсвэл төрийн байгууллага хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлдэг загвар юм. Хувьцаа эзэмшигчийн чиг үүргийг хэрэгжүүлэх эрхийг гол төлөв ТӨХЭ-ийн үйл ажиллагаатай уялдуулан салбарын яамны бүрэн эрхийн хүрээнд багтдаг байна. Аргентин, Болгар, Герман, Япон, Мексик, Украин зэрэг улсууд төвлөрсөн бус загварыг хэрэгжүүлж байна. Тухайлбал, Болгар улсын хувьд 2020 оны байдлаар 221 ТӨХЭ-дэд нийт 17 яам хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлж байна.

Төрийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийн удирдлага

Эстони улсын RKAS

Эстони улсад төрийн өмчийн удирдлагыг үр ашигтай, ил тод, хариуцлагатай байлгах зорилго бүхий хэд хэдэн байгууллага үйл ажиллагаа явуулдаг. Эдгээрийн нэг нь төрийн үл хөдлөх эд хөрөнгийг хариуцсан RKAS (Riigi Kinnisvara AS) юм.⁴⁰

RKAS нь 2001 онд байгуулагдсан бөгөөд төрийн өмчит үл хөдлөх эд хөрөнгийн менежмент, хөгжүүлэлт, засвар үйлчилгээ зэрэг үйл ажиллагааг хариуцдаг 100% төрийн өмчит компани юм.⁴¹ Тус компанийн зорилго нь эхэндээ төрийн өмчит оффис барилга байгууламжийн удирдлага байсан бол, сүүлийн үед сургууль, бусад тусгай зорилго бүхий байгууламжийн удирдлагыг хариуцах болсон.⁴² Үүнд:

- Сургуулийн барилга, байгууламж;
- Соёлын барилга, байгууламж;
- Шүүхийн барилга, байгууламж, шүүх хуралдааны танхим;

RKAS-ийн үндсэн зорилго нь:⁴³

- Төрийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийн нэгдсэн төлөвлөлт, удирлагыг хэрэгжүүлэх;
- Төрийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийг үр ашигтай удирдах;

³⁹Энэтхэг улсын “Нийтийн аж ахуйн газар” (Department of Public Enterprises -DEP)-ийн албан ёсны цахим хуудас [<https://dpe.gov.in/>].

⁴⁰ Албан ёсны вэб хуудас 2025/03/10 (<https://rkas.ee/en>).

⁴¹ Албан ёсны вэб хуудас 2025/03/10 (<https://rkas.ee/en/node/451>).

⁴² Албан ёсны вэб хуудас 2025/03/10 (<https://rkas.ee/en/node/451>).


⁴³ Албан ёсны вэб хуудас 2025/03/10 (<https://rkas.ee/en/node/451>).

- Төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд тохирсон барилга байгууламжийг хөгжүүлэх;
- Засвар үйлчилгээ, шинэчлэлийн ажлуудыг удирдах;
- Төрийн өмчит үл хөдлөх эд хөрөнгийн хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх;
- Ил тод байдал, санхүүгийн сахилга баттай менежментийг хэрэгжүүлэх.

RKAS нь төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн хөгжүүлэлтийг зах зээлийн зарчмаар явуулдаг бөгөөд Эстонийн Сангийн яам хувьцааг нь эзэмшдэг байна. RKAS-ийн эрх зүйн байдал нь компанийн хэлбэр тул түүний бүхий л үйл ажиллагаа нь компанийн зарчмаар явагдана.⁴⁴

Улмаар RKAS нь дараах бүтэц, зохион байгуулалтын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг байна.⁴⁵

- Хяналтын зөвлөл – Сангийн яамнаас томилогдох бөгөөд төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагаанд хяналт тавьдаг. Хяналтын зөвлөл нь дэргэдээ аудитын хороотой байх бөгөөд дотоод аудитын нэгж нь шууд аудитын хорооны харьяанд хамаарна.
- ТУЗ – Сангийн яамнаас томилогдох бөгөөд төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн бодлогыг тодорхойлдог бөгөөд ТУЗ-ийн гишүүд нь өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулдаг.



Англи улсын GPA

Англи улсын GPA (Government Property Agency) нь төрийн өмчийг төвлөрүүлэн удирддаг Засгийн газрын харьяа агентлаг юм. Өөрөөр хэлбэл, GPA нь **Cabinet Office** буюу **Засгийн газрын Хэрэг эрхлэх газар**-т харьяалагддаг байна. Үйл ажиллагаа нь төрийн байгууллагуудын оффис, барилга байгууламжийг үр ашигтай ашиглах, түрээслэх, хөгжүүлэх зэрэгт төвлөрдөг байна.⁴⁶ Үүнд дараах чиг үүрэг хамаарна.

⁴⁴ Албан ёсны вэб хуудас 2025/03/10 (<https://rkas.ee/en/node/451>).

⁴⁵ Албан ёсны вэб хуудас 2025/03/10 (<https://rkas.ee/en/company/structure-and-management>).

⁴⁶ Засгийн газрын вэб хуудас 2025.03.25 (<https://www.gov.uk/government/organisations/government-property-agency/about>).

- **Стратегийн өмчийн удирдлага** – Төрийн өмчийн бүхий л төрлийн барилга байгууламжийг нэгдсэн удирдлагаар хангах.
- **Үл хөдлөх хөрөнгийн менежмент** – Байгууллагуудын байр, оффис, ажлын орчинд хөрөнгө оруулалт хийж, удирдах.
- **Эд хөрөнгийн ашиглалтыг оновчтой болгох** – Шинэ оффис байгуулах, хуучин өмчийг шинэчлэх, дахин хөгжүүлэх зэрэг төсөл хэрэгжүүлэх.
- **Ногоон бодлого хэрэгжүүлэх** – Байгаль орчинд ээлтэй барилга байгууламж хөгжүүлэх, эрчим хүчний хэмнэлтийг дэмжих.
- **Аюулгүй байдал, стандартын хяналт** – Засгийн газрын өмчийн аюулгүй байдал, эрсдэлээс сэргийлэх бодлогыг хэрэгжүүлэх.

GPA-ийн эрх барих байгууллага нь УЗ байдаг. УЗ нь дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:⁴⁷

- **CEO (Chief Executive Officer)** – Агентлагийн үйл ажиллагааг удирдаж, стратеги боловсруулдаг.
 - **Cabinet Office**-оос нээлттэй сонгон шалгаруулалтын журмаар томилдог.
 - Томилгооны явцад мэргэжлийн туршлага, стратегийн удирдлагын чадвар, төрийн өмчийн менежментэд ажиллаж байсан туршлагыг гол шалгуур болгодог.
- **CFO (Chief Financial Officer)** – Санхүүгийн асуудлыг удирдан зохион байгуулдаг.
 - **CEO**-ийн санал болгосноор Засгийн газрын Хэрэг эрхлэх газар (Cabinet Office)-аас баталдаг.
- **COO (Chief Operating Officer)** – Өмчийн менежментийн өдөр тутмын үйл ажиллагааг хариуцдаг.
 - **CEO**-ийн санал болгосноор Засгийн газрын Хэрэг эрхлэх газар (Cabinet Office)-аас баталдаг.
- **CTO (Chief Technology Officer)** – Мэдээллийн технологийн шийдэл, дижитал инновацийг хэрэгжүүлдэг.
 - **CEO**-ийн санал болгосноор Засгийн газрын Хэрэг эрхлэх газар (Cabinet Office)-аас баталдаг.
- **Commercial Director** – Худалдаа, бизнесийн харилцааг хариуцдаг.
 - Энэ албан тушаалтан нь Гэрээ хэлэлцээр, Тендер, Түншлэл, Худалдааны бодлого зэрэг асуудлыг хариуцдаг учир өргөн хүрээний менежментийн туршлага шаарддаг.
 - **CEO**-ийн санал болгосноор Засгийн газрын Хэрэг эрхлэх газар (Cabinet Office)-аас баталдаг.
- **Хараат бус гишүүд (Non-Executive Directors)** – агентлагийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавих, стратегийн зөвлөгөө өгөх чиг үүрэгтэй

⁴⁷ Засгийн газрын вэб хуудас 2025.03.25 (<https://www.gov.uk/government/organisations/government-property-agency/about/our-governance>).

- Ихэвчлэн хувийн хэвшил болон төрийн байгууллагад удирдах түвшинд ажилласан туршлагатай мэргэжилтнүүдээс 6 хүн сонгогддог.
- **Cabinet Office**-оос нээлттэй сонгон шалгаруулалтаар 3 жилийн хугацаатайгаар томилдог.

УЗ нь дэргэдээ аудит хяналтын хороо, хөрөнгө оруулалтын хороо, соёл, цалин урамшууллын хороог байгуулж ажилладаг.⁴⁸ Мөн GPA нь Лондон, Манчестер, Бирмингем зэрэг бүс нутагт салбаруудтай бөгөөд орон нутаг дахь төрийн өмчийн удирдлагыг хариуцдаг.⁴⁹

Ийнхүү бусад улсын туршлагаас үзэхэд **“ТӨХЭ-ийн удирдлага болон төрийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийн удирдлага”**-д онцгойлон анхаардаг байна. Эдгээр асуудлыг хариуцсан бие даасан агентлаг, эсхүл хуулийн этгээд байгуулах практик нийтлэг байна. Тухайлбал, Эстони улсын хувьд төрийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийг хариуцсан компанийг үүсгэн байгуулж, зах зээлийн зарчмаар үйл ажиллагаа явуулдаг бол Англи улсын хувьд ЗГХЭГ-ын харьяа агентлагын хэлбэрээр төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлдэг байна.

Ингэхдээ эдгээр өмч хариуцсан байгууллагын удирдлагыг хамтын удирдлагын зарчим бүхий УЗ хэрэгжүүлэх бөгөөд хараат бус гишүүдийг нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр ажиллуулдаг байна. Эстони улсын хувьд ТУЗ-ийн үйл ажиллагаанд хяналт тавих хүрээнд хяналтын зөвлөлийг байгуулжээ. Мөн Англи улсын GPA-ийн хувьд УЗ-ийн дарга нь УЗ-ийн бусад ердийн гишүүдийг санал болгож байгаа нь 1996-2016 оны үеийн ТӨХ-той адил механизмыг хэрэгжүүлдгээрээ онцлог байна.

Дөрөвдүгээр бүлэг. Төрийн болон орон нутгийн өмчийн эзэмшигч буюу хуулийн этгээдийн ангилал

Q1. Төрийн өмчит хуулийн этгээдийн ангилал Иргэний хууль болон бусад хууль тогтоомжтой нийцтэй юу?

2022 оны байдлаар төрийн болон орон нутгийн өмчийн тооллогоор төрийн өмчит 1273, орон нутгийн өмчит 5341 хуулийн этгээд хамрагдснаас хуулийн этгээдийн гэрчилгээтэй 5484 байгууллага байна. Үүнийг зохион байгууллалтын хэлбэрээр нь ангилан үзвэл төсөвт байгууллага 4733, ХК 68, ХХК 99, төрийн болон орон нутгийн өмчит ААТҮГ 357, банк 3, төрийн тусгай сан 20, өрхийн эмнэлэг 204 байна⁵⁰. Өөрөөр хэлбэл, эдгээр төрийн болон орон нутгийн өмчит байгууллагууд нь төрийн болон орон нутгийн өмчийг эзэмшиж, ашигладаг байгууллагууд юм.

Хүснэгт 9. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн тоо

⁴⁸ Засгийн газрын вэб хуудас 2025.03.25 (<https://www.gov.uk/government/organisations/government-property-agency/about/our-governance>).

⁴⁹ Засгийн газрын вэб хуудас 2025.03.25 (<https://www.gov.uk/government/organisations/government-property-agency/about>).

⁵⁰ ТӨБЗГ, Улсын нэгдсэн тооллогын тайлан, 5, (2021).

Өмчийн хэлбэр	Санхүүгийн тайлан гаргасан нэгжийн тоо	Нийт хуулийн этгээдийн тоо	Гэрчилгээгүй	
			ТЕЗ-ийн дотоод сан	Төсөл
Төрийн өмч	1273	1153	4	116
Орон нутгийн өмч	5341	4331	1010	
Нийт	6614	5484	1014	116

Төрийн өмчийн харилцааг зохицуулахад өмчийн өөрийнх нь шинж байдал чухал ач холбогдолтойн нэгэн адил эдгээр өмчийг хэрэглэх субъект ч тун чухал. Өөрөөр хэлбэл, тухайн байгууллагын эрх зүйн байдал нь эд хөрөнгийн талаар түүний эдлэх эрх, үүргийг тодорхойлох суурь үндэс болдог.⁵¹

ТБОНӨТХ-ийн 13 дугаар зүйлд Төр чиг үүргээ хэрэгжүүлэх болон нийгмийн хэрэгцээг хангах зорилгоор төр өөрийн өмчөөр дангаараа байгуулсан хуулийн этгээдийг төрийн өмчит хуулийн этгээд байхаар заасан. Ингэхдээ “төрийн өмчит хуулийн этгээд” гэсэн ерөнхий ухагдахуун үүсгэж түүнийг дотор нь:

- төрийн байгууллага, албан газар;
- төрийн өмчит үйлдвэрийн газар;
- төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг;
- (iv) төрийн болон орон нутгийн өмчийн боловсролын сургалтын байгууллага /сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн, дээд боловсрол/ хэмээн 4 ангилсан байна.

Өөрөөр хэлбэл, төрийн өмчит этгээдүүдийг нийтийн ба хувийн эрх зүйн статусыг үл харгалзан төрийн өмчит хуулийн этгээд гэсэн нэгдсэн ухагдахуунаар зохицуулахаар оролдсон нь гол алдаа болсон гэж үздэг.⁵² Үүний үр дүнд хоорондоо үйл ажиллагаа нь уялдаагүй, хуулийн хийдлийг ашиглахыг эрмэлзсэн үр ашиг муутай олон компани, сан, төслийн нэгж, үйлдвэрийн газрууд төрөн гарсан⁵³ гэсэн шүүмжлэлийг дагуулж байна.

Улмаар ТБОНӨТХ-д төрийн өмчит үйлдвэрийн газраас бусад улсын төсвөөс санхүүждэг хуулийн этгээдийг төрийн байгууллага, албан газар гэнэ гэж заасан бөгөөд төрийн байгууллага, албан газрууд нь ямар ялгаатай болохыг тодорхойлоогүй. Өөрөөр хэлбэл, төрийн өмчит хуулийн этгээдийг тогтоох шалгуурыг улсын төсвөөс санхүүждэг байхаар тогтоосон нь улсын төсвөөс санхүүждэггүй ч

⁵¹ Н.Баярмаа, Газар ба үл хөдлөх хөрөнгө, газрын хэвлийн баялаг ба хувьцаа, ННФ, 2022., 72.

⁵² Мөн тэнд.

⁵³ Мөн тэнд.

төрийн чиг үүргийг хэрэгжүүлдэг нийтийн эрх зүйн этгээдийг хэрхэн авч үзэх нь тодорхойгүй орон зайг үүсгэсэн. Тодруулбал, нийтийн эрх зүйн этгээдийн гол шалгуур нь улсын төсвөөс санхүүждэг гэдгээр хязгаарлагдахгүй нийтийг засаглах эрх мэдэлтэй байх тухай юм.⁵⁴

Манай улсын хувьд хуулийн этгээдийн ерөнхий ангиллыг 2002 оны Иргэний хуулиар тогтоосон бөгөөд хуулийн этгээдийг үйл ажиллагааны зорилгоор нь ашгийн төлөө ба ашгийн төлөө бус /ИХ 25.2/, өмчлөгчөөр нь нийтийн, хувийн, холимог өмчийн /ИХ 25.3/ байхаар зохицуулснаас үзвэл төрийн өмчийн хуулийн этгээд нь ИХ-д заасан нийтийн өмчийн хуулийн этгээдэд хамаарах уу гэсэн асуулт урган гарна. ИХ-ийн 7.3-т “төр, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж болох аймаг, сум, нийслэл, дүүрэг нь иргэний эрх зүйн харилцаанд хуулийн этгээдийн нэгэн адил оролцоно” гэж заасан нь төрийн чиг үүргийг хэрэгжүүлдэг бүхий л байгууллагыг төрийн өмчит хуулийн этгээд хэмээн хавтгайруулан хэрэглэх шаардлагагүй буюу төр иргэний эрх зүйн харилцаанд хуулийн этгээдтэй адил эрх үүрэгтэй болохыг илтгэнэ.

Улмаар Иргэний хууль болон Захиргааны ерөнхий хуульд төрийн чиг үүргийг гүйцэтгэдэг байгууллагыг үндсэнд нь “нийтийн эрх зүйн хуулийн этгээд”, “нийтийн эрх зүйн этгээд” хэмээн нэрлэсэн бөгөөд ТБОНӨТХ-аар төрийн өмчит хуулийн этгээд гэсэн өөр нэр томъёо хэрэглэснээрээ нийтийн эрх зүйн этгээдтэй ямар уялдаа холбоотой байх нь ойлгомжгүй болж хууль хоорондын ойлгомжгүй байдал үүсгэсэн гэж дүгнэж болно. Өөрөөр хэлбэл, нийтийн эрх зүйн этгээдийн төрийн чиг үүргийг гүйцэтгэдэг захиргааны байгууллага болон төр, орон нутаг хувь хөрөнгөө оруулсан хуулийн этгээдүүд нь зарчмын хувьд нийтийн эрх зүйн этгээд болон хувийн эрх зүйн этгээд гэх ялгаатай эрх зүйн харилцааны субъект болохыг ялгаж салгахгүйгээр төрийн өмчит хуулийн этгээд нэрийн дор түүнийг үүсгэн байгуулах, хөрөнгөө удирдах, зохион байгуулалт, засаглалын бүтэц зэрэг асуудлууд тодорхойгүй нөхцөлд орж, улмаар төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг үр ашиггүй зарцуулах зэрэг асуудлын үндсэн шалтгаан болдог.

Ялангуяа, дээрх асуудал ТӨҮГ, ААТҮГ-ын хувьд тодорхой харагддаг. ТБОНӨТХ-ийн 15.1-д “төрийн өмчит үйлдвэрийн газар гэдэгт дан ганц төрийн өмчид үндэслэсэн болон улсын төсвөөс санхүүждэг үйлдвэрийн газар хамаарах” бөгөөд тэдгээрийг эд хөрөнгийн эрхийн байдлаар нь

- (i) аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар (ААТҮГ),
- (ii) улсын төсөвт үйлдвэрийн газар (УТҮГ) гэж ангилна хэмээн заасан.

ААТҮГ гэдэгт өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийг санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даасан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг хэлэх бол УТҮГ нь өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр төсвийн хөрөнгөөр санхүүждэг, зөвхөн төрийн хэрэгцээнд зориулсан үйлдэврлэл, ажил, үйлчилгээ эрхэлдэг хуулийн этгээдийг хэлэхээр тус тус заасан. /ТБОНӨТХ 15.2, 15.3/

⁵⁴ Мөн тэнд.

Дээрхээс үзвэл, ААТҮГ нь өөрт олгогдсон эд хөрөнгийг ашиглан аж ахуйн үйл ажиллагаа явуулсны үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх чиг үүрэгтэй нь хувийн эрх зүйн хуулийн этгээд буюу Иргэний хуульд заасан ашгийн төлөө хуулийн этгээдийн хэлбэрээр зохион байгуулагдаж, тухайлсан хуульд заасан нөхцөл шаардлагыг үндэслэн үүсгэн байгуулах, засаглалын бүтэц, хяналт хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх учиртай.

Түүнчлэн хуулийн 21.1-д төрийн өмчийн хувьцаатай буюу төр хувь хөрөнгөө оруулсан хуулийн этгээдийг төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд гэнэ гэж заасан нь дээрх ААТҮГ-аас ямар ялгаатай болох нь ойлгомжгүй бөгөөд практикт үүнийг төрийн өмчит ХК, ХХК хэлбэрээр зохион байгуулж байна. Тиймээс дээр дурдсан ААТҮГ нь эд хөрөнгөө бие даан захиран зарцуулах эрх хязгаарлагдмал, улс төрөөс бие даасан байдлаар үйл ажиллагаа явуулах хараат бус байдал болон компанийн сайн засаглал бүрдээгүй тул төрийн өмчит компанийн хэлбэрт нэгтгэн зохион байгуулах замаар Компанийн тухай хууль болон тусгайлсан хуульд заасан бүтэц зохион байгуулалтад орох нь зүйд нийцнэ.

Мөн 2016 оны нэмэлт өөрчлөлтөөр төрийн болон орон нутгийн өмчит мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг, 2023 оны өөрчлөлтөөр төрийн болон орон нутгийн өмчийн боловсролын сургалтын байгууллагыг төрийн өмчит хуулийн этгээдийн ангилалд хамааруулан оруулсан нь чухам ямар үндэслэл, шалгуураар оруулсан нь тодорхойгүй болгож, төрийн өмчит хуулийн этгээдийг эд хөрөнгийн эрхийн шалгуураар ангилах ангиллын бүтцийг алдагдуулсан.

Иймд (i) ТБОНӨТХ-ийн төрийн өмчит хуулийн этгээдийн ангиллыг эргэн харж, ААТҮГ, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийг Иргэний хуульд заасан ашгийн төлөө хуулийн этгээдийн хэлбэрээр нэгтгэн зохион байгуулах, (ii) гүйцэтгэх засаглал болон шүүх эрх мэдэл зэрэг төрийн үндсэн чиг үүргийг гүйцэтгэдэг байгууллагыг зөвхөн төсвөөс санхүүжих шаардлагаар бус нийтийг засаглах эрх мэдлийн шалгуураар нэгтгэн Захиргааны ерөнхий хуульд заасан нийтийн эрх зүйн этгээдийн ойлголттой нийцүүлэх, (iii) төрийн өмчит хуулийн этгээдийг нийтийн эрх зүйн этгээд, хувийн эрх зүйн этгээдийн ангилалд хамааруулж, хувийн эрх зүйн этгээдийн хүрээнд зохион байгуулагдах учиртай төрийн өмчийн компанийн зохицуулалтыг тусгайлсан хууль, эсхүл Компанийн тухай хууль үйлчлэхээр тодорхой заах, (iv) төрийн чиг үүргийг хэрэгжүүлэх субьектийг байгуулахдаа тухайлсан хуулиар хуулийн этгээдийн эрх олгох болон засаглал, бүтэц, хяналт механизмын тогтолцоог нарийвчлан зохицуулдаг байх өөрчлөлтийг хийх шаардлагай болохыг онцолж байна. Ингээд доорх хэсэгт бусад орнуудад төрийн өмчийн удирдлага, эзэмшил, ашиглалтыг ямар субьектүүд хариуцдаг талаар товч авч үзье.

Япон улс

Төрийн өмчийн эд хөрөнгийг эзэмших, ашиглах эрх бүхий субьектыг бусад улсуудад хэрхэн ангилж, зохицуулдаг талаар товч авч үзье. Япон улсын хувьд Иргэний хуулийн 33.1-д “Хуулийн этгээд нь энэ хууль болон бусад хуульд

үндэслээгүй бол үүсгэн байгуулагдахгүй”⁵⁵, 33.2 “эрдэм шинжилгээ, буяны үйл, зан заншил, шашин болон бусад нийтийн эрх ашгийн төлөөх зорилго бүхий хуулийн этгээд, ашгийн төлөө үйл ажиллагаа явуулдаг ашгийн төлөө зорилго бүхий хуулийн этгээд болон бусад хуулийн этгээдийг үүсгэн байгуулах, түүний бүтэц, удирдлага, хяналтыг энэ хууль болон бусад хуульд зааснаар зохицуулна”⁵⁶ гэж заасан. Өөрөөр хэлбэл, манай улсын ИХ-тай адилаар хуулийн этгээдийг өмчлөл, үйл ажиллагааны зорилгоор нь ангилахдаа ямарваа нэг хязгаарлалт тогтоогоогүй тул аливаа хувийн болон төрийн өмчийн хөрөнгөөр байгуулсан хуулийн этгээдийг байгуулахдаа тухайлсан хуулиар хуулийн этгээдийн эрхийг олгодог онцлогтой.

Хуулийн этгээдийн ангиллыг нарийвчлан үзвэл, ашгийн төлөө хуулийн этгээд гэдэгт компани, ЗГБХК, БГБХК, ХХК, ашгийн төлөө бус хуулийн этгээдэд ердийн холбоо, ердийн сан, нийтийн эрх ашгийн төлөөх сан, нийтийн эрх ашгийн төлөөх холбоо, ТББ, хувийн өмчийн сургууль, цэцэрлэг, эмнэлэг зэрэг хамаарна. Харин нийтийн эрх зүйн хуулийн этгээдэд төр, орон нутгийн засаг захиргаа, тусгай захиргааны хуулийн этгээд, тусгай зориулалтын хуулийн этгээдүүд хамаарна. Үүнд манай улстай адилаар төрийн өмчит хуулийн этгээд гэсэн нэгдсэн нэршил үүсгэдэггүй бөгөөд харин нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн хүрээнд тухайлсан хуулиудад үндэлсэн хуулийн этгээдийн эрхийг олгодог. Япон улс нь төрийн өмчийг удирдах хүрээнд төрийн өмчийн нэгдсэн удирдлага болон төрийн өмчийн тухайлсан удирдлагын бий болгосон.

Төрийн өмчийн нэгдсэн удирдлагыг Сангийн сайд хэрэгжүүлнэ.⁵⁷ “Төрийн өмчийн нэгдсэн удирдлага” гэдэг нь төрийн өмчийг зохистой аргын дагуу захиран зарцуулахын тулд төрийн өмчийг удирдах нэгдсэн тогтолцоог бий болгож, удирдах, захиран зарцуулах үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангаж, түүний өсөлт, бууралт, одоогийн нөхцөл байдал, үнэлгээг тодорхой байлгах, болон удирдах, захиран зарцуулахад шаардлагатай зохион байгуулалтын хариуцахыг хэлнэ.⁵⁸ Захиргааны өмчийн хувьд тухайлсан удирдлагыг тухайн хөрөнгийг харъяалах яам, агентлагийн зүгээс хэрэгжүүлнэ.⁵⁹ Харин яам, агентлагийн тухайлсан удирдлагын үйл ажиллагаанд нэгдсэн удирдлагыг хэрэгжүүлэгчийн хувиар Сангийн сайд хяналт тавина.

Бүгд Найрамдах Эстони Улс

Харин Бүгд Найрамдах Эстони улсын (БНЭУ) хувьд 2010 онд хэрэгжиж эхэлсэн Төрийн хөрөнгийн тухай хууль (State Assets Act)-ийн 4 зүйлд Төрийн хөрөнгийн удирдлагын талаар заасан бөгөөд Төрийн өмчийн удирдагч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

⁵⁵ 民法 33 条 1 項

⁵⁶ 民法 33 条 2 項

⁵⁷ Г.Давааням, Япон улсын төрийн өмчийн удирдлага, түүний эрх зүйн зохицуулалт, 26 (ННФ, 2022) 国有財産法 7 条。

⁵⁸ Мөн тэнд. 国有財産法 4 条。

⁵⁹ Мөн тэнд. 国有財産法 5 条。

- Төрийн нэрийн өмнөөс өмч олж авах, эзэмших, ашиглах, захиран зарцуулах;
- Үл хөдлөх хөрөнгийг ашиглах гэрээ эсвэл хязгаарлагдмал эд хөрөнгийн эрхийн гэрээний дагуу ашиглах;
- Эстони Улсад бүртгэлтэй хувийн болон олон нийтийн хязгаарлагдмал хариуцлагатай компани, сан, ашгийн бус холбоонд, мөн гадаад дахь хязгаарлагдмал хариуцлагатай хувийн эрх зүйн хуулийн этгээдэд төрийг хувьцаа эзэмшигч, үүсгэн байгуулагч, гишүүнээр оролцуулах;
- Дээр дурдсан үйл ажиллагаатай холбогдон үүсэх эрх, үүргийг энэ хуулийн дагуу хэрэгжүүлэхээр заасан⁶⁰. Харин 4.2-т зааснаар Төрийн өмчийн удирдагчид дараах байгууллагууд багтана. Үүнд:

- 1) Улсын Их Хурлын Тамгын газар (Riigikogu);
- 2) Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар;
- 3) Үндэсний аудитын газар;
- 4) Хууль зүйн Хянан Шалгах Газрын Тамгын газар;
- 5) Дээд шүүх;
- 6) Засгийн газрын Хэрэг эрхлэх газар;
- 7) Яамд⁶¹ байна.

Харин хууль болон Засгийн газрын журмаар заасан тохиолдолд төрийн өмчийн удирдагчийн чиг үүргийг ашгийн төлөө төрийн агентлаг болон Газрын реформын тухай хууль болон түүнтэй холбоотой журмын дагуу Газрын алба хэрэгжүүлж болохоор байна. Мөн хууль болон холбогдох журамд өөрөөр заагаагүй бол төрийн өмчийн удирдагчийн чиг үүргийг хэрэгжүүлэх этгээдийг тухайн байгууллагын дотоод зохицуулалтаар томилно.⁶²

Бүгд Найрамдах Солонгос Улс

БНСУ-ын хувьд 2009 онд батлагдсан Төрийн өмчийн (State Property Act) тухай хуулиар төрийн өмчийн хяналт, удирдлагын харилцааг зохицуулдаг. БНСУ нь Япон улстай адилаар төрийн өмчийн нэгдсэн удирдлага, хяналтын тогтолцоотой бөгөөд тус хуулийн 8 дугаар зүйлд төрийн өмчийн ерөнхий хяналт, удирдлагын талаар зохицуулсан. Ерөнхий удирдлагын алба (Office of General Administration) нь төрийн өмчтэй холбоотой хэрэг эрхлэх, түүнд хяналт тавих, төрийн өмчийг захиран зарцуулах, удирдах үүрэгтэй байна. Ерөнхий удирдлагын алба гэдэг БНСУ-ын Эдийн засаг, санхүүгийн яамыг ойлгохоор заасан. Гэхдээ төв Засгийн газрын

⁶⁰ State Assets Act 4.1

⁶¹ State Assets Act 4.2

⁶² State Assets Act 4.3, 4.5

агентлагийн (Central Government Agency) дарга энэ хуулийн 8.3-т заасны дагуу захиран зарцуулж, удирдах төрийн өмч үүнд хамаарахгүй.⁶³

Ерөнхий удирдлагын алба нь нийтийн өмчийг хадгалалтанд зориулсан өмч болгон хувиргах замаар удирдах боломжтой. Төв Засгийн газрын агентлагийн дарга нь Үндэсний санхүүгийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасны дагуу байгуулсан тусгай санхүүжилтийн данс эсвэл 5 дугаар зүйлд заасны дагуу байгуулсан санд хамаарах төрийн өмч болон 40 дугаар зүйлийн (2) дахь хэсэгт заасан төрийн өмчийг захиран зарцуулж, удирдана.⁶⁴

Төв Засгийн газрын агентлагийн дарга нь 8.3-т хамаарахгүй төрийн өмчийг захиргааны өмч болгон ашиглахыг хүсвэл Ерөнхий удирдлагын албанаас Ерөнхийлөгчийн зарлигаар тогтоосон журмын дагуу зөвшөөрөл авах ёстой⁶⁵. Ерөнхий удирдлагын албаны энэ хуулийн дагуу захиргааны өмчийг удирдах, захиран зарцуулах тодорхой чиг үүргийг Ерөнхийлөгчийн зарлигаар тогтоосон журмын дагуу төв Засгийн газрын агентлагийн даргад шилжүүлж болно⁶⁶.

Өөрөөр хэлбэл, БНСУ-ын хувьд төрийн өмчийн нэгдсэн удирдлагыг хэрэгжүүлэгч Ерөнхий удирдлагын албыг байгуулж, тухайн алба нь тодорхой төрлийн тусгай данс, сангийн хөрөнгөөс бусад төрлийн төрийн өмчийг удирдах, хянах, өмчлөх, захиран зарцуулах эрхийг эдлэхээр төвлөрсөн удирдлагын загварыг нэвтрүүлсэн.

Дээр дурдсанчлан Япон, БНЭУ, БНСУ-ын хувьд манай улстай адилаар төрийн өмчит хуулийн этгээдийн ерөнхий ангилал үүсгэж, түүнийгээ дотор нь задлах байдлаар хуульчлаагүй. Тодруулбал, төрийн өмчийн эзэмшигч, ашиглагч нь тодорхой нэг нэгдсэн удирдлага бүхий захиргааны байгууллага, эсхүл өмчийн төрлөөсөө хамааран шууд холбогдох захиргааны байгууллагуудад өмчийг эзэмших, ашиглах, удирдах эрхийг олгосон байна.

Тавдугаар бүлэг. Төрийн болон орон нутгийн өмчид хөрөнгө олж авах, захиран зарцуулах

Q1. Төрийн болон орон нутгийн өмчид хөрөнгө олж авах харилцааг бүрэн зохицуулж чадсан уу?

ТБОНӨТХ-ийн 24 дүгээр зүйлд төрийн өмчийн эд хөрөнгийн олж авах талаар зохицуулсан боловч төрийн өмчид хөрөнгө олж авах маш олон аргыг орхигдуулсан, тодорхойгүй үлдээснээс болж төрийн болон орон нутгийн өмч хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, түүнээс ямар нэгэн үр шим гарахгүй байх зэрэг асуудлууд үүссээр ирсэн. Өөрөөр хэлбэл, одоогийн үйлчилж буй ТБОНӨТХ-аар төрийн болон орон нутгийн өмчид хөрөнгө олж авах аргыг тодорхой зохицуулаагүй үлдээсэн.

⁶³ State Property Act 8.1

⁶⁴ State Property Act 8.3

⁶⁵ State Property Act 8.4

⁶⁶ State Property Act 8.6

Төр, орон нутаг өмчтэй байх, өмч олж авах нь нийтийн ашиг сонирхлыг хамгаалах, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, нийгмийн тэгш байдлыг хадгалах, аюулгүй байдлыг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой бөгөөд улс оронд шаардлагатай дэд бүтцийг бий болгож, төрийн үйлчилгээг тасралтгүй хүргэх үндэс болдог. Энэ нь төрийн санхүүгийн тогтвортой байдлыг хангаж, өмчийн үр ашигтай менежментээр зардлыг бууруулах, илүүдэл хөрөнгийг борлуулж төсвийн орлогыг нэмэгдүүлэх ач холбогдолтойгоос гадна, хувийн хэвшлийн давамгайлал, газрын үнийн хөөрөгдөл зэрэг шударга бус байдлыг хязгаарлаж, нийгмийн бүх давхаргын иргэдэд тэгш боломж олгоход чиглэгддэг.

Мөн онцгой нөхцөл байдал, гамшгийн үед шаардлагатай өмч, байгууламжийг бэлэн байлгах, батлан хамгаалах, эрчим хүчний стратегийн объектуудыг төрийн мэдэлд байлгах замаар үндэсний аюулгүй байдлыг хангах боломж бүрдүүлдэг бөгөөд төрийн тогтвортой бодлого хэрэгжих, гадаадын хөрөнгө оруулалтын эрсдэлээс сэргийлэхэд чухал үүрэгтэй.⁶⁷ Тиймээс төрийн өмчийг зөв зохистой олж авах нь улс орны урт хугацааны хөгжилд эерэг нөлөө үзүүлж, тогтвортой засаглалын үндэс суурь болдог. Тиймээс ТБОНӨТХ-аар төрийн болон орон нутгийн өмч олж авах арга хэлбэрийг тодорхойлох шаардлагатай.

ТБОНӨТХ-ийн 24.1-д “Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар өөрийн чиг үүрэг, зорилгыг хэрэгжүүлэхэд шаардлагатай эд хөрөнгийн жагсаалтыг санхүүгийн жил эхлэхээс 3 сарын өмнө гаргаж, төрийн өмчийн бодлого зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Сангийн ямааар зардлын дээд хязгаарыг батлуулна”, 24.2 “Төрийн байгууллагаас бусад төрийн өмчит хуулийн этгээд батлагдсан зардлын дээд хэмжээнд батгаан шаардлагатай хөрөнгөө өөрөө худалдаж авах ба төрөөс түүнд хариу төлбөргүйгээр олгож болно” гэж заасан. Мөн төрийн өмчит хуулийн этгээд үл хөдлөх хөрөнгийг захиалгын үндсэн зөвхөн төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн захиргааны байгууллагын шийдвэрээр олж авахаар заасан.

1996 онд ТБОНӨТХ батлагдах үед төрийн өмчийн дүн 1,531.9 тэрбум төгрөгийн өмчтэй байсан бол 2021 оны байдлаар 79,896.6 тэрбум төгрөг хүрсэн нь төр, орон нутгийн өмчилж буй хөрөнгийн дүн жил бүр өсч байгааг харж болно. Үүний нэг шалтгаан нь сүүлийн жилүүдэд төрийн болон төрийн өмчийн оролцоотой уул уурхайн компаниудын орлого өсч, төрийн болон орон нутгийн эзэмшлийн хувь, хувьцааны үнэ, түүнд ногдох ногдол ашгийн өгөөж нэмэгдсэнтэй холбоотой. Гэтэл ТБОНӨТХ-ийн 24 дүгээр зүйлд зөвхөн төрийн өмчит хуулийн этгээд батлагдсан зардлын хэмжээнд батгаан хөрөнгө худалдаж авах, үл хөдлөх хөрөнгийг ТӨБЗГ-ын шийдвэрээр олж авах талаар зохицуулснаас дээр дурдсан төрийн эзэмшлийн үнэт цаас, ногдол ашиг, төрийн өмчийн эд хөрөнгийн үр шим, зээл, хандив тусламжаар бий болсон хөрөнгө гэх мэт төрийн болон орон нутгийн өмчид хөрөнгө олж авах олон аргуудыг орхигдуулсан.

⁶⁷ Government Property Function, Government Property Strategy 2022-2030, 2022/23, 4. https://assets.publishing.service.gov.uk/media/630debb78fa8f5535f413ecf/Government_Property_Strategy_2_.pdf

Хэдийгээр ТБОНӨТХ-аас бусад Төсвийн тухай хууль, Үндэсний баялгын сангийн тухай хууль, Иргэний хуульд заасан аргуудаар төрийн өмчид хөрөнгө олж авах боломж нээлттэй байгаа ч ТБОНӨТХ нь төрийн өмчийн эд хөрөнгийн харилцааны хувьд Үндсэн хуулийн дараа орох тулгуур хуулиудын нэг болох тул төрийн өмчид хөрөнгө олж авах үндсэн аргуудыг тус хуульд тусгах нь зарчмын хувьд оновчтой. Ингэснээр төрийн болон орон нутгийн өмчид хөрөнгө олж авах арга, зарчим тодорхой болж, төрийн өмчийн удирдлага, ашиглалтыг хэрэгжүүлж буй субъектүүд тухайн хөрөнгийн үр дүнтэй ашиглах боломжийг бүрдүүлэх учиртай.

Түүнчлэн ТБОНӨТХ-ийн 3 зүйлд “төрийн өмч нь төрийн нийтийн зориулалттай өмч, төрийн өөрийн өмчөөс бүрдэнэ. Төрийн нийтийн зориулалттай өмч, төрийн өөрийн өмч нь Иргэний хуулийн 84 дүгээр зүйлд заасны дагуу үл хөдлөх болон хөдлөх хөрөнгөд хуваагдана” гэж төрийн өмчийг явцууруулан тодорхойлж, төр болон орон нутагт үр өгөөжөө өгөх боломж бүхий эдийн бус баялаг буюу үнэт цаас, оюуны өмч, зохиогчийн эрх зэргийг хөрөнгөд оруулахгүйгээр хязгаарласан. Тиймээс ч төрийн өмчид хөрөнгө олж авах аргад эдийн бус баялгыг оруулаагүй нь онолын хийгээд практиктай нийцэхгүй гэдэг нь тодорхой байна.

Тиймээс (i) ТБОНӨТХ-д төрийн болон орон нутгийн өмчид хөрөнгө олж авах үндсэн аргуудыг хуульчлах, (ii) төр, орон нутаг бусдаас хандив, тусламж авах замаар хөрөнгө олж авах тохиолдолд хэт өндөр үүрэг хүлээсэн хийгээд хэт их зардал гаргах ач холбогдолгүй хөрөнгийг олж авахгүй байх хязгаарлалтыг хийх, (iii) эдийн бус баялгын эрхээр хөрөнгө олж авах зэрэг асуудлыг шийдвэрлэх нь зохистой.

Иймд гадаадын зарим орнуудад төрийн өмчид хөрөнгө олж авах ямар аргууд байдаг талаар товч авч үзье.

Хүснэгт 10. Төрийн өмчид хөрөнгө олж авах арга, харьцуулалт

	Төрийн өмчид хөрөнгө олж авах арга	Эх сурвалж, тайлбар
Япон улс	- Бэлэглэл, өв залгамжлал, хандив тусламж - Нийтийн эрх ашгийн төлөө газрыг дайчлан авах (үерийн далан барих, зам г.м. Гэхдээ өмчлөгчид зүй ёсны нөхөн олговрыг олгосон байх) - Эзэнгүй эд юмс, гээгдэл хөрөнгө олж авах - Өв залгамжлагчгүй эд хөрөнгө өвлөх - Гэмт хэргийн улмаас хураан авсан хөрөнгө - Орон нутагт хэрэгцээгүй болсон хөрөнгийг төрийн өмчид авах г.м	(1) Төрийн өмчийн тухай хууль (2) Төсвийн тухай хууль (3) Иргэний хууль (4) Газрыг албадан чөлөөлөх тухай хууль (5) Гэмт хэргийн орлогыг дамжуулахаас сэргийлэх тухай хууль (6) ЗЗНДНТХ

БНЭУ	(1) Төрийн өмчийг дараах зорилгоор удирдана: 1. төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэх; 2. төрийн өмчийн удирдагчийн тогтоосон бусад нийтийн зорилгоор; 3. орлого олох; 4. өмчийг нөөц байдлаар хадгалах. (2) Хэрэв компанид эзэмшиж буй хувьцааг удирдах анхдагч зорилго нь хууль тогтоомжид заасан, эсвэл компанийн дүрэмд тусгасан, захиргааны гэрээнд тодорхойлсон олон нийтийн ашиг сонирхолд суурилсан тодорхой чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн бол, тухайлбал, тодорхой бизнесийн үйл ажиллагаа эрхлэх тохиолдолд бараа, үйлчилгээний төлбөртэй борлуулалтаас зохистой ашгийг бий болгох нь мөн уг удирдлагын зорилгод тооцогдоно. (3) Төр өмчийг хууль тогтоомжийн дагуу болон арилжааны гэрээний үндсэн дээр олж авах бөгөөд энэхүү олж авах үйлдэл нь энэ зүйлийн (1) дэх хэсэгт заасан зорилгоор шаардлагатай эсвэл Улсын Их Хурлын хууль тогтоомжоор өмчийг олж авах үүрэг хүлээсэн тохиолдолд хэрэгжинэ. (5) Энэ зүйлийн (3) дахь хэсэгт заагаагүй тохиолдолд төр өмчийг зөвхөн Засгийн газрын зөвшөөрлөөр олж авч болно.	(1) Төрийн хөрөнгийн тухай хууль
БНСУ	– Өмчлөгчгүй газар – Хандив, тусламж – Өв залгамжлал	(1) Төрийн өмчийн тухай хууль

Зургаадугаар бүлэг. Төрийн болон орон нутгийн өмчийг захиран зарцуулах арга

Q1. Төрийн болон орон нутгийн өмчийг захиран зарцуулах аргыг нарийвчлан зохицуулах шаардлагатай байна уу?

ТБОНӨТХ-ийн 27-30 дугаар зүйлд зааснаар төрийн өмчийг (i) төрийн өмчийн бусад этгээдэд эзэмшүүлж, ашиглуулах, (ii) түрээслүүлэх, (iii) худалдах, (iv) үнэ төлбөргүй шилжүүлэх хэлбэрийг хуульчилсан байна.

Төрийн өмчийг төрийн өмчийн бус этгээдэд эзэмшүүлж, ашиглуулахдаа эрх бүхий байгууллагын шийдвэрээр төр хувийн хэвшлийн түншлэл, түрээс, хуулиар зөвшөөрсөн бол үнэ төлбөргүйгээр эзэмшүүлж ашиглаж болно. Ингэхдээ эрх бүхий байгууллага нь төрийн нийтийн зориулалттай хөрөнгийн хувьд УИХ, төрийн өөрийн өмчийн хувьд Засгийн газар, Засгийн газар тусгайлан журамласнаас бусад үл хөдлөх эд хөрөнгийг түрээслүүлэхэд төрийн өмчит хуулийн этгээд буюу төрийн өмчийн эзэмшигч шийдвэрлэхээр хуульд заасан.

Харин төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг хувьчлалаас гадуур худалдахдаа Засгийн газар, төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийг ТӨБЗГ, түүнээс бусад хөрөнгийг худалдах шийдвэрийг төрийн өмчийн эзэмшиж буй төрийн өмчит хуулийн этгээд гаргана. Уг хуулийн зохицуулалтаас үзвэл, төрийн өмчийг эзэмшиж байгаа төрийн байгууллага, албан газар, ТӨҮГ, ТӨК-ийн бүхий л эд хөрөнгийн эрхийг бусад төрийн байгууллагын оролцоо, зөвшөөрлийн үндсэн дээр хязгаарласан байна (Хүснэгт 1).

Ийнхүү төрийн болон орон нутгийн өмчийг эзэмшигч өөрийн эзэмшлийн хөдлөх эд хөрөнгө, ширээ сандал зэрэг эд зүйлсийг ч бодит байдал дээр захиран зарцуулах боломжгүй байгаа нь өмчийг үр ашиггүй болгох, эдийн засгийн харилцаанд орох боломжийг хязгаарласаныг илтгэж байна. Үүнээс гадна төрийн болон орон нутгийн өмчийг эзэмшигчийн дотоод засаглал, хяналтын хүрээнд хэрэгжүүлэх боломж бүхий өмчийн удирдлагыг УИХ, ИТХ, Засгийн газар, Засаг дарга, ТӨБЗГ-ын түвшинд шийдвэрлэж байгаа нь өмчийн удирдлагын зардал болон үр ашгийн харьцаанд сөргөөр нөлөөлж байна.

Эндээс дүгнэн үзвэл, төрийн өмчийн хөрөнгийг захиран зарцуулах үндсэн аргыг хуульд заасан боловч тухайн хөрөнгийг үнэ төлбөргүй ашиглуулах, түрээслүүлэх үндэслэл шаардлагыг хуулиар тогтоогоогүй, төрийн нийтийн зориулалттай өмчийг түрээслэх тохиолдолд УИХ, төрийн өөрийн өмчийг түрээслүүлэх журмыг ЗГ-аас тогтоохоор заасан. Төрийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэхтэй холбоотой ЗГ-аас дараах журмыг баталсан байна.

- ЗГ-ын 2001 оны 134 тогтоолын хавсралт “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журам”

Харин төрийн нийтийн зориулалттай өмчийг түрээслүүлэх журмыг УИХ-аас тогтоохоор заасан боловч legalinfo.com сайтаас хайлт хийхэд УИХ-аас баталсан тогтоолын илэрц олдоогүй учир төрийн нийтийн зориулалттай өмчийг түрээслүүлэх журмыг батлаагүй байна гэж үзэв.

Иймд төрийн болон орон нутгийн өмчийг захиран зарцуулах, бусдад шилжүүлэх, ашиглуулах хэлбэрийг тодорхой хуульчлах нь зүйтэй. Тухайбал, төрийн өмчийн бусдад үнэ төлбөргүй болон хөнгөлөлттэй үнээр ашиглуулах, шилжүүлэх нөхцөл шаардлагыг тодорхой болгох, зах зээлийн журмаар түрээслүүлж ашиглуулах тохиолдолд түүнийг үнийг хэрхэн тодорхойлох, нийтийн эрх ашгийн төлөө үйл ажиллагаа явуулдагч төрийн өмчийн бус байгууллагуудад төрийн өмчийг ямар

зарчмаар ашиглуулах зэрэг олон төрлийн асуудлыг цогцоор нь зохицуулах шаардлагатай.

Япон улс

Япон улсын хувьд төрийн өмчийг (i) захиргааны өмч, (ii) ердийн өмч гэж ангилж төрийн өмчийг удирдах, захиран зарцуулах хэлбэр нь тухайн өмчийн хөрөнгө нь захиргааны өмч болон ердийн өмчийн хөрөнгө байхаас хамааран ялгаатай байна.

Захиргааны өмчийг удирдах, захиран зарцуулах

Захиргааны өмчийг яам, агентлагын дарга нар удирдана⁶⁸. Яам, агентлагын дарга нарын зүгээс захиргааны өмчийг удирдахдаа Төрийн өмчийн тухай хуульд зааснаас бусад тохиолдолд захиран зарцуулахыг хориглодог⁶⁹.

Энэхүү захиргааны өмчийг захиран зарцуулахыг хориглосон тохиолдолд дараахь хэлбэрүүд хамаарна. Үүнд: (i) түрээслүүлэх, (ii) арилжаа хийх (өөр хөрөнгөөр солих), (iii) худалдах, (iv) хөрөнгө итгэмжлэх, (v) хөрөнгө оруулах, (vi) хувийн эрх зүйн эрх олгох (газар ашиглах эрх, сервитут,) хамаарна. Харин Төрийн өмчийн тухай хуульд заасны дагуу гагцхүү дараахь тохиолдолд тухайн хөрөнгийн зориулалтад нийцсэн хүрээнд түрээслүүлэх эсхүл хувийн эрх зүйн эрх олгож болно⁷⁰.

- төрөөс өөр этгээд захиргааны өмчийн газар дээр барилга эсхүл үр тариа өмчилдөг эсхүл өмчлөх гэж байгаа бөгөөд тухайн газрын хэрэглээний зорилгод нийцсэн байдлаар ашиглах гэж буй тохиолдолд тухайн этгээдэд⁷¹ газрын түрээслүүлэх;
- Төрөөс нутгийн өөрөө удирдах байгууллага эсхүл Засгийн газрын тогтоолд заасан хуулийн этгээдтэй захиргааны өмчийн газрын дээрх барилгыг хамтран өмчлөхийн тулд тухайн этгээдэд тухайн газрыг түрээслүүлэх;
- Төрөөс захиргааны өмчийн газар болон түүний хажуугийн газрын дээр байгаа байгаа барилгыг төрөөс өөр этгээдтэй хамтран өмчлөхийн тулд тухайн этгээдэд газрыг түрээслүүлэх;
- Төрийн байгууллагын зориулалтай барилгын хэрэглээний тухай тусгай хуулийн 2.2.-т заасан барилгын дотоод болон гадаад талбайд илүүдэл байгаа хэмээн Засгийн газраас тогтоосон тохиолдолд төрөөс өөр этгээдэд тухайн илүүдэл хэсгийг түрээслүүлэх;
- Захиргааны өмчийн газрын ашиглах эрхийг нутгийн өөрөө удирдах байгууллага эсхүл Засгийн газрын тогтоолд заасан хуулийн этгээдийн

⁶⁸ Г.Давааням, Япон улсын төрийн өмчийн удирдлага, түүний эрх зүйн зохицуулалт, 27 (ННФ, 2022) 国有財産法 5 条。

⁶⁹ Мөн тэнд. 国有財産法 18 条。

⁷⁰ Мөн тэнд. 国有財産法 18 条 2 項。

⁷¹ Тухайн этгээд гэж тухайн хөрөнгийг харъяалах яам, агентлагуудын дарга нар зохих журмын дагуу тохиромжтой гэж үзсэн этгээдийг хэлнэ.

- ажиллуулж байгаа төмөр зам, машин зам болон бусад Засгийн газрын тогтоолд заасан байгууламжийн зориулалтаар тухайн этгээдэд олгох
- Захиргааны өмчийн газарт нутгийн өөрөө удирдах байгууллага, эсхүл Засгийн газрын тогтоод заасан хуулийн этгээдийн ашиглаж буй гэрлийн шугам болон бусад Засгийн газрын тогтоолд заасан байгууламжийн зориулалтаар тухайн этгээдэд сэрвитут эрх олгох;

Түүнчлэн дээр дурдсан хэлбэрээр захиргааны өмчийн газрыг түрээсэлж авсан этгээд нь тухайн газар дээрх барилгын өөрт ногдох хэсгийг бусдад шилжүүлэх тохиолдолд тухайн хөрөнгийг харъяалах яам, агентлагын дарга нарын тохиромжтой гэж үзсэн этгээдэд шилжүүлэн түрээслүүлж болно⁷². Мөн захиргааны өмчийн зориулалтад нийцсэн тохиолдолд тухай хөрөнгийг бусдад ашиглуулж, түүнээс ашиг хүртэх боломжийг зөвшөөрч болно. Тухайлбал, Нутгийн өөрөө удирдах байгууллага нь хуульд заасан хуулийн этгээд эсхүл нийтийн өмчлөлийн компани захиргааны өмчийг зам, усан сувгын зориулалтаар тухайн газрыг ашиглах эрх, сервитутын эрхийг олж авсан тохиолдолд тухайн этгээд газрыг хариу төлбөргүй түрээслүүлэх эсхүл ашиг олох боломжийг олж авч болохоор зохицуулсан байна⁷³. Харин хуулиар зөвшөөрсөнөөс бусад хэлбэрээр захиргааны өмчийг захиран зарцуулсан тохиолдолд эрх зүйн дагаварын хувьд тухайн хэлцэл нь хүчин төгөлдөр бус байхаар зохицуулсан⁷⁴.

Ердийн өмчийг удирдах, захиран зарцуулах

Ердийн өмчийг Сангийн яамны сайд удирдана⁷⁵. Ингэхдээ, ердийн өмчийн хамаарах хөрөнгийг дараахь хэлбэрээр захиран зарцуулж болно⁷⁶. Үүнд, (i) түрээслүүлэх, (ii) удирдлагыг шилжүүлэх, (iii) арилжаа хийх (өөр хөрөнгөөр солих), (iv) худалдах, (v) шилжүүлэн олгох, (vi) хөрөнгө итгэмжлэх, (vii) бусад аргаар хувийн эрх зүйн эрх олгож болно. Мөн ердийн өмчийн хөрөнгийг хуульд өөрөөр зааснаас бусад тохиолдолд хөрөнгө оруулах зорилгоор ашиглаж болохоор зохицуулсан⁷⁷. Түүнчлэн ердийн өмчийг захиран зарцуулах хүрээнд Төрийн өмчийн тухай хуульд нийцүүлэн баталсан 1952 оны Төрийн өмчийн тусгай арга хэмжээний тухай хууль хүчин төгөлдөр үйлчилж байна. Уг хууль зорилго нь нийтийн эрх ашгийг дээдлэх, иргэдийн тогтвортой байдал, аж ахуйн үйл ажиллагаанд Төрийн өмчийн тухай хууль дахь “төрийн ердийн өмч”-ийн хөрөнгийг үр дүнтэй ашиглуулахын тулд түүнийг удирдах, захиран зарцуулах тусгай журмыг бий болгоход чиглэсэн⁷⁸.

⁷² Г.Давааням, Япон улсын төрийн өмчийн удирдлага, түүний эрх зүйн зохицуулалт, 30 (ННФ, 2022) 国有財産法 18 条 3 項。

⁷³ Мөн тэнд. 国有財産法 18 条 7 項。

⁷⁴ Мөн тэнд. 国有財産法 18 条 5 項。

⁷⁵ Мөн тэнд. 国有財産法 6 条。

⁷⁶ Мөн тэнд. 国有財産法 20 条。

⁷⁷ Мөн тэнд. 国有財産法 20 条 2 項。

⁷⁸ Г.Давааням, Япон улсын төрийн өмчийн удирдлага, түүний эрх зүйн зохицуулалт, 31 (ННФ, 2022) 国有財産特別措置 1 条。

БНЭУ

Эстони улсын Төрийн хөрөнгийн тухай хуулийн 3 дугаар бүлэг нь төрийн өмчийг ашиглуулах харилцааг бүхэлд нь зохицуулдаг. Төрийн өмчийг ашиглалтад шилжүүлэх гэж төрийн өмчийг ашиглах эрхийг өөр этгээдэд ашиглах гэрээний үндсэн дээр олгохыг хэлнэ⁷⁹. Төрийн өмчийг бусдын ашиглалтад шилжүүлэх үндэслэл, ашиглалат шилжүүлэх хэлбэр, ашиглалтын төлбөр, үл хөдлөх эд хөрөнгийн ашиглалтын төлбөрийн үнэлгээ, ашиглалтын гэрээний хугацаа гэх зэргээр нарийвчлан зохицуулсан.

Мөн төрийн өмчийн хөрөнгийг ашиглуулах гэдэгт зөвхөн эд хөрөнгө хамаарахгүй бөгөөд эд юмсын хязгаарлагдмал эрхийн дагуу төрийн өмчийг ашиглуулах харилцаа хамаардаг бөгөөд хөрөнгө ашиглуулах нийтлэг зохицуулалт үйлчилэхээс гадна эд юмсын хязгаарлагдмал эрхтэй холбоотой тусгай журамд нийцүүлнэ⁸⁰.

Ашиглалтад шилжүүлэх үндэслэл ба хязгаарлалт

Төрийн хөрөнгийн тухай хуулиар төрийн өмчийг ашиглалтад шилжүүлэх дараах үндэслэлүүдийг заасан⁸¹. Үүнд:

1) тухайн өмчийн удирдлагад уг өмчийг түр хугацаанд ашиглах шаардлагагүй болсон үед;

2) энэ хуулийн 18 дугаар зүйлийн (2) дахь хэсэгт заасан тохиолдолд;

3) өмчийг удирдах зорилго нь орлого олох үед;

4) өмчийг нөөц байдлаар хадгалах зорилгоор ашиглалтад шилжүүлэх үед;

5) хуульд заасан бусад тохиолдолд.

Хэрэв төрийн өмчийг ашиглалтад шилжүүлэх нь тухайн өмчтэй холбоотой төрийн өмчийг зориулалтын дагуу ашиглахад ноцтой хүндрэл учруулах, эсхүл боломжгүй болгох тохиолдолд ашиглалтад шилжүүлэхийг хориглохоос гадна төрийн өмчийг барьцаанд тавихыг хориглоно. Үл хөдлөх хөрөнгийн хувьд, төрийн өмчийн удирдлага нь уг өмчийг ашиглалтад шилжүүлэх үйл ажиллагааг эхлүүлэхээс өмнө, уг өмчийг төрийн ашиг сонирхолд нийцэх байдлыг тодорхойлох үүрэгтэй бөгөөд төрийн өмчийг ашиглалтад шилжүүлснээр төр хохирол амсах ёсгүй.

Ашиглалтад шилжүүлэх аргын хувьд төрийн өмчийг дараах аргаар ашиглалтад шилжүүлнэ:

1) нээлттэй дуудлага худалдаа;

2) сонгон шалгаруулалт;

3) олон нийтийн дуудлага худалдаа эсвэл сонгон шалгаруулалтгүйгээр хөрөнгийн удирдлагын шийдвэрийн үндсэн дээр (шууд гэрээ байгуулах журам).

Ялангуяа, төрийн өмчийн хөрөнгийг бусдын ашиглалтад шилжүүлэх шийдвэр гаргах журам, ашиглуулах гэрээнд тусгах нөхцөл, хөдлөх болон үл хөдлөх эд

⁷⁹ State Assets Act 14.1

⁸⁰ State Assets Act 14.2

⁸¹ State Assets Act 15.1

хөрөнгийн хувьд гэрээний хугацаа, тавигдах шаардлага зэргийг ялгамжтай хуульчилсан онцлогтой.

Долоодугаар бүлэг. Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, тооллого

Q1. Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, тооллого бүрэн хийгдэж чадаж байгаа юу?

ТБОНӨТХ-ийн 70 дугаар зүйлийн 70.1-д зааснаар “Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгө, үнэт цаас, мөнгөн хөрөнгийн тооллогыг дотоодын тооллого, улсын тооллого гэж хоёр хуваана”, 70.2 “Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж, улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана”, 70.4-т “Үндсэн хөрөнгийн, шаардлагатай гэж үзвэл эргэлтийн хөрөнгийн улсын үзлэг тооллогыг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага 4 жилд 1 удаа Засгийн газрын бүрэн эрхийн хугацаа эхэлсэн анхны жилийн IV улиралд багтаан явуулна” гэж заасан.

ТБОНӨТХ-ийн 70.4-т заасны дагуу төрийн болон орон нутгийн өмчийн улсын тооллого өнөөдрийг хүртэл нийт 7 удаа явагдсан бөгөөд хамгийн сүүлд 2022 онд явуулсан байна.

Хүснэгт 11⁸². Улсын нэгдсэн тооллогын харьцуулалт

Өмчлөгч	Тооллогод хамрагдсан нийт хөрөнгийн дүн /сая.төг/						
	1996.12.31	2000.12.31	2003.12.31	2007.12.31	2011.12.31	2015.12.31	2021.12.31
Орон нутаг	0.00	272.66	701.95	673.96	2,403.34	3,839.27	11,901.70
Төр	1,531.97	2,083.89	2,451.08	3,458.16	12,057.34	12,425.38	79,896.85
Нийт дүн	1,531.97	2,356.55	3,153.03	4,132.12	14,460.68	16,264.65	91,798.55

Дээрх хүснэгт 11-аас үзвэл улсын тооллого явагдсан дийлэнх цаг хугацаанд төрийн болон орон нутгийн өмчийн дүн өссөн үзүүлэлттэй бөгөөд ялангуяа, 2016 оноос 2022 оны хооронд төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгө огцом өссөн үзүүлэлттэй байна. Сүүлийн жилүүдэд улс орны эдийн засгийн үзүүлэлт сайжрахыг дагалдан төсвийн хөрөнгө оруулалт, хандив, зээл, тусламжаар ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт хийсэнтэй шууд холбоотой. Хэдийгээр төрийн болон орон нутгийн өмчилж буй хөрөнгийн дүн өссөн боловч төрийн болон орон нутгийн өмчөөс бусдад төлөх өр, төлбөрийг хасч тооцсон цэвэр хөрөнгийн дүнг /өөрийн хөрөнгө/ авч үзвэл төрийн болон орон нутгийн өмчийн цэвэр хөрөнгийн дүн 16,264.65 сая төгрөгөөс 2022 оны улсын тооллогоор 39,737.23 сая төгрөг болсон нь нийт бүртгэгдсэн

⁸² ТӨБЗГ, Улсын нэгдсэн тооллогын тайлан, 32, (2021).

хөрөнгөтэй харьцуулахад түүнд эзлэх өр төлбөрийн хувь их хэмжээгээр нэмэгдсэн болохыг харуулж байна⁸³.

Ийнхүү төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгийн нийт дүн өсч байгаа нь төрийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй болгох, нийтийн дэд бүтцийг сайжруулах зэрэг олон талын ач холбогдолтой боловч төрийн болон орон нутгийн өмч хөрөнгө нэмэгдэх тусам тухайн өмч хөрөнгийг үнэн зөв бүртгэх, хариуцах эзэнтэй болгох замаар ашиглалт, үр өгөөжийг нэмэгдүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэхгүйгээр төрийн болон орон нутгийн өмч хөрөнгө эзэнгүйдэх, улмаар хууль тогтоомжийн зохицуулалтын хангалтгүй байдлыг ашиглаж нийтийн хөрөнгийг шамшигдуулах сөрөг үр дагаврыг дагуулдаг. Тухайлбал, 2022 оны улсын нэгдсэн тооллогоос үзэхэд төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэлд тусгагдаагүй 358,801,353,816.36 төгрөг, дутагдуулсан 2,235,555,055.98 төгрөг, маргаантай хөрөнгийн нэгдсэн дүн 41,270,724,412.82 төгрөг болсон байна⁸⁴.

Зөвхөн дээрх тоон мэдээллээс үзэхэд маш их хэмжээний төрийн болон орон нутгийн хөрөнгө бүртгэгдээгүй, эсхүл дутуу бүртгэсэн, бусад этгээдтэй өмчлөлийн маргаантай нөхцөл байдалтай байгааг тодорхой харж болно. Тэгвэл одоогийн мөрдөгдөж буй ТБОНӨТХ-д төрийн өмчийн эд хөрөнгийн бүртгэлтэй холбоотой ганцхан зүйлийг тусгасан.

Тодруулбал, хуулийн 69.1-д “төрийн өмчит хуулийн этгээд нь анхан шатны бүртгэлийн баталгаажсан баримтыг үндэслэн дэлгэрэнгүй ба хураангуй бүртгэл хөтлөн, тайлан тэнцлийг улирлаар зохиож Сангийн яаманд тушаана”, 69.2 “Заавал хөтлөх нягтлан бодох бүртгэлийн нийтлэг маягтаас гадна төрийн өмчийн хуулийн этгээдэд хөтлөгдвөл зохих мэдээ, тайлангийн маягт, аргачлалыг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батлан мөрдүүлж болно” гэсэн зүйлээс өөрөөр төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэлийг хэрхэн хөтлөх, ямар төрлийн бүртгэл, төрийн өмчийн дийлэнх хэсгийг бүрдүүлдэг газрыг хэн яаж бүртгэх зэрэг олон асуудал тодорхойгүйтэй холбоотой.

Төрийн өмчийн барилга байгууламж болон үл хөдлөх хөрөнгийн Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн байгууллагад бүртгүүлэхгүй байх, хувийн хэвшлийн хуулийн этгээдийн нэр дээр бүртгүүлэх зэрэг асуудлууд үүссээр байна. Тухайлбал, орон нутгийн өмчид бүртгэлтэй 22 ахмадын хороо нь ТББ гэрчилгээтэй, орон нутгийн өмчийн 124 эм эргэлтийн сангууд байгаагаас 22 нь ХХК, 41 нь ОНӨҮГ, 51 нь статусгүй буюу “сан ” нэртэй боловч хуулийн этгээдийн бүртгэлд бүртгэгдэж гэрчилгээ аваагүй байгаа нь тухайн байгууллагуудад эзэмшүүлсэн хөрөнгүүд ашиглалтгүй бол үйл ажиллагаа доголдох нөхцөл байдалд хүрсэн байна⁸⁵.

ТӨБЗГ-аас ТБОНӨТХ-ийн 69.2-г үндэслэн 2019.6.18-ны 269 тоот “Мэдээ, тайлангийн маягт батлах тухай” тогтоолоор дараах маягтыг баталсан байна. Үүнд:

- (i) Хавсралт 1 “Нээлттэй дуудлагын худалдааны зар мэдээ”

⁸³ ТӨБЗГ, Улсын нэгдсэн тооллогын тайлан, 33, (2021) тоон мэдээллээс дүгнэв.

⁸⁴ Мөн тэнд, 90-95, (2021) тоон мэдээллээс дүгнэв.

⁸⁵ Мөн тэнд, 7, (2021).

- (ii) Хавсралт 2 “Дуудлагын худалдаанд оролцох хүсэлтийн маягт”
- (iii) Хавсралт 3 “Дуудлагын худалдааны тэмдэглэлийн тайлан”
- (iv) Хавсралт 4 “Худалдах, худалдан авах гэрээний маягт”

Гэвч дээрх 4 төрлийн маягт нь төрийн болон орон нутгийн өмчийн бүртэглтэй хамааралгүй буюу дуудлага худалдаа явуулахтай холбоотой маягтууд юм.

Иймд одоогийн хуулиар зохицуулаагүй байгаа дараах асуудлыг хуульд нарийвчлан зааж, төрийн байгууллагуудын чиг үүрэг, өмч хөрөнгийн бүртгэлийг цэгцлэх зайлшгүй шаардлагатай гэж дүгнэж байна. Үүнд: (i) Монгол Улсын иргэнд өмчлүүлснээс бусад төрийн өмчийн газрыг нэгдсэн бүртгэлжүүлж, түүнээс иргэн, хуулийн этгээд, төрийн болон орон нутгийн байгууллагад эзэмшүүлж, ашиглуулж байгаа газрыг нэг бүрчлэн эрхийн нэгдсэн бүртгэлд хамруулж, эзэмшигч, ашиглагчийн эд хөрөнгийн эрхийг баталгаажуулах (гэхдээ энэ харилцаа нь ТБОНӨТХ-аар зохицуулахаас илүүтэй газрын тухай хуулиар зохицуулах харилцаа боловч ТБОНӨТХ-д төрийн өмчийн газартай холбоотой суурь харилцааг зохицуулах, төрийн болон орон нутгийн байгууллагаас эзэмшиж, ашиглаж буй газрыг бүртгэлжүүлэх асуудлыг зохицуулах), (ii) төрийн байгууллагуудын үл хөдлөх эд хөрөнгийг Эрхийн улсын бүртгэлд зайлшгүй бүртгүүлж, өмчлөх эрхийг баталгаажуулж, хариуцах эзнийг тодорхой болгох, (iii) орон нутгийн өмчийн бүртгэлийн тогтолцоог төрийн өмчтэй адилаар нарийвчлан зохицуулах, (iv) төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл хөтлөх нийтлэг журмыг журмаар бус хуулиар бий болгох шаардлагатай байна. Улмаар төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэлийн нэгдсэн систем үүсгэж, түүнээс хувьчлах болон иргэн хуулийн этгээдэд эзэмшүүлж, ашиглуулах эд хөрөнгийн мэдээллийг олон нийтэд нээлттэй болгох замаар нийтийн өмчийн үр ашгийг дээшлүүлэх нь зүйд нийцнэ. Гэхдээ анхаарах зүйл нь төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл нь эд хөрөнгийн эрхийн бүртгэлд суурилах шаардлагатай бөгөөд эрх үүсгэх шинжгүй байна.⁸⁶ Учир нь манай улсын эд хөрөнгийн бүртгэлийн тогтолцоонд эрх үүсгэх бүртгэл нь тухайн иргэн, хуулийн этгээдийн эд хөрөнгийн эрхийг баталгжуулах зорилгоор хийгддэг нэгдсэн бүртгэл учир төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл нь эд хөрөнгийн эрхийн бүртгэлтэй адил эрх зүйн үр дагавар үүсгэх шинжтэй бүртгэл бус тухайлсан буюу хөрөнгийн удирдлага, бүрэн бүтэн байдал, үр ашигтай зохион байгуулалт, хяналтыг хэрэгжүүлэх зорилго бүхий бүртгэл байна.

Харин төрийн өмчийн тооллого, тооллого явуулах журам, тооллогын комисс, тэдгээрийн чиг үүргийг хуулиар нарийвчлан зохицуулсан бөгөөд улсын хэмжээнд нийт 7 удаагийн тооллогыг зохион байгуулж, холбогдох зөвлөмж, саналыг гаргаж байсан байна. Гэхдээ одоогийн хуулиар орон нутгийн өмчийн нэгдсэн тооллогыг төрийн өмчийн улсын тооллоготой хамтатган явуулж байна. Угтаа хуулийн зарчмаар орон нутгийн өмчийн өмчлөгч нь тухайн орон нутгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал өмчлөгч байхаар (ТБОНӨТХ 77.1) заасан боловч 78.4 “Засаг дарга нь орон нутгийн өмчийн эд хөрөнгийн нэгдсэн бүртгэл хөтлөх, эд хөрөнгийн тооллого явуулах ажлыг зохион байгуулах” гэж хэт ерөнхийлөн заасан тул орон нутаг бие даан өөрийн

⁸⁶ Н.Баярмаа, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн төсөлд өгөх санал, шүүмж, ННФ Цуврал №40, 2022.6, 12.

өмчийн эд хөрөнгийг бүртгэх, тооллого явуулах журмыг нарийвчлан заах нь зохимжтой.

Япон улс

Төрийн өмчийг удирдах, захиран зарцуулах процессыг зохистой, үр дүнтэй явуулахын тулд төрийн өмчийн өнөөгийн байдлыг хянах шаардлагатай байдаг. Улмаар яам, агентлагууд⁸⁷ эсхүл тэдгээрийн доод шатны байгууллагууд нь төрийн өмчийн журналыг хөтөлж, өөрт харъяалагдах хөрөнгийг бүртгэх үүргийг хүлээнэ⁸⁸. Төрийн өмчийн журнал нь хөрөнгийн ангилал (газар, мод, барилга, тариа будаа гэх ангилал), төрөл (байгууламж барих газар, орон сууцны газар, хээр тал зэргийн ангилал, барилгын хувьд оффисын барилга, орон сууцны барилга гэх ангилал), байршил, тоо хэмжээ, үнэ, олж авсан, устгалд оруулсан, шилжүүлсэн он сар өдөр, түүний шалтгаан, бусад шаардлагатай зүйлс зэргээс бүрдэнэ.

Төрийн өмчид шинээр олж авсан, харъяалах газрыг нь өөрчилсөн, захиран зарцуулсан, бусад үндэслэлээр өөрчлөлт орсон бол түүний өсөлт, бууралтыг журналд бүртгэнэ. Төрийн өмчийн бүхий л хөрөнгийг журналд бүртгэх боловч, зарим төрлийн хөрөнгийг бүртгэхгүй байхаар зохицуулсан. Үүнд:

- нийтийн зориулалтай цэцэрлэгт хүрээлэн, олон нийтийн зориулалтай хэмээн тогтоосон бусад зүйлс (газар, гол горхи, далай нуурын эрэг г.м.);
- ердийн хөрөнгө дотроос нутгийн өөрөө удирдах байгууллагад түрээслүүлсэн хөрөнгө хамаарна.

Эдгээр хөрөнгө нь гагцхүү олон нийтэд зориулалттайгаар ашиглагдах бөгөөд түүнийг төрийн зүгээс захиран зарцуулах боломж хязгаарлагдмал байдаг тул төрийн өмчийн журналд бүртгэх нь төдийлэн ач холбогдол багатай юм. Төрийн өмчийн журналд хөрөнгө тус бүрийн үнэлгээг тусгах шаардлагатай бөгөөд бүртгэлтэй байгаа хөрөнгийн үнэлгээ нь зарчмын хувьд тухайн хөрөнгийг олж авсан үеийн үнэлгээнд суурилсан байх ёстой. Уг үнэлгээнд жилд нэг удаа өөрчлөлт оруулах шаардлагатай байдаг⁸⁹. Төрийн өмчийн журналыг “Төрийн өмчийн нэгдсэн мэдээллийн систем” ашиглаж эхэлсэнээс хойш буюу 2010 оны 1 сараас эхлэн цахим хэлбэрээр хөтлөгдөх болжээ.

Наймдугаар бүлэг. Төрийн болон орон нутгийн өмчийн хяналт

Q1. Төрийн болон орон нутгийн өмчид тавих төрийн хяналтын тогтолцоо бүрдсэн үү?

ТБОНӨТХ-ийн 66 дугаар зүйлийн 66.1-д “Төрийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, эзэмшилт, ашиглалт, захиран зарцуулалтад тавих төрийн хяналт шалгалт нь Улсын Их Хурал, Засгийн газраас тавих ерөнхий хяналт, Төрийн

⁸⁷ Төрийн өмчийн тухай хуулийн 32-р зүйлд заасны дагуу “яам, агентлагууд” гэдэгт Парламентын дээд болон доод танхим, Засгийн газар, түүний яам, агентлагууд, Улсын Дээд шүүх хамаарна.

⁸⁸ 国有財産法 32 条。

⁸⁹ Төрийн өмчийн тухай хуулийг хэрэгжүүлэх журмын тухай хууль 23-р зүйл (төрийн өмчийн аж ахуйн нэгжийн үнэлгээнд хамаарахгүй)

хянан шалгах хороо, Сангийн яам болон төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас хэрэгжүүлэх мэргэжлийн хяналт шалгалт, хуулийн этгээдийн дотоодын хяналт шалгалтаас бүрдэнэ” гэж заасан.

Хүснэгт 12. Төрийн болон орон нутгийн өмчийн хяналтын төрөл

Хяналтын төрөл	Хяналт хэрэгжүүлэх байгууллага
Ерөнхий хяналт	- УИХ - ЗГ
Мэргэжлийн хяналт, шалгалт	- Төрийн хянан шалгах хороо - Сангийн яам - Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага
Дотоод хяналт	- Хуулийн этгээд өөрөө хэрэгжүүлэх
Хөндлөнгийн магадлан шалгалт	- ТӨБЗГ болон эрх бүхий бусад байгууллагын захиалгаар хийх

Төрийн болон орон нутгийн өмчийн хяналтын тогтолцоог хуульд заасны дагуур дээрх 4 хэлбэрээр хэрэгжүүлэхээр заасан. Гэхдээ үүнд орон нутгийн өмчийн хяналтыг хэрхэн хэрэгжүүлэх талаар тусгайлсан зохицуулалт байхгүй бөгөөд ТБОНӨТХ-ийн 77.2.1-д “ИТХ нь орон нутгийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдлыг хянан шалгах буюу түүнд тавих хяналт шалгалтыг зохион байгуулах” гэснээс өөрөөр орон нутгийн өмчид тавих хяналтын хэлбэрүүд зохицуулагдаагүй.

Харин төрийн өмчид тавих дээрх 4 төрлийн хяналтын талаар ТБОНӨТХ-д хяналт хэрэгжүүлэх арга хэрэгслийн талаар нарийвчлан зохицуулаагүй тул холбогдох бусад хууль тогтоомжид хэрхэн заасан талаар дэлгэрүүлэн авч үзье. УИХ хэрэгжүүлэх ерөнхий хяналтын талаарх зохицуулалтыг судалж үзэхэд УИХ нь 2024.5.26-ны өдөр батлагдсан “Монгол Улсын Их хурлын хяналт шалгалтын тухай хууль” /шинэчилсэн найруулга/-д заасны дагуу хяналт шалгалтыг хэрэгжүүлэх талаар зохицуулжээ. Ингэхдээ МУИХХШТХ-д зааснаар УИХ нь (i) асуулт тавих, (ii) асуулга тавих, (iii) хууль тогтоомжийн биелэлтийн үр дагаварт үнэлгээ хийх, (iv) мэдээлэл сонсох, тайлан, илтгэл хэлэлцэх, (v) төсвийн хяналт, (vi) хяналтын сонсгол хийх, (vii) хянан шалгах түр хороо байгуулж, тусгай шалгалт явуулах гэсэн 7 төрлийн арга хэрэгслээр хянан шалгах эрхээ хэрэгжүүлнэ.

Үүнээс төрийн өмчийн хяналттай холбоотой УИХ-аас хяналт тавих тусгайлсан зохицуулалт байхгүй боловч ТБОНӨТХ-ийн 8.1.2-т заасан “төрийн өмчийн улсын нэгдсэн тооллогын дүнгийн тухай Засгийн газрын тайланг хэлэлцэх, төрийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрх хэмжээг тогтоох” бүрэн эрхийн хүрээнд ерөнхий хяналтыг хэрэгжүүлэх эрх зүйн үндэс бүрдсэн гэж дүгнэж байна. Түүнчлэн

МУИХХШТХ-д УИХ-аас хянан шалгах чиг үүргээ хэрэгжүүлэхдээ төрийн байгууллагуудаас мэдээлэл авах, хяналтын сонсгол хийх зэргээр процесс ажиллагааг мөн зохицуулсан. Энэ хүрээнд төрийн өмчит компани болох Тавантолгой ХК-ийн “Нүүрсний сонсгол”, ЗГ-ын тусгай сан болох Болосвролын зээлийн сан, Хөгжлийн банкны гэх хэд хэдэн нээлттэй сонсголчуудыг УИХ-аас зохион байгуулсан нь төрийн ерөнхий хяналтыг хэрэгжүүлж буй үйл явц гэж дүгнэх боломжтой.

ЗГ-аас тавих хяналтын хувьд ЗГТХ-аар ТБӨНТХ-тай холбоотой хяналт хэрэгжүүлэх талаар зохицуулаагүй бөгөөд тус хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 “төрийн өмчийн талаархи төрийн бодлого, хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах”, 9.8 “төрийн өмчийн эд хөрөнгийн нэгдсэн тооллогын дүн, төсвийн гүйцэтгэлийн тайланг УИХ-д өргөн мэдүүлж, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх” бүрэн эрхийн хүрээнд хяналт хэрэгжүүлэх боломжтой. Гэхдээ УИХ болон ЗГ-аас хэрэгжүүлэх хяналт нь ерөнхий хяналт тул төрийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгө, үйл ажиллагаанд тухайлсан хяналт хийх боломжгүй юм.

Энэхүү тухайлсан буюу мэргэжлийн хяналтыг ТБОНӨТХ-аар Сангийн яам, төрийн хянан шалгах хороо, ТӨБЗГ хэрэгжүүлэхээр заасан. Гэхдээ төрийн хянан шалгах хороо гэдэг нь ямар байгууллага болох нь тодорхогүй буюу бусад хууль тогтоомжид төрийн хянан шалгах хороо гэсэн нэр томъёо хэрэглэгдээгүй. Улмаар төрийн хянан шалгах хороо гэдгийг Төрийн аудитын тухай хуулийн 4.1.3-т заасан “төрийн аудитын байгууллага” гэж ойлгох эсэх, эсхүл Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлд заагдсан “Хяналт шалгалтын байгууллага” эсэх нь ойлгомжгүй буюу тодорхойгүй байна. Өөрөөр хэлбэл, төрийн өмчийн мэргэжлийн хяналтыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллагыг бусад хууль тогтоомжтой нийцүүлэн өөрчилж, байгууллагын чиг үүргийн давхцал, хийдлийг арилгахгүйгээр төрийн өмчид тавих мэргэжлийн хяналт бүрэн хэрэгжих боломж хязгаарлагдмал болно. Хуучнаар Төрийн аудитын байгууллагыг төрийн хянан шалгах хороо гэж нэрлэж байсан боловч Төрийн аудитын тухай хууль гарч, төрийн аудитын байгууллага болгон өөрчилсөн ч тухайн хуулийг дагасан өөрчлөлт ТБОНӨТХ-д ороогүй гэж үзэхэд хүргэж байна.

Түүнчлэн төрийн өмчийн хяналтын нэг чухал хэлбэр нь дотоодын хяналтын хэлбэр юм. Гэвч өмнөх бүлгүүдэд дурдсанчлан төрийн өмчит хуулийн этгээдийг зөв ангилан томъёолоогүйгээс болж төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоот компани, ААТҮГ, УТҮГ гэх өөр өөр хэлбэр бүхий аж аухйн үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээд бий болсон ч тэдгээрийн засаглал, хяналт хариуцлагыг тодорхойлон заагаагүйгээс төрийн өмчийн дотоод хяналт хангалтгүй байх, олон нийтийн зүгээс хүчтэй шүүмжлэл дагуулах нөхцөл болж байна.

Олон улсын сайн туршлагаас үзвэл төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой ААН-ийн үйл ажиллагааны хяналтыг тогтолцооны гол суурь нь ТУЗ-ийн дэргэдэх аудитын хорооны дотоод хяналт болон хөндлөнгийн мэргэжлийн аудитын

байгууллагаар үйл ажиллагаа, санхүү тайлангийн аудит хийлгэхийг зөвлөдөг.⁹⁰ Дотоод аудит нь төрийн өмчит аж ахуйн нэгжийн бүх төрлийн эд хөрөнгийн бүртгэл, түүний тайлагнал, үнэн зөв байдлыг тухай бүр болон тодорхой хугацааны давтамжтай хийх, гүйцэтгэлийг үнэлэх замаар үр ашигтай, найдвартай ил тод байдлыг бэхжүүлэх чухал үүргийг гүйцэтгэдэг.⁹¹

Иймд төрийн өмчит хуулийн этгээдийн ангилал, бүтцийг тодорхой болгож, төрийн өмчит компани, үйлдвэрийн газар болон аж ахуйн шинжтэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагыг төрийн өмчит компанийн хэлбэрээр өөрчлөн зохион байгуулж, хувийн өмчит компаниудад мөрдөгддөг ТУЗ, аудитын хороо, хөндлөнгийн аудит зэрэг үр нөлөө бүхий хяналтын тогтолцоог нэвтрүүлэх нь туйлын чухал юм.

УИХ, ЗГ-аас хэрэгжүүлэх төрийн өмчийн ерөнхий хяналтын чиг үүрэг хэрэгжих боломжтой ч төрийн өмчит хуулийн этгээдүүдэд мэргэжлийн хяналт тавих байгууллагуудын чиг үүргийн давхцал, зарим байгууллагын нэр томьёо нь ойлгомжгүй байдал зэргийг бусад хууль тогтоомжид нийцүүлэн өөрчлөх шаардлагатай. Ялангуяа, аж ахуйн шинжтэй үйл ажиллагаа явуулж буй төрийн өмчит хуулийн этгээдийн хэлбэрийг төрийн өмчит компанийн хэлбэрт өөрчлөн зохион байгуулах замаар дотоод хяналтын засаглалыг бий болгох, хөндлөнгийн хараат бус аудитын байгууллагаар хөндлөнгийн хяналт хийлгэдэг болох цогц эрх зүйн орчныг бүрдүүлэх нь төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөд тавих хяналтын тогтолцоог бэхжүүлж, нийтийн өмч хөрөнгө үнэ цэнгүйдэхээс сэргийлэх боломжтой болно.

ТӨБЗГ-аас хийх мэргэжлийн хяналтын хувьд 2016 он хүртэл Төрийн өмчийн хороо, түүнээс хойш ТӨБЗГ нэртэйгээр өөрчлөн зохион байгуулсан ч орон нутгийн өмч хариуцсан газар бүрэн бэхжээгүй, төрийн өмчит хуулийн этгээдэд ТӨБЗГ-аас хяналт шалгалт хийсэн ч тус байгууллагын албан хаагч нь бусад төрийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй байгууллагатай адил улсын байцаагчийн эрх олгогдоогүйгээс хяналт шалгалтаас илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, арга хэмжээ авах зэрэг эрх хэмжээ олгогдоогүй. Энэ нь төрийн өмчийн хөрөнгийг нэгдсэн зохион байгуулалтаар хангаж, удирдах, зохион байгуулах чиг үүрэг бүхий байгууллагын зүгээс хийх төрийн мэргэжлийн хяналтыг үр дүнгүй болгох тул (i) ТӨБЗГ-ын төрийн өмчид тавих мэргэжлийн хяналтын чиг үүргийг тодорхой болгох, (ii) улмаар хяналт тавих албан хаагчид улсын байцаагчийн статус олгох хэлбэрээр мэргэжлийн хяналтыг сайжруулах боломжтой.

Есдүгээр бүлэг. Төрийн болон орон нутгийн өмчийн тайлагнал ба мэдээллийн сан

Q1. Төрийн болон орон нутгийн өмчийн тайлагнал ба мэдээллийн сангийн тогтолцоо бүрдсэн үү?

⁹⁰ OECD (2024), *Ownership and Governance of State-Owned Enterprises 2024*, OECD Publishing, Paris, 94., <https://doi.org/10.1787/395c9956-en>.

⁹¹ Мөн тэнд.

Төрийн болон орон нутгийн өмчийн үр ашигт байдлыг дээшлүүлэх, хөрөнгийг бүрэн бүртгэж өмчлөх эрхийг баталгаажуулах нь төрийн өмч нэрийн дор хэн нэгэн эрх мэдэл, албан тушаалтан хувьдаа шамшигдуулах, зүй бус үйлдэл гаргахаас сэргийлэх, улмаар төрд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх боломжийг олгодог. Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгийн мэдээлэл нээлттэй ил тод байх, хүссэн иргэн, хуулийн этгээд тухайн мэдээллээр дамжуулан төрийн үйл ажиллагаанд хяналт тавих нөхцөлийг бүрдүүлэх агаад олон улсад хэрэглэгддэг нийтлэг арга болон хэвшсэн байна. Ялангуяа, төрийн өмчит ААН-ийн мэдээлэл, тайлагналын тогтолцоо нь орчин үеийн компанийн засаглалын чухал үзүүлэлтийн нэг болохын сацуу төрийн өмчийн үр ашигтай захиран зарцуулалт, ашиглалт хамгаалалтыг сайжруулах чухал хүчин зүйл юм.⁹²

Өөрөөр хэлбэл, төрийн өмчит хуулийн этгээдийн мэдээллийн ил тод байдал, тайлагналыг бусад хувийн хэвшлийн нээлттэй хувьцаат компаниудын төвшинд хүргэхийг Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас зөвлөдөг. Төрийн өмчийн ААН-тэй холбоотой бүхий материаллаг мэдээллийг ил тод байдал нь тэдгээрийн ТУЗ, гүйцэтгэх захирал, удирдлагын хариуцлагыг бэхжүүлэх, төр өөрийн хяналтаар дамжуулан өмчлөгчийн эрхээ хэрэгжүүлэх гол түлхүүр юм.⁹³

Харин манай улсын хувьд өнөөдрийг хүртэл төрийн болон орон нутгийн өмч хөрөнгийг бүрэн бүртгэлжүүлээгүйгээс нийтийн өмч хөрөнгө эзэнгүйдэх, үр ашиггүй байх нөхцөл байдал үргэлжилсээр байгааг дээрх бүлгүүдэд тодорхой дурдсан. Гэвч 2021 онд УИХ-аас Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийг баталсан бөгөөд төр өөрт байгаа хувь хүн, албан байгууллага, төрийн нууцад хамаарахаас бусад мэдээллийг нээлттэй мэдээлэх үүргийг холбогдох байгууллагад үүрэг болгосон.

Тус хуулиар төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээд, хууль, эсхүл гэрээний үндсэн дээр төрийн байгууллагын тодорхой чиг үүргийг гүйцэтгэж байгаа этгээд, олон нийтийн радио, телевиз, улс төрийн намыг нийтийн мэдээлэл хариуцагч гэж заагаад, улмаар хуулиар хязгаарлалттай болон хаалттай мэдээлэлд хамаарахгүй мэдээллийг нээлттэй мэдээлэл гэж үзэж нийтэд ил тод байхаар заасан.⁹⁴

Улмаар ЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга хэмжээний хөтөлбөрийн 4.1.4-ийн 5 дахь заалтад “Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн мэдээллийн нэгдсэн систем бий болгож, нийслэл, 21 аймгийн өмчийн мэдээллийн сан, төрийн бусад байгууллагын мэдээллийн сантай холбох”⁹⁵ гэсэн төлөвлөгөө тусгагдаж, ТӨБЗГ-ын даргын 2025 оны 1 сарын 22-ны өдрийн А/07 тоот “Цахим систем нэвтрүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авах тухай” тушаалаар

⁹² OECD (2024), *OECD Guidelines on Corporate Governance of State-Owned Enterprises 2024*, OECD Publishing, Paris, 51., <https://doi.org/10.1787/18a24f43-en>.

⁹³ Мөн тэнд.

⁹⁴ Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, 6, 7 зүйл.

⁹⁵ МУЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга хэмжээний хөтөлбөр <https://legalinfo.mn/storage/uploads/files/2020tog203h1.pdf>

төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн систем нэвтрүүлэх төлөвлөгөөг баталсан байна.

ТӨБЗГ-аас umch.sgov.mn (Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлжүүлэх систем) цахим системийг нээж, (i) төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн цахим бүртгэл үүсгэх, (ii) төрийн болон орон нутгийн өмчийн хайлт хийх, (iii) төрийн болон орон нутгийн өмч хөрөнгийн тайланг нийтлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.⁹⁶

Гэсэн хэдий ч одоогийн хууль эрх зүйн орчинд төрийн болон орон нутгийн өмчийн цахим систем үүсгэх эрх зүйн үндэс тодорхойлогдоогүй бөгөөд олон нийтэд нээлттэй тайлан гаргах үүрэг хүлээгээгүй. Тодруулбал, ТБОНӨТХ-ийн 70.2-т заасны дагуу “эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж, улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана”, 69.1-д “Төрийн өмчит хуулийн этгээд нь анхан шатны бүртгэлийн баталгаажсан баримтыг үндэслэн дэлгэрэнгүй ба хураангуй бүртгэл хөтлөн, тайлан тэнцлийг улирлаар зохиож Сангийн яаманд тушаана” гэснээс үзвэл төрийн өмчит хуулийн этгээдийн тайлан нь санхүү, хөрөнгийн бүртгэлийн шинжтэй тайлан бөгөөд Сангийн яаманд хүргүүлэх тайланг зохицуулсан.

Япон улсын хувьд 2010 оны 1 сараас эхлэн “Төрийн өмчийн нэгдсэн мэдээллийн систем” ашиглаж эхэлсэнээс хойш буюу цахим хэлбэрээр хөтөлж, (i) төрийн өмчийн өөрчлөлтийн тайлан, (ii) төрийн өмчийн үнэлгээний талаар урьдчилсан таамаглалын тайлан, (iii) төрийн өмчийг хариу төлбөргүй түрээслүүлсэн байдлын тайланг боловсруулж, холбогдох төрийн байгууллага, олон нийтэд нийтлэх үүргийг хүлээдэг.

Тиймээс одоогийн хуулиар зохицуулаагүй боловч ТӨБЗГ-аас гүйцэтгэн хэрэгжүүлж буй төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн цахим санг үүсгэх эрх зүйн үндсийг хуулиар тогтоох, түүний аюулгүй байдал, засвар шинэчлэлт, мэдээллийн найдвартай байдлыг төрийн зүгээс хангах, тухайн цахим мэдээллийн системд нийтлэх төрийн өмчит хуулийн этгээдийн тайланг тодорхой болгож, зөвхөн санхүү байдлын тайлан бус олон нийтэд ойлгомжтой байдлаар тайлбарласан жилийн тайлан гаргах үүргийг хуулиар бий болгох замаар төрийн болон орон нутгийн өмчийн ил тод байдлыг хангах боломжтой.

⁹⁶ ТӨБЗГ, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлжүүлэх системийн танилцуулга” 2025. <https://pcsp.gov.mn/wp-content/uploads/2022/01/User-guide.pdf>

ДҮГНЭЛТ

ТБОНӨТХ-ийн хэрэгжилтийн үр дагаврын судалгааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын Зургаадугаар хавсралтаар баталсан аргачлалын дагуу хийж гүйцэтгэлээ. Ингэхдээ одоогийн хүчин төгөлдөр хэрэгжиж буй ТБОНӨТХ-ийн бүтцэд баригдалгүйгээр аль болох одоогийн хуулиар дутуу зохицуулсан болон зохицуулагдаагүй байгаа харилцааг дүгнэх байдлаар нийт 9 бүлэгт хуваан хэрэгжилтийг дүгнэсэн.

Ингэхдээ гол анхаарал хандуулсан асуудал нь төрийн болон орон нутгийн өмчийн ангилал нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан “төрийн нийтийн өмч”-ийн үзэл баримтлалд нийцсэн эсэх, түүнээс улбаалж төрийн болон орон нутгийн өмчийн өмчлөгч, удирдалага хэрэгжүүлэгч, хяналт тавих субъектуудийн эрх мэдлийн хуваарилалт оновчтой хийгдсэн эсэх тухай байв. Мөн төрийн болон орон нутгийн өмчийг эзэмшиж, ашиглаж буй субъектууд болох төрийн өмчит хуулийн этгээдийн ангилал, хууль зүйн мөн чанар нь бусад хууль тогтоомжтой эсэхэд анхаарал хандуулж, дүгнэлт өгөхийг зорьсон.

Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын судалгааны бүлэг тус бүрт тодорхой асуултыг тавьж, хууль тухайн асуултад бүрэн хариулт өгөх хэмжээнд хэрэгжиж байгаа эсэхийг дүгнэсэн тул нарийвчилсан дүгнэлтийг бүлэг бүрээс дэлгэрүүлж унших боломжтой тул доорх хэсэгт хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг ерөнхийд нь дүгнэн үзье.

Нэгдүгээрт, 1996 онд батлагдсан Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль нь зах зээлийн шилжилтийн үеийн төрийн өмчийг удирдах, төрийн өмчийг хувьчлах харилцааг зохицуулахад чиглэсэн тул орчин үеийн нийгэм, эдийн засгийн харилцааны хурдацтай өөрчлөлтөд нийцэхгүй байна гэж дүгнэв. Өөрөөр хэлбэл, тус хуульд нийт 36 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан бөгөөд хуулийн бүтцийн үндсэн хэлбэр болох зүйлийн зохицуулалтын ойролцоогоор 80%-д өөрчлөлт орж⁹⁷, хуулийн үндсэн концепци алдагдсан.

Хоёрдугаарт, 2019 онд Монгол Улсын Үндсэн хууль орсон нэмэлт өөрчлөлтөөр “төрийн нийтийн өмч” гэх хууль зүйн нэр томъёог шинээр оруулсантай нийцүүлэн төрийн болон орон нутгийн өмчийн ангиллыг Үндсэн хуулийн үзэл санаанд нийцүүлэн шинэчлэх шаардлагатай. Улмаар одоогийн хуульд төрийн болон орон нутгийн өмчийг зөвхөн хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгө байхаар зохицуулсныг эдийн бус хөрөнгө мөн адил төрийн болон орон нутгийн өмч байх өөрчлөлтийг оруулах шаардлагатай.

Гуравдугаарт, өмчийн удирдлагын хүрээнд УИХ, Засгийн газар, ТӨБЗГ-ын өмчийг удирдах бүрэн эрх ойлгомжгүй, уялдаа холбоо тааруу, төрийн өмчийг эзэмшиж буй төрийн байгууллага, албан газар, компанийн эд хөрөнгийн эрх тодорхойгүй, төрийн өмчит хөрөнгө олж авах хязгаарлалт байхгүй, төрийн өмчийг захиран зарцуулах харилцааг шинж чанараар нь бус гэрээний төрлөөр шууд тулган

⁹⁷ УИХТГ, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн судалгаа. Хуулийн төслийн ажлын хэсэг. 2021 он.

зааж, өмчийн захиран зарцуулах уяан хатан байдлыг хязгаарласан, төрийн өмчийг бусдад шилжүүлэх, ашиглуулах арга нь ойлгомжгүй, уялдаа холбоо тааруу, төрийн өмчийн бүртгэл, тооллого, тайлагнал, хяналт, мэдээллийн тогтолцоо нь зөвхөн өөрийн өмчөөр хязгаарлагдсан байна гэж дүгнэв.

Дөрөвдүгээрт, төрийн болон орон нутгийн өмчийн эзэмшигч болох хуулийн этгээдийн ангилал нь Иргэний хуульд заасан хуулийн этгээдийн ангилалтай нийцэхгүй, засаглал, хяналт хариуцлагын тогтолцоо зохицуулалтгүй байна. Ялангуяа, төрийн өмчит хуулийн этгээд нэрийн дор УГҮГ, ААТҮГ, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд гэх аж ахуйн шинжтэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудыг Иргэний хууль болон Компанийн тухай хуульд заасан хуулийн этгээдийн хэлбэрээр өөрчлөн зохион байгуулж, олон улсад хэрэглэгддэг сайн засаглалыг нэвтрүүлэх шаардлагатай.

Тавдугаарт, одоогийн ТБОНӨТХ-иар зохицуулалтгүй байгаа харилцаа болон ерөнхий байдлаар зохицуулсан харилцааг хуулийг бүтцээр нь шинэчлэн найруулах замаар өөрчилж, төрийн болон орон нутгийн өмч нэрийн дор хяналт хариуцлагагүй ханддаг, хувийн болон гуравдагч этгээдийн эрх ашигт нийцүүлэн ашигладаг байдлыг халах шаардлагатай. Тухайлбал, төрийн болон орон нутгийн өмчид хөрөнгө олж авах аргуудыг дэлгэрүүлэх, түүнийг нэгдсэн бүртгэлд бүртгэлжүүлж, тайлагнадаг байх тогтолцоог нэвтрүүлэх шаардлагатай.

Зургаадугаарт, одоогийн ТБОНӨТХ-иар төрийн болон орон нутгийн өмчийн харилцааг зохицуулахаар заасан боловч орон нутгийн өмчийн харилцааг үндсэнд нь зохицуулаагүй орхигдуулсан гэж дүгнэхээр байна. Ялангуяа, орон нутгийн өмч гэх боловч сум, дүүрэг өмчтэй байх, түүнийг удирдах зохицуулалт байхгүй, орон нутгийн өмчийн бие даасан байдал алдагдсан зэрэг асуудлыг нэрлэж болно. Зарим тохиолдолд төрийн өмчийг зохицуулалтруу эш татсан байх боловч, төрийн өмчийг удирдах этгээд буюу УИХ, ЗГ зэргийг ИТХ, Засаг даргатай шууд адилтгүй боломжгүй юм. Иймд орон нутгийн өмчийн зохицуулалтыг төрийн өмчийн зохицуулалтаас салгаж зохицуулах шаардлага зүй ёсны байна.

Эцэст нь нэгтгэн дүгнэхэд, ТБОНӨТХ нь одоогийн цаг үеийн харилцааг бүрэн зохицуулж чадаагүй, анхны хуулийн үндсэн концепци алдагдаж, төрийн болон орон нутгийн өмчийн өмчлөгч, удирдлагын эрх, үүргийн давхцал зэрэг нөхцөл байдлаас бүрэн хэрэгжиж чадахгүй байна гэж дүгнэж байна. Иймд Монгол Улсын Үндсэн хууль болон дотоодын бусад суурь хууль тогтоомжтой нийцүүлэх, олон улсын сайн туршлагыг нэвтрүүлэх байдлаар одоогийн үйлчилж буй ТБОНӨТХ-ийг шинэчлэн найруулах шаардлагатай гэж дүгнэв.

Хавсралт 1. Шүүхийн шийдвэрийн тоон судалгаа

“Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-г 2016-2025 (3 сарын 9-ний байдлаар) оны хооронд Иргэний хэргийн шүүхийн шийдвэрт зохигчид болон шүүхээс үндэслэл болгон авсан шүүхийн шийдвэрийн тоог хүснэгт 13-ээр үзүүлэв.

Гарфик 1. ТБОНӨТХ-ийг үндэслэл болгосон шүүхийн шийдвэр




НИЙТ: 270

Дээрх шүүхийн шийдвэрүүдэд хамгийн олон давтагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-н зүйл заалтуудыг график 1-оор илэрхийлэв.

График 2. Шүүхийн шийдвэрт хамгийн олон давтагдсан ТБОНӨТХ-ийн зүйл заалт /хувь/

**Хамгийн олон давтагдсан Төрийн болон орон нутгийн
өмчийн тухай хууль"-н зүйл заалтууд**



Хүснэгт 13. Шүүхийн шийдвэрийн мэдээлэл

№	Он	Зүйл заалт	Зохигчид	Дугаар
1	2025	29.1	Иргэн хоорондын	150//ШШ2025/00023
2	2025	20.1.10	Н:Иргэн Х:ТӨҮГ	157/ШШ2025/00022
3	2024	13.1	Иргэн хоорондын	142/шш2024/01697
4	2024	14.1	Н:Б аймаг Прокурорын газар Х:Иргэн	130/ШШ2024/00974
5	2024	19.1	Н:Иргэн Х: Х аймгийн Засаг дарга	155/ШШ2024/01160
6	2024	77.1	Иргэн хоорондын	101/ШШ2024/05376
7	2024	77.1, 77.2.4	Иргэн хоорондын	101/ШШ2024/05200
8	2024	5.1.2, 16.1.1, 28.1	Н:Иргэн Х:ТӨҮГ ААТҮГ	101/ШШ2024/05001

9	2024	77.1, 77.2	Иргэн хоорондын	101/ШШ2024/04855
10	2024	77.1, 77.2.4	Н:Иргэн Х:Б дүүргийн ИТХ	101/ШШ2024/04856
11	2024	30.2	Н:Иргэн Х: ХХК	135/ШШ2024/01240
12	2024	20.1.10	Н:Иргэн Х: ХХК	150/ШШ2024/00184
13	2024	9 ¹ .1	Иргэн хоорондын	101/ШШ2024/04321
14	2024	71.1	Н:Иргэн Х: 3 аймгийн БДС	140/ШШ2024/00365
15	2024	14.1	Иргэн хоорондын	153/ШШ2024/00381
16	2024	77.1, 77.2.4	Иргэн хоорондын	101/ШШ2024/03989
17	2024	77.1	Н:Иргэд Х: Б дүүрэг засаг дарга, ИТХ	101/ШШ2024/03960
18	2024	14.1	Иргэн хоорондын	130/ШШ2024/00649
19	2024	14.1	Н:Б аймаг Прокурорын газар Х:Иргэн	130/ШШ2024/00622
20	2024	77.1, 77.2.4	Иргэн хоорондын	101/ШШ2024/03177
21	2024	20.1.4	Иргэн хоорондын	104/ШШ2024/00364
22	2024	20.1.2, 20.1.4, 20.1.10	Иргэн хоорондын	183/ШШ2024/02647
23	2024	71.1, 72.2, 73.1	Иргэн хоорондын	102/ШШ2024/03166

24	2024	14.1	Н:Б аймаг Прокурорын газар Х:Иргэн	130/ШШ2024/00589
25	2024	3.1	Иргэн хоорондын	101/ШШ2024/02455
26	2024	27.1, 28.1	Н:Иргэн Х: ТББ	183/ШШ2024/01740
27	2024	77.1	Н:Иргэн Х: ИТХ, НӨХГ	181/ШШ2024/01573
28	2024	14.1, 15.1	Н:Иргэн Х: СЯ	182/ШШ2024/01555
29	2024	20.1.4, 20.1.10	Иргэн хоорондын	183/ШШ2024/01414
30	2024	14.1	Иргэн хоорондын	153/ШШ2024/00125
31	2024	30.2	Иргэн хоорондын	102/ШШ2024/01285
32	2024	20.1.10	Н:Иргэн Х: ТӨХК	102/ШШ2024/01304
33	2024	12.1	Н:Иргэн Х: ТӨХХК	182/ШШ2024/00679
34	2024	20.1.10	Н:Иргэн Х: ХХК	135/ШШ2024/00226
35	2024	30.3	Иргэн хоорондын	102/ШШ2024/00757
36	2024	20.1.10	Н:Иргэн Х: ХХК	150/ШШ2023/00035
37	2024	18.1, 20.1.10	Н:Иргэн Х: ХХК	150/шш2024/00006/и

38	2023	20.1.10	Иргэн хоорондын	182/ШШ2023/03720
39	2023	20.1.10	Н:Иргэн Х: ХХК	150/шш2023/00214
40	2023	20.1.4, 20.1.10	Иргэн хоорондын	183/ШШ2023/04170
41	2023	20.1.10	Н:Иргэн Х: ХК	150/ШШ2023/00204
42	2023	20.1.10	Иргэн хоорондын	150/шш2023/00203
43	2023	20.1.4, 20.1.10	Иргэн хоорондын	183/ШШ2023/03906
44	2023	20.1.10	Иргэн хоорондын	150/ШШ2023/00194
45	2023	11.1, 11.2, 66.3	Иргэн хоорондын	181/ШШ2023/03694
46	2023	14.1	Н:Б аймаг Прокурорын газар Х:Иргэн	130/ШШ2023/00939
47	2023	18.1, 20.1.10	Н:Иргэн Х: ТӨХК	150/шш2023/00182
48	2023	70.1, 70.2, 72.1	Иргэн хоорондын	150/ШШ2023/00181
49	2023	20.1.10	Н:Иргэн Х: ТӨХК	152/ШШ2022/00425
50	2023	20.1.10	Иргэн хоорондын	150/ШШ2022/00167
51	2023	18.1, 20.1.11	Н:Иргэн Х: ТӨХК	143/ШШ2023/00438
52	2023	18.1	Н:Иргэн Х:ХК	182/ШШ2023/02622

53	2023	20.1.10	Н:Иргэн Х: ТӨХК	102/ШШ2023/03085
54	2023	20.1.10	Иргэн хоорондын	150/ШШ2023/00132
55	2023	2.4	Н:Иргэн Х:ААТҮГ	184/ШШ2023/02735
56	2023	15.2	Н:Иргэн Х:АТҮТ	181/ШШ2023/02096
57	2023	20.1.2, 20.1.10	Н:Иргэн Х: ТӨХК	102/ШШ2023/02367
58	2023	9.5	Н:Иргэн Х: МЭЕГ	101/ШШ2023/02882
59	2023	18.1	Н:Иргэн Х: Б аймаг Эрүүл мэндийн газар	130/ШШ2023/00492
60	2023	11.8	Н:Иргэн Х: ТӨҮГ	142/ШШ2023/00776
61	2023	20.1.2, 20.1.10	Иргэн хоорондын	102/шш2023/01812
62	2023	20.1.4, 20.1.10	Иргэн хоорондын	184/ШШ2023/01859
63	2023	20.1.10	Н:Иргэн Х: ДЦС ТӨХК	102/ШШ2023/01751
64	2023	20.1.2, 20.1.10	Н:Иргэн Х: ДЦС ТӨХК	102/ШШ2023/01564
65	2023	11.1, 11.2, 20.1.10, 66.3	Н:Иргэн Х: ТӨААТҮГ	184/ШШ2023/01470

66	2023	11.9, 18.5	Н:Иргэн Х: ТӨҮГ	181/ШШ2023/00990
67	2023	20.1.4	Н:Иргэн Х: ХХК	136/ШШ2023/00206
68	2023	20.1.4	Иргэн хоорондын	104/ШШ2023/00143
69	2023	6.1.1, 29.1, 30.1	Н:ХХК Х: Иргэн	101/ШШ2023/01127
70	2023	20.1.10	Иргэн хоорондын	142/ШШ2023/00140
71	2023	30.3	Иргэн хоорондын	102/ШШ2023/00262
72	2023	20.1.10	Н:Иргэн Х: ТӨХК	102/ШШ2023/00242
73	2023	1.1, 5.1, 14.1, 76.1, 77.1	Иргэн хоорондын	151/ШШ2023/00077
74	2022	20.1.10	Иргэн хоорондын	150/ШШ2023/00002
75	2022	20.1.10	Н:Иргэн Х: ОНӨААТҮГ	101/ШШ2023/00039
76	2022	20.1.10	Н:Иргэн Х: А төв	181/ШШ2023/00007
77	2022	23.1	Н:Иргэн Х: МУЗГ	181/ШШ2022/03095
78	2022	20.1.4	Н:Иргэн Х: ААНҮГ	182/ШШ2022/03406
79	2022	19.2	Н:Иргэн Х: Г аймгийн ЗД	133/ШШ2022/00574
80	2022	20.1.10, 39.1	Иргэн хоорондын	142/ШШ2022/01430

81	2022	9 ¹ .1	Н:Иргэн Х: ХХК	182/ШШ2022/03018
82	2022	69.3	Н:Иргэн Х: ХХК	181/ШШ2022/02318
83	2022	9 ¹ .1, 18.1, 19.1	Иргэн хоорондын	101/ШШ2022/04027
84	2022	9 ¹ .1, 11.1	Иргэн хоорондын	101/ШШ2022/03882
85	2022	21.2.3	Н:Иргэн Х: ТӨБЗГ	101/ШШ2022/03153
86	2022	20.1.2, 20.1.10	Н:Иргэн Х: ТӨХК	102/ШШ2022/02252
87	2022	6.1.1, 11.1, 25.1, 77.1	Н:Иргэн Х: ХХК	101/ШШ2022/02712
88	2022	20.1.2, 20.1.10	Н:Иргэн Х: ТӨХК	102/ШШ2022/02149
89	2022	20.1.10	Иргэн хоорондын	142/ШШ2022/00809
90	2022	20.1.4	Иргэн хоорондын	184/ШШ2022/01729
91	2022	9 ¹ .1, 9.3, 9.5, 23.1	Н:Иргэн Х: ХХҮГ, БХБЯ	133/ШШ2022/00188
92	2022	20.1.10	Н:Иргэн Х: ТӨХК	102/ШШ2022/01021
93	2022	20.1.10	Иргэн хоорондын	142/ШШ2022/00419
94	2022	20.1.4	Н:Иргэн Х: ОНӨААТҮГ	183/ШШ2022/00657

95	2022	15.2, 20.1.4, 20.1.10	Иргэн хоорондын	182/ШШ2022/00695
96	2022	13.1, 68.1	Иргэн хоорондын	157/ШШ2022/00019
97	2022	18.1	Н:Иргэн Х: ААТҮГ	184/ШШ2022/00760
98	2022	20.1.2, 20.1.10	Н:Иргэн Х: ТӨХК	102/ШШ2022/00639
99	2022	20.1.4	Н:Иргэн Х: АТҮТ	181/ШШ2022/00290
100	2022	6.2, 78.1	Н:Иргэн Х: ХХК	183/ШШ2022/00417
101	2022	20.1.2, 20.1.10	Н:Иргэн Х: ТӨХК	102/ШШ2022/00431
102	2022	67.2	Н:Иргэн Х: Коллеж	155/ШШ2022/00167
103	2022	20.1.2, 20.1.10	Н:Иргэн Х: ТӨХК	102/ШШ2022/00250
104	2022	20.1.2, 20.1.10	Н:Иргэн Х: ХК	102/ШШ2022/00180
105	2021	20.1.2, 20.1.10	Иргэн хоорондын	102/ШШ2022/00014
106	2021	9.1, 15.1, 91.1	Иргэн хоорондын	183/ШШ2021/03130
107	2021	77.1	Н:Иргэн Х: ХХК	182/ШШ2021/02865

108	2021	20.1.2, 20.1.10	Н:Иргэн Х: ТӨХК	102/ШШ2021/03451
109	2021	12.2, 66.1, 66.3, 66,5	Н:Иргэн Х: ТӨБЗГ, БХЯ	101/ШШ2021/04242
110	2021	20.1.2, 20.1.10	Н:Иргэн Х: ДЦС ТӨХК	102/ШШ2021/03279
111	2021	9.5, 11.9, 18.1	Н:Иргэн Х: ТӨБЗГ	183/ШШ2021/02861
112	2021	3.1	Иргэн хоорондын	133/ШШ2021/00538
113	2021	20.1.4, 20.1.10	Н:Иргэн Х: ТӨҮГ	184/ШШ2021/03194
114	2021	20.1.10	Иргэн хоорондын	142/ШШ2021/01132
115	2021	20.1.4, 20.1.10	Иргэн хоорондын	183/ШШ2021/02667
116	2021	11.9, 18.5, 20.1.4	Н:Иргэн Х: Э төв	183/ШШ2021/02379
117	2021	67.2	Н:Иргэн Х: Х төв	155/ШШ2021/00922
118	2021	20.1.10	Иргэн хоорондын	142/ШШ2021/00785
119	2021	15.1	Н:Иргэн Х: Х аймаг Хот тохижуулах газар	153/ШШ2021/00426
120	2021	11.1, 28.1	Н:Иргэн Х: ХХК	151/ШШ2021/00510
121	2021	18.1	Н:Иргэн	101/ШШ2021/01829

			Х: ТӨБЗТ	
122	2021	20.1.10	Иргэн хоорондын	142/ШШ2021/00544
123	2021	15.1	Иргэн хоорондын	153/ШШ2021/00307
124	2021	20.1.4, 20.1.10	Н:Иргэн Х: ЗТН	183/шш2021/01267
125	2021	60.1	Н:Иргэн Х: Х аймаг Хот тохижуулах газар	153/ШШ2021/00279
126	2021	67.2	Н:Иргэн Х: ... төв	155/ШШ2021/00603
127	2021	20.1.4, 20.1.10	Н:Иргэн Х: ЗТГ	181/ШШ2021/01040
128	2021	11.5, 11.6, 11.9, 21.6	Иргэн хоорондын	101/ШШ2021/01592
129	2021	13.1, 14.1,	Н:Иргэн Х: ХХК	Дугаар 183/ШШ2021/01116
130	2021	78.2.2,	Н:Иргэн Х: НЗДБУХЗИ	182/ШШ2021/01073
131	2021	29.1, 43.3, 45.1, 77.1	Н:Иргэн Х: Б аймаг ОНӨГ	131/ШШ2021/00243
132	2021	14.1	Иргэн хоорондын	132/ШШ2021/00178
133	2021	14.1	Иргэн хоорондын	132/ШШ2021/00162
134	2021	5.1, 15.1	Н:Иргэн Х: ХИС	153/ШШ2021/00164
135	2021	66.1, 67.1, 67.2, 72.1	Н:Иргэн	182/ШШ2021/00684

			Х: ТОСК ТӨХХК	
136	2021	6.1	Н:Иргэн Х: ХК	142/ШШ2021/00275
137	2021	20.1.4, 20.1.10	Иргэн хоорондын	142/ШШ2021/00254
138	2021	31.3.1, 20.1.4	Иргэн хоорондын	104/ШШ2021/00080
139	2021	20.1.10	Н:Иргэн Х: ИНҮТААТҮГ	183/ШШ2021/00327
140	2020	20.1.4	Иргэн хоорондын	101/ШШ2021/00029
141	2020	20.1.10	Н:Иргэн Х: ОСНААУГОНӨААТҮГ	182/ШШ2020/02885
142	2020	5.1, 11.8	Н:Иргэн Х: Э үйлдвэр ТӨҮГ	142/шш/2020/01271
143	2020	78.2	Н:Иргэн Х: БГД ЗДТГ	02794
144	2020	20.1.2, 20.1.4, 20.1.10	Н:Иргэн Х: ТӨХК	102/ШШ2020/02171
145	2020	20.1.4, 20.1.10	Н:Иргэн Х: АҮТ ТӨҮГ	181/ШШ2020/01828
146	2020	20.1.4	Н:Иргэн Х: ТБАГУТҮГ	01784
147	2020	6.4	Иргэн хоорондын	102/ШШ2020/02012
148	2020	77.1	Н:ХХК Х: НИТХ	182/ШШ2020/01239

149	2020	20.1.4, 20.1.10	Н:Иргэн Х: ОСНААУГ	182/ШШ2020/01088
150	2020	20.1.4, 20.1.10	Н:Иргэн Х: СЭХҮТ	1457
151	2020	20.1.4, 20.1.10	Н:Иргэн Х: С төв	102/ШШ2020/01454
152	2020	20.1, 20.4	Н:Иргэн Х: Г ТӨААТҮГ	184/ШШ2020/01513
153	2020	20.1.10	Н:Иргэн Х: Г ТӨҮГ	184/ШШ2020/01308
154	2020	29.1, 41.2, 42.6, 43.2, 43.4, 44.1, 44.2	Н:Иргэн Х: У аймаг ИТХ	330
155	2020	20.1.4, 20.1.10	Н:Иргэн Х: О газар	182/ШШ2020/00811
156	2020	20.1.10	Н:Иргэн Х: УСҮГ	988
157	2020	18.1	Н:Иргэн Х: ТӨБЗГ	101/ШШ2020/00883
158	2020	20.1.4	Н:Иргэн Х: ТӨХК	155/ШШ2020/00518
159	2020	20.1.4, 20.1.10	Иргэн хоорондын	181/ШШ2020/00364
160	2020	20.1.4	Н:Иргэн Х: ТӨХК	183/ШШ2020/0259

161	2020	20.1.4	Н:Иргэн Х: УТҮГ	183/ШШ2020/00251
162	2019	78.2.2	Н:Иргэн Х:ГАА ЗД	133/ШШ2020/00006
163	2019	14.2.1	Н:Иргэн Х:Санхүүгийн хяналт, аудитын алба	00619
164	2019	20.1.10	Н:Иргэн Х:ТӨҮГ	2557
165	2019	27.4, 30.1	Н:Иргэн Х:А ХХК	2692
166	2019	20.1.4, 20.1.10	Н:Иргэн Х: ОНӨААТҮГ	182/ШШ2019/02166
167	2019	20.1.1	Н:Иргэн Х: ЗТН	183/ШШ2019/02583
168	2019	20.1.4	Н:Иргэн Х: Алтны үйлдвэр	151/ШШ2019/01249
169	2019	20.1.4, 23.2.1	Н:Иргэн Х: ТӨХК	00968
170	2019	31.1, 77.2.3	Н:Иргэн Х: ХХҮГ	130/ШШ2019/00671
171	2019	5.1, 6.1, 27.1, 30.1	Н:Иргэн Х: ХХК	102/ШШ2019/03036
172	2019	20.1.4, 20.1.10	Иргэд хоорондын	181/ШШ2019/02113

173	2019	20.1.4	Н:Иргэн Х: СЭХҮТ	102/ШШ2019/02802
174	2019	66.4	Иргэд хоорондын	151/ШШ2019/00972
175	2019	15.2, 77.1, 78.1, 79.1	Н:Иргэн Х: Б аймаг ЗД	453
176	2019	19.1, 24.1	Иргэд хоорондын	1666
177	2019	61.1	Н:Иргэн Х: МОХНН УБТЗ	01178
178	2019	29.1	Н:Иргэн Х: ХХК	102/ШШ2019/01118
179	2019	3.1, 11.8, 30.2, 60.2	Н:Иргэн Х: Б УТҮГ	183/ШШ2019/00924
180	2019	20.1.4, 20.1.10	Иргэд хоорондын	817
181	2019	20.1.4	Н:Иргэн Х: ГОНӨААТҮГ	942
182	2019	15.1	Иргэд хоорондын	864
183	2019	20.1.4	Н:Иргэн Х: Г УТҮГ	0643
184	2019	6.3	Н:Иргэн Х: ХО нөхөрлөл	76
185	2019	20.1.4	Н:Иргэн Х: ТӨААТҮГ	184/ШШ2019/00636
186	2019	20.1.10	Н:Иргэн Х: ОНӨААТҮГ	183/ШШ2019/00146

187	2019	20.1.4, 20.1.10	Н:Иргэн Х: АҮТ ТӨҮГ	167
188	2019	15.3	Иргэд хоорондын	132
189	2018	9.1, 91.1	Н:Иргэн Х: ЭҮ ТӨҮГ	142/ШШ2018/01239
190	2018	11.4	Н:Иргэн Х: ТӨБЗГ	101/ШШ2018/03649
191	2018	14.2	Н:Иргэн Х: Б УТҮГ	2657
192	2018	13.1	Н:Иргэн Х: ХХК	1180
193	2018	9.2, 29.1	Н:Иргэн Х: ХХК	2336
194	2018	20.1.4, 20.1.10	Н:Иргэн Х: САТҮГ	181/ШШ2018/02313
195	2018	18.1, 21.6	Н:Иргэн Х: ТӨХК	183/ШШ2018/02379
196	2018	20.1.4, 20.1.10	Н:Иргэн Х: АТҮТ ТӨҮГ	2095
197	2018	20.1.4, 20.1.10	Н:Иргэн Х: ОНӨААТҮГ	182/ШШ2018/02023
198	2018	30.3	Н:Иргэн Х: ХХК	181/ШШ2018/01883
199	2018	20.1.10	Н:Иргэн	183/ШШ2018/02122

			Х: ОНӨААТҮГ	
200	2018	14.1	Иргэд хоорондын	135/ШШ2018/01011
201	2018	15.1, 18.1, 69.3	Н:Иргэн Х: ТӨААТҮГ	1731
202	2018	28.1, 28.3	Иргэд хоорондын	184/ШШ2018/02043
203	2018	20.1.4, 20.1.10	Н:Иргэн Х: АТҮТ ТӨҮГ	1722
204	2018	15.2	Иргэд хоорондын	183/ШШ2018/01902
205	2018	20.4.2, 20.5	Иргэд хоорондын	387
206	2018	11.6, 19.1	Н:Иргэн Х: ТӨБЗГ	2121
207	2018	28.1	Н:Иргэн Х: УТҮГ	1006
208	2018	4.3, 18.1, 75.2, 77.1	Н:Иргэн Х: ИТХ	155/ШШ2018/00911
209	2018	21.5	Н:Иргэн Х: ТӨХК	1099
210	2018	27.1	Н:Иргэн Х: ХХК	00454
211	2018	9.5, 15.1	Н:Иргэн Х: УТҮГ	183/ШШ2019/00660
212	2018	25.1	Н:Иргэн Х: Д аймаг ЗДТГ	37
213	2018	20.1.4, 20.6	Н:Иргэн	182/ШШ2018/00242

			Х: ТОСК ТӨҮГ	
214	2018	16.1	Н:Иргэн Х: НХОГ	00196
215	2018	4.1, 5.1.3, 30.2	Н:Иргэн Х: Э ХХК	222
216	2018	14.2	Н:Иргэн Х: УТҮГ	183/ШШ2018/00107
217	2017	29.1	Иргэд хоорондын	182/ШШ2017/02354
218	2017	18.5, 20.1.4	Н:Иргэн Х: МТҮП ТӨААТҮГ	181/ШШ2017/02937
219	2017	14.2.1	Н:Иргэн Х: НЗД	182/ШШ2017/02202
220	2017	18.5	Н:Иргэн Х: МТҮП ТӨҮГ	181/ШШ2017/02778
221	2017	34.1.2, 78.2.6	Н:Иргэн Х: Б аймаг ЗД	130/ШШ2017/00654
222	2017	15.2	Н:Иргэн Х: ОНӨААТҮГ	183/ШШ2017/02312
223	2017	15.2	Н:Иргэн Х: ЗТНО	2279
224	2017	20.1.4, 20.1.10	Н:Иргэн Х: ОНӨААТҮГ	1946
225	2017	20.1.4, 20.1.10	Н:Иргэн Х: ОНӨААТҮГ	183/ШШ2017/02121

226	2017	14.1, 14.2.1	Н:Иргэн Х: НЗД	182/ШШ2017/01781
227	2017	20.1.4	Н:Иргэн Х: МТҮП ТӨҮГ	181/ШШ2017/02362
228	2017	20.1.10	Н:Иргэн Х: ТӨҮГ	182/ШШ2017/01774
229	2017	20.1.4, 20.1.10	Иргэд хоорондын	182/ШШ2017/01765
230	2017	20.1.4	Иргэд хоорондын	278
231	2017	68.1	Н:Иргэн Х: Цэцэрлэг	279
232	2017	9.5, 15.3	Н:Иргэн Х: ХХҮЕГ	1259
233	2017	11.6, 21.3, 21.4.1	Н:Иргэн Х: ТӨБЗГ	2399
234	2017	20.1.4	Н:Иргэн Х: ААТҮГ	182/ШШ2017/01501
235	2017	8.1.4, 10.1, 11.8	Н:Иргэн Х: ТӨХК	103/ШШ2017/00290
236	2017	20.1.4	Н:Иргэн Х: ТӨААТҮГ	182/ШШ2017/01485
237	2017	20.1.4	Н:Иргэн Х: ДБҮЭГ	181/ШШ2017/01881
238	2017	31.1	Иргэд хоорондын	130/ШШ2017/00414
239	2017	18.5	Н:Иргэн	181/ШШ2017/01745

			Х: АТҮТ ТӨҮГ	
240	2017	20.1.4	Н:Иргэн Х: ДБҮЭГ ТӨҮГ	1655
241	2017	15.3	Иргэд хоорондын	1805
242	2017	20.1.4, 20.1.10	Н:Иргэн Х: АТҮТ ТӨҮГ	1353
243	2017	20.1.4, 20.1.10	Н:Иргэн Х: ТОСК	182/ШШ2017/01088
244	2017	20.1.4	Иргэд хоорондын	311
245	2017	28.1, 80.1	Иргэд хоорондын	102/ШШ2017/01092
246	2017	9.5	Н:Иргэн Х: ХХҮЕГ	00763
247	2017	14.4	Иргэд хоорондын	183/ШШ2017/00707
248	2017	20.1.4, 20.1.10	Н:Иргэн Х: ХНХСИ	693
249	2017	20.1.4	Иргэд хоорондын	181/ШШ2017/00816
250	2017	20.1.4	Н:Иргэн Х: ОНӨААТҮГ	577
251	2017	20.1.4	Н:Иргэн Х: ЭХХТ ТӨААТҮГ	183/ШШ2017/00537
252	2017	20.1.4	Иргэд хоорондын	184/ШШ2017/00501
253	2017	20.1.4	Иргэд хоорондын	081
254	2017	77.3	Иргэд хоорондын	104/ШШ2017/00050
255	2017	20.1.4	Иргэд хоорондын	182/ШШ2017/00294

256	2017	20.1.4, 20.1.10	Н:Иргэн Х: БХТ	265
257	2017	20.1.10	Н:Иргэн Х: Б ТӨААТҮГ	182/ШШ2017/00256
258	2017	77.1, 78.2.1	Н:Иргэн Х: 3 дүүрэг ЗДТГ	184/ШШ2017/00230
259	2017	5.1	Иргэд хоорондын	52
260	2016	11.3.6, 18.1	Н:Иргэн Х: МУСЯ	182/ШШ2016/01006
261	2016	18.1, 78.2	Н:Иргэн Х: Б аймаг ЗД	130/ШШ2016/00648
262	2016	20.1.4, 20.1.10	Н:Иргэн Х: ТӨҮГ	181/ШШ2016/01026
263	2016	9.5, 18.5	Иргэд хоорондын	181/ШШ2016/01008
264	2016	20.1.10	Н:Иргэн Х: ОНӨААТҮГ	6047
265	2016	74.1	Н:Иргэн Х: Б аймаг ШШГА	00507
266	2016	9.5, 18.5	Иргэд хоорондын	181/ШШ2016/00716
267	2016	9.5	Н:Иргэн Х: ТӨҮГ	700
268	2016	28.1	Н:Иргэн Х: Музей	146/ШШ2016/00238
269	2016	9.5, 20.1.4	Н:Иргэн	350

			Х: ТӨҮГ	
270	2016	20.1.10	Н:Иргэн Х: ТӨҮГ	0229